

ЯАГААД ҮГҮЙ ГЭЖ?



**FRIEDRICH
EBERT
STIFTUNG**

ХБНГУ-ын
Фридрих Эбертийн сан




**FRIEDRICH
EBERT
STIFTUNG**

ХБНГУ-ын
Фридрих Эбертийн сан



ЯАГААД ҮГҮЙ ГЭЖ?



Улаанбаатар хот
2010 он

DDC
323.34
Я-112



ЯАГААД ҮГҮЙ ГЭЖ?

Хянан тохиолдуулж, судалгааны тайлбар бичсэн:
Хэвлэлийн эхийг эмхтгэсэн:
Хэвлэлийн дизайнер:

Д.Алтай
Б.Халиун
С.Батцэцэг

Соёмбо хэвлэлийн газар хэвлэв.
Утас/факс: 976-11-325052

ISBN 978-99929-4-489-7

Одоогоос 5 жилийн өмнө 2005 оны намар ХБНГУ-ын Ф.Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр МАХН-ын дэргэдэх МАСЭХ-оос ийм нэртэй номыг хэвлүүлэн гаргаж билээ. “Яагаад үгүй гэж?” нэрлэсэн номоороо монголын улс төрд, бодлого боловсруулж шийдвэр гаргах түвшинд хүн ам, сонгогчдын 50 хувийг бүрдүүлдэг эмэгтэйчүүд төлөөлөл багатай, өөрсдийн дуу хоолойг гаргаж, зохих байр суурь эзэлж чадахгүй байгааг 2004 оны сонгуулийн үр дүн, МАХН-ын доторхи эмэгтэйчүүдийн байр сууринд хийсэн судалгаа, түүний бодит үр дүнгээр бид олон нийтэд харуулахыг хичээсэн юм. Энэ номын үргэлжлэл болох “Яагаад үгүй гэж?” II дахь цувралд бид 2008 оны бүх шатны сонгуулийн үр дүн, МАХН-ын дотоод бүтэц, УИХ, ЗГ, орон нутгийн удирдлагын бүх түвшин, Ерөнхийлөгчийн Тамгын Газар, УИХ-аас сонгогддог байгууллагын удирдах бүтэц Засгийн Газрын яам, агентлагт эмэгтэйчүүд удирдах албан тушаалд ямар төлөөлөлтэй байгаа, Үндсэн хуулийн Цэц, Дээд шүүх зэрэг шүүх засаглалын удирдах бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн байр сууринд ямар ахиц өөрчлөлт гарсныг судалгааны дүнд түшиглэн уншигч олон нийт, судлаачид, бодлого боловсруулагч нарт дахин толилуулж байна. Энэ судалгааг хийхэд анхдагч материал бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн МАСЭХ-ны 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн салбар зөвлөлийн удирдах ажилтан, идэвхитэн сонгуультан болон орон нутгийн МАХН-ын хороо, аймаг, дүүргийн төр засгийн байгууллагын ажилтнуудад гүн талархал илэрхийлье.



ХБНГУ-ын Ф.Эбертийн 1999 оноос эдүгээ хүртэл МАХН-ын дэргэдэх МАСЭХ-той хамтран шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн дунд болон урт хугацааны төслийг хэрэгжүүлж ирсэн. 2001 оноос АН-ын АЭХ, 2005 оноос УИХ-д суудалтай улс төрийн намуудын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарсан төслийг хэрэгжүүлж байна. Тухайлбал 2008-2009 онд “Сонгууль ба эмэгтэйчүүд” олон улсын чуулган зохион байгуулах, УИХ-д төлөөлөлтэй 3 нам - МАХН, АН, ИЗН-ын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын идэвхтэн сонгуультан болон аймаг нийслэлийн хуралд Иргэдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон эмэгтэйчүүдэд зориулан 14-28 хоногийн хугацаатай тусгай хөтөлбөрт сургалтыг Удирдлагын

Академид явуулах, Зуны Академи зохион байгуулах, МАСЭХ-оос 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа эмэгтэйчүүд МАХН-ын дотоод бүтэц, УИХ, орон нутгийн хурлууд, Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГазар болон шүүх засаглалын удирдах байгууллагад ямар төлөөлөлтэй байгааг судлан түүний үр дүнг тусгасан судалгааны ном гаргах, 2010 оны цаг тооны бичиг (эмэгтэйчүүдийн хуанли) хэвлүүлэх зэрэг олон төрлийн ажлыг төслийн хүрээнд хийсэн.

Монголын эмэгтэйчүүдийн нийгэм, улс төр дахь төлөөллийг нэмэгдүүлэхэд санаа тавьж, хамтарсан төсөл хэрэгжүүлж, бидний үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж байдаг ХБНГУ-ын Ф.Эбертийн сан, түүний Ази Номхон далайн газрын удирдлага, Монголыг хариуцсан зохицуулагч Р.Файхт /2004-2009 оны III сар/, Свен Шверсенски /2009 оны III сараас/ Монголын эмэгтэйчүүдийн дотны найз, зөвлөгч ХБНГУ-ын Бундестагийн гишүүн эрхэмсэг хатагтай Уте Кумф, Улаанбаатар дахь тус төслийн хариуцлагатай ажилтан, зохицуулагч Ч.Оюунгэрэл нарт чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

“Яагаад үгүй гэж?” цуврал номын II дахь хэсэгт монголын нийгэмд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, улс төр дахь тэдний оролцоог харуулахдаа уг номын нэгдэх ботид тусгагдсан агуулгын дэс дарааллыг хэвээр баримтлан шигтгээ болгон хавсралтыг хамтатган уншигчдад хүргэж байна.

Хэдийгээр УИХ-ын 2008 оны сонгуулийн үр дүнд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 3,9 хувь болон /2004 онд 6,5 хувь буюу 76 гишүүнээс 5 эмэгтэй байсан/ буурч 3 эмэгтэй сонгогдсон боловч Засгийн газрын танхим, гүйцэтгэх засаглалын удирдах түвшинд эмэгтэй төлөөлөл бага боловч нэмэгдэж ахиц дэвшил гарсан. Түүнчлэн 2008 оны УИХ-ын сонгуулиар хамгийн олон суудал /45 мандат/ авсан МАХН-ын дотоод бүтцэд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурьт ахиц гарсан хандлага ажиглагдаж байна. Үүнд нөлөөлсөн доорхи хүчин зүйл байна.

1. Гадаад хүчин зүйл буюу олон улсын хурал зөвлөлгөөнөөс гаргаж буй шийдвэрт жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих дэлхий нийтийн хандлага нөлөөлж байна. Тухайлбал МХЗорилт, Олон Улсын Парламентын Холбооны (ОУПХ) шийдвэр, түүний удирдлага үйл ажиллагаанд баримталж буй зарчим, Социнтерний гишүүн улс төрийн намууд эмэгтэйчүүдийн квотыг намын дүрэмд тусгаж буй байдал, Социнтерний эмэгтэйчүүдийн байгууллагын Зөвлөлийн хурлын тогтоол, НҮБ болон олон улсын бусад байгууллагын шийдвэр, конвенци, гэх мэт

2. Монголын нөлөө бүхий улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын шаардлага, шахалт. Тухайлбал МАСЭХ 2002 оноос МАХН-ын дүрэмд эмэгтэйчүүдийн квотыг тусгах тэмцэл

үр дүнд хүрч 2005 онд хуралдсан МАХН-ын XXIV Их Хурлаас намын дотоод бүтцэд бүх түвшний сонгогдох байгууллагад эмэгтэйчүүд нэр дэвшигчдийн 25 хувиас доошгүй байна гэсэн заалтыг дүрмэндээ тусгасан.

Түүнчлэн УИХ-д суудалтай улс төрийн намуудын /МАХН, АН, ИЗН, ЭОН/ дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага 2005 оны хавар “Улс төр ба засаглалд эмэгтэйчүүдийн түншлэл” Форумд нэгдэж “Их Тэнгэрийн Тунхаглал”-ыг батлан гаргасан явдал нь өөр өөр үзэл бодолтой намуудын хүүхнүүд нэгдмэл эрх ашигт хөтлөгдөн хамтарч ажиллахаа илэрхийлсний тод илрэл байлаа. Түүнчлэн бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувьд эмэгтэйчүүд байхыг улс төрийн намуудад үүрэг болгосон “Их Тэнгэрийн Тунхаглал”-ын үзэл санааг хэрэгжүүлэх зорилгоор 4 намын эмэгтэйчүүдийн байгууллагууд УИХ-ын сонгуулийн хуулийг батлах үеэр ухуулга-сурталчилгаа, нөлөөллийн ажлыг амжилттай хийсний үр дүнд 2005 оны 12 сард батлагдсан “УИХ-ын сонгуулийн тухай” хуульд “нам эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувьд эмэгтэйчүүд байна” гэсэг заалтыг оруулж чадсан юм. Харамсалтай нь энэ заалт амьдралд хэрэгжиж амжилгүй эрэгтэйчүүдийн улс төрийн орон зайгаа алдахаас айсан ухвар мөчид хүсэл эрмэлзэлд сарнин 2007 оны 12 сард дээрхи хуулиас хасагдсан. Намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагууд хамтран ажилласнаар эрх зүйн орчинд нааштай өөрчлөлт оруулахад нөлөөлсөн боловч нийгмийн сэтгэл зүй дахь уламжлалт хандлага, лидер эрэгтэйчүүдийн улс төрийн хүсэл зоригоос хамааран саад бэрхшээлтэй ийнхүү тулгарсан билээ. Гэвч энэхүү чармайлт нийгэмд, манлайлагч эмэгтэйчүүдэд хүчтэй нөлөөлж 2008 оны УИХ-ын сонгуульд олон эмэгтэйчүүд нэр дэвшин өрсөлдөж тэднийг дэмжих нийгмийн бааз өргөжиж буйг харуулсан. Дээрхи үйл явц нийгмийн болон шийдвэр гаргагчдын сэтгэл зүйд эмэгтэйчүүдийг дэмжихгүй бол болохгүй гэсэн бүүдгэр боловч хүсэл эрмэлзлийг бүрдүүлэхэд нөлөөлж байна.

УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 1992 оны түвшинд хүрч буурсан хэдий ч 2008 онд бүрдсэн хамтарсан Засгийн Газрын кабинетад 2 сайд, дэд сайдын түвшинд 4 эмэгтэй ажиллаж байгаа нь 1992 оноос хойшхи бүх Засгийн газруудын дээд амжилт болж байна.

Мөн эл номонд орсон судалгааны дүнг өмнөх сонгуулийн дүнд буюу 2005 онтой харьцуулахад эмэгтэйчүүдийн төлөөлөлд бага боловч ахиц дэвшил гарсныг тодорхой харж болно. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог ахиулахын төлөө тэмцэл шаргуу, байнгын байж, алхам алхмаар амжилтанд хүрэхийг бид мэдэрлээ. Тиймээс ч эмэгтэйчүүд бидний тэмцэл илүү зорилготой, илүү хүчтэй байх нь ирээдүйн амжилтын үндэс болно.

Яагаад эмэгтэйчүүдийн дуу хоолой бодлого боловсруулж шийдвэр гаргах түвшинд хангалтгүй хэвээр байх ёстой вэ? гэдэг асуултыг бид энэ удаа ч улс төрчид, уншигч сонгогчид та бүхэнд эргэцүүлэхийг хүсэн дахин тавьж байна.

“Яагаад үгүй гэж?” номын II дахь цувралд бид уламжлалт шигтгээ болон хавсралт хэсэгтээ танин мэдэхүйн шинж чанартай буюу шинэ мэдээллийг агуулсан материал, мэдээ, тайлан, тоо баримт статистикийг оруулсан. Мөн монголын эмэгтэйчүүдэд туршлага сургамж болох гадаад орны мэдээ мэдээлэл, дэлхийн эмэгтэйчүүд улс төрд ямар байр суурьтай байгааг харуулсан хүснэгт, диаграммыг ОУПХолбооноос авсан байдлаар орууллаа.

Энэхүү судалгааг нэгтгэн дүгнэж, хэвлэлд бэлтгэхэд МАСЭХ-ны гүйцэтгэх захирал Б.Халиун, дизайнер С.Батцэцэг нар чухал үүрэг гүйцэтгэснийг онцлон тэмдэглэж талархал илэрхийлье.

Та бүхэн энэ номны талаархи санал хүсэлтээ Монгол Улс, Улаанбаатар хот, шуудангийн хайрцаг 46/540 гэсэн хаягаар, эсвэл 976-11-321136 тоот факс, мөн E- mail: MDSWA94@yahoo.com хаягаар тус тус ирүүлнэ үү.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Номын редактор, судалгаанд тайлбар бичсэн:

МАСЭХ-ны Тэргүүн



Д.Алтай

УА-ийн проф.доктор /PhD/.

Яагаад үгүй гэж?


ÍÝÄ. ÍÈÈÒ Õ-í ÀìÄ ÝìÝÄÒÝÉ×--ÄÈÉÍ ÝÇËÝÕ
ÁÀÉÐ, ÑÓÓÐÛ

Манай орны нийт хүн амын 51.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Түүнчлэн хөдөлмөрийн насны хүн амын 51.5 хувь, нийт хөдөлмөр эрхэлж буй ажиллагсдын 50.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Энэ нь нийгмийн баялагаас эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил хүртэх, тухайлбал баялагийг хувиарлах, нийгмийн хөгжлийг хангахад тэгш эрхтэй оролцох боломжтойг харуулж байна. Эмэгтэйчүүд өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ улмаар улс орны хөгжилд ач холбогдол бүхий шийдвэрт нөлөөлж, өөрсдөө оролцох бодит боломж, нийгмийн шаардлагыг ч эндээс харж болох юм. Хүн амын тэн хагасын эрх ашиг, эрэлт хэрэгцээг тооцож үзээгүй, тэдний оролцоо алдагдсан бодлого нийгмийн хөгжлийг хангах тэгш эрхийн зарчимд харшилж, сөрөг үр дагаврыг бий болгодог байна.

№	Үзүүлэлт	Нийт хүн ам /мян/	Үүнээс эмэгтэйчүүд /мян/	хувь
1	Хүн ам	2683.5	1373.6	51.1
2	Хөдөлмөрийн насны хүн ам	1688.7	870.8	51.5
3	Нийт ажиллагсад	1041.7	529	50.7

Эх сурвалж: УСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл, УБ, 2008



Õçñíýàò 1

ÍÈÈÒ Õçí Àìûí
Áíëíí Àæëëàò
Õç÷íëé Áóíä
ÝìÝÄÒÝÉ÷ÇÄÈÉÍ
ÝÇËÝÕ ÕçâØëí
(Õóâëàð)

Äðàòèê. 1

ÍÈÈÒ Õçí Àìûí
Áíëíí Àæëëàò
Õç÷íëé Áóíä
ÝìÝÄÒÝÉ÷ÇÄÈÉÍ
ÝÇËÝÕ ÕçâØëí
(Õóâëàð)

Монгол Улсад эдийн засгийн өсөлт 2005-2008 онд дунджаар 8.7 хувьтай байж 2004-2007 онд нэг хүнд оногдох ДНБ 2 дахин өссөн. Сүүлийн 10 жилд 1 хүнд ногдох бодит орлого 2 дахин нэмэгдсэн. Гэхдээ ядуурлын түвшин буураагүй. Нэмэгдэж буй тэгш бус байдал нь ядуурлыг бууруулахад саад тотгор болж байна. Монголчуудын эдийн засгийн идэвх (64.2 хувь) дэлхийн дундажаас (65.7 хувь) доогуур, Зүүн Азийн орнуудынхаас (74.6 хувь) нилээн доогуур үзүүлэлттэй байна. Тэр дундаа монгол эрэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх (65 хувь) нь дэлхийн (79 хувь) болон бүсийн (81.5 хувь) үзүүлэлтээс доогуур байгаа нь гол шалтгаан болж байна.

Хөдөлмөрийн насны хүн амын 35.8 хувь нь эдийн засгийн идэвхгүй ба тэдний талаас илүү нь буюу 53.2 хувь эмэгтэйчүүд байна.

Хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй хүн амын 2/3 нь хөдөлмөрийн чадваргүй, тэдний дийлэнх нь эмэгтэйчүүд байна /53.5 хувь/. Хөдөлмөрийн насны тэтгэвэрт буй ажил хийдэггүй хүн амын 62.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Гол шалтгаан нь: эрт тэтгэвэрт гардаг, 4-өөс дээш хүүхэдтэй бол бүр эрт /50 настай/ гардаг, эмэгтэйчүүдийн 69 хувь нь гэр бүлд гүйцэтгэх үүргээс шалтгаалан ажил эрхэлж чаддаггүй, эмэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь «бусад» шалтгаан, «эсвэл тохирсон ажил олддоггүй» гэсэн шалтгаанаар ажил эрхлэхгүй буйг судалгаа харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтэд ажиллах хүчний хэрэгцээ өсч буй салбар нь уул уурхай, барилга, дэд бүтэц тул эрэгтэйчүүдэд ажлын байр олдох боломж илүүтэй байна.

ӨНӨӨ

“Эмэгтэйчүүд хөгжилд” хандлага	“Жендэр ба Хөгжил” хандлага
Дүн шинжилгээ: Эмэгтэйчүүд хөгжлийн бодлогын гадуур үлдэж байна. Эмэгтэйчүүдийн боловсролд хамрагдах, өөртөө итгэх байдал сул байна.	Дүн шинжилгээ: Нийгмийн бүтэц, үйл явц нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд хөрөнгө нөөц, боломж, шийдвэр гаргалтын тухайд тэгш бус байдал үүсгэж байна.
Асуудал: Эмэгтэйчүүд	Асуудал: Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш бус байдал
Хандлага: Эмэгтэйчүүд өөрчлөгдөж буй хөгжлийн үйл явцад идэвхитэй нэгдэн орох хэрэгтэй.	Хандлага: Тэгш сонголт, тэгш боломж бүрдүүлэхийн тулд нийгмийн бодлого, зан үйлийг өөрчлөх хэрэгтэй.

Яагаад үггүй гэж?

Харин хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаагүйгээс осол аваарийн 52 хувь, амь насаар хохирогчдын 72 хувь, гэмтэл бэртлийн 41 хувь, хохирогсдын 90 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь сэтгэл түгшээсэн баримт юм. Эмэгтэйчүүд голдуу эдийн засгийн өгөөж багатай салбарт төвлөрдөг тул цалингийн жөндөрийн зөрүүтэй байдал нэмэгдэж байна. Энэ зөрүү өмнө нь 9-10 хувь байсан бол 2008 онд 15.7-26 хувь болон өсчээ.

Хөдөлмөрийн зах зээлд ажил эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийн хувьд илүү өндөр байхад эмэгтэйчүүдийн хувьд ажлын байрны олдоц, хүртээмж нь хязгаарлагдмал байна. Гадаадад ажил эрхлэх болон давхар ажил эрхлэх боломж эрэгтэйчүүдэд илүүтэй байхад хагас өдрийн буюу хагас цалинтай ажил эмэгтэйчүүдэд илүү олдоцтой буюу ээлтэй байгаа аж.

Ø È Ñ Ò Ñ Ý Ý

İ î í ã î ë ó ě ñ á à ý ì ý ã ò ý é ÷ ç ä

Монгол Улс жендэрийн болон эмэгтэйчүүдийн асуудлаарх олон улсын хэд хэдэн гэрээ, конвенцид нэгдэн орсон юм. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай тунхаглал, 1994 онд Кайр хотноо болсон “Хүн ам ба хөгжил” бага хурал, 1995 онд Копенгагенд болсон Нийгмийн хөгжлийн асуудлаархи дээд хэмжээний уулзалт, түүнчлэн 1995 онд Бээжинд хуралдсан дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хуралд Монгол улс оролцож, холбогдох баримт бичгүүдэд гарын үсэг зурсан билээ.

Дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хурлаас баталсан үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь жендэрийн асуудлыг үндэсний, бүсийн болон олон улсын түвшинд судлан үзэж, бодлого хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал, тус хөтөлбөрт “Шийдвэр гаргахаасаа өмнө эрэгтэй, эмэгтэй хүмүүст үр нөлөө нь хэрхэн тусах талаар дүн шинжилгээ хийж байх үүднээс Засгийн газар болон бусад талууд бүх бодлого, хөтөлбөрт жендэрийн хүчин зүйлүүдийг тусгаж байх идэвхитэй, харагдахуйц бодлого явуулах хэрэгтэй” гэж заасан байна.

НҮБ-аас батлан гаргаж улс орнуудын хэрэгжүүлж буй Мянганы хөгжлийн найман зорилтын гуравдугаарх нь эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулах, жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлэх явдал юм. Иймд жендэрийн үзэл баримтлалыг харгалзан үзэж шийдвэрлэх нь сайн дурын асуудал төдий бус, харин олон улсын түвшинд хүлээсэн үүрэг юм.

/Эх сурвалж: Жендэрийн стратеги. УБ.2006 он. 6-р хүүдас/

Ажилгүйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өссөөр байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 56.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь улсын дунджаас 14 хувиар, эрэгтэйчүүдийнхээс 25 хувиар илүү байна. Дээд боловсролтой хүмүүсийн ажилгүйдэл 16 хувиар өссөн байхад бусад түвшингийн хувьд ажилгүйдэл түүштай буурч байна.

Ижил түвшингийн ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс доогуур цалин авч байна. Тухайлбал менежер эмэгтэй менежер эрэгтэйгээс 21 хувиар, мэргэжилтэн 19 хувиар, инженер 30 хувиар тус тус доогуур цалин авч байна.

ӨНӨӨД

Үддэ гэдэг үйлдвэрлэлд ажилд ажилд

- 1996 онд Монгол Улсын Засгийн газраас Бээжингийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн. 2002 он хүртэл үргэлжилсэн тус хөтөлбөр нь нийгмийн хөгжилд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог хангахад нөлөөлжээ.

- 2002 оны 10 дугаар сард Жендэрийн тэгш байдлын талаарх үндэсний чуулган хуралдаж, Жендэрийн тэгш байдлын асуудлаарх үндэсний хөтөлбөрийн төслийг хэлэлцэн дэмжсэн байна. Улмаар Монгол улсын Засгийн газар 2002 оны 12 дугаар сард уг хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж эхлээд байна. Үндэсний хөтөлбөрт Жендэрийн хөгжлийн индекс Монгол улсад 0,653 байгааг хөтөлбөрийн хэрэгжиж дуусах үед буюу 2015 он гэхэд 0,690 болгохоор заажээ.

- 2005 онд Хүйсийн тэгш байдлын асуудлаарх үндэсний зөвлөл нь Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо болон түүнийг Монгол улсын ерөнхий сайд даргалан ажиллаж байна.

- Монгол улсын Засгийн газраас явуулж буй төрийн захиргааны ба төрийн албаны шинэтгэл нь жендэрийн үзэл баримтлал нь яамдын бодлого төлөвлөлтөнд тусгахад нэгэн нааштай хүчин зүйл болж байна. Тухайлбал, 2002 оны 6 дугаар сард батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 4-р зүйлд төрийн албанд баримтлах зарчмын тухай 4.2.4 хэсэгт “иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх” гэж заажээ. Мөн тус хуулийн 16.1 буюу төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол гэсэн хэсэгт “төрийн тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, болон нам, олон нийтийн бусад байгууллагын харъяалал зэргээр ялгаварлаж үл болно” гэж заажээ.

/Эх сурвалж: Жендэрийн стратеги. УБ.2006 он. 7-10-р хуудас/

Эмэгтэйчүүдийн цаг, хүч, хөдөлмөрийн шаардлага хэрэгцээ огт буурсангүй. Эмэгтэйчүүдийн ажлын өдөр эрэгтэйчүүдийнхээс 10 хувиар урт, нийт хөлсгүй хөдөлмөрийн 70 хувийг тэд гүйцэтгэдэг. Үүнд өрх гэрийн гишүүдэд үзүүлэх халамж үйлчилгээ, асаргаа хамаарна. Харин эрэгтэйчүүдийн ажлын өдрийн 70 хувийг хөлстэй хөдөлмөр эзэлж байна. Эмэгтэйчүүд өрх гэр бүлдээ өдөр бүр 2.2-3.0 цаг илүү зарцуулдаг байдал хэвээр байна. Хөдөлмөрийн зах зээлд хүйсээр ялгаварлан гадуурхах явдал байсаар байна.

Тухайлбал: Ажилд авах болон халахад, мэргэжлээрээ өсөх, албан тушаал ахихад ялгаварлал байна. Түүнчлэн хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал төдийлөн сайн биш байгаа нь эмэгтэйчүүдэд ажиллах тааламжтай нөхцөл болж чадахгүй байна.

ӨНӨН

- 2002 онд батлагдсан Төсвийн байгууллагуудын удирдлага, санхүүжилтийн хуульд улсын төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах, төсвийн талаарх төрийн байгууллага, албан тушаалтны эрх үүргийг тодорхойлохын хамт төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлогыг хөндсөн заалтуудыг тусгасан байна. Эдгээр хуулиудад төрийн албан хаагчийг зөвхөн мэдлэг, боловсрол, мэргэжил туршлага, мэргэжлийн ур чадвараар нь нээлттэй өрсөлдөөний зарчмаар томилох зэрэг тулгуур зарчмыг бататгасан бөгөөд харин эмэгтэй, эрэгтэй хүмүүс гэж онцолж дурдаагүй байна.

- Зарим төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа хүрээнд жендэрийн болон эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар мэргэжиж, туршлага хуримтлуулж байна.

- Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг. Монгол улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн нэг хэсэг нь ядуурлыг бууруулах, хүн амын тогтвортой амжиргааг хангах явдал билээ.

Энэ хүрээнд хувийн дэвшилд суурилсан, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогыг дэлхийн нийтийн хөгжлийн зорилттой нийцүүлэн, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн бүрэн хэмжээний баримт бичгийг боловсруулан ажиллаж байна. Энэхүү баримт бичиг нь жендэрийн тэгш байдлыг хангаснаар эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулахад хүрэх зорилт бүхий бодлогын баримт бичиг юм. Тус баримт бичгийн жендэрийн асуудлыг Дэлхийн банкнаас сайшаан үзсэн байна.

/Эх сурвалж: Жендэрийн стратеги. УБ.2006 он. 7-10-р хуудас/

НҮБ-ын Хүний хөгжлийн 2007/2008 оны илтгэлд дурдсан чансаагаар Монгол улс хүнийг хөгжлийн индексээр /ХХИ/ 177 орноос 114-т, жендэр хөгжлийн индексээр /ЖХИ/ 177 улсаас 100-д, Жендэрийн тэгш боломжийн хэмжүүрээр 93 орноос 77-д орсон байна. Хүний хөгжлийн индекс нь үрт удаан, эрүүл саруул амьдрах /дундаж наслалтаар хэмжигдэх/, боловсролын түвшин /насанд хүрэгсэдийн бичиг үсгийн мэдлэг, анхан дүнд, дээд шатны сургуульд элсэлтийн нийлмэл үзүүлэлтээр хэмжигдэх/, амьдралын зохистой түвшин /валютын худалдан авах чадавхийн паритет буюу PPP орлогоор илэрхийлэгдэж/ гэсэн хүний хөгжлийн 3 гол хэмжигдэхүүний нийлмэл үзүүлэлт юм. 1995 оны хүний хөгжлийн илтгэлээс эхлэн ЖХИ-индексийг ХХИ-ийг тооцсон үзүүлэлтүүдийг эрэгтэй, эмэгтэйгээр буюу хүйсээр тооцож тэгш бус байдал хэрхэн ямар түвшинд байгааг хэмжиж эхэлсэн.

ӨНӨН

Мянганы хөгжлийн зорилтууд. Олон улсын хамтын нийгэмлэгээс дэмжсэн Мянганы хөгжлийн зорилтуудыг Монгол улс талархан хүлээн авч, түүнийг өөрийн орны нөхцөлтэй уялдуулан 2015 он хүртэлх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. МХЗ-уудын 8 зорилтын 3 дахь зорилтод “Жендэрийн тэгш байдлыг сайжруулж, эмэгтэйчүүдийн үүрэг, ролийг нэмэгдүүлэх” асуудлыг дэвшүүлэн тавьжээ.

/Эх сурвалж: Жендэрийн стратеги. УБ.2006 он. 7-10-р хуудас/

2005-2008 онуудад сургууль завсардалт ялимгүй багасч, ерөнхий боловсролын сургуульд суралцагсадын дүнд хөвгүүд охидын сургууль завсардалтын жендэрийн зөрүү 1.2-1.03 болж буурсан, их дээд сургуульд суралцагсдын эрэгтэй, эмэгтэй оюутны жендэрийн зөрүү 1.72-1.53 болж багассан. 2000 онд 97.7 хувьтай байсан бичиг үсэг тайлагдалт буурах хандлагатай байна. Жишээ нь: 15-24 насны залуучуудын дүнд бичиг үсэг үл мэдэх явдал 2 хувиар буурч, тэдний 63 хувь нь эрэгтэй байна гэсэн судалгаа гарчээ.

Сургуулийн өмнөх байгууллагын тоо 10 хувь, тэнд ажиллах багш нарын тоо 16 хувь, түүнд хамрагдах бага насны хүүхдүүд 21 хувиар түс түс нэмэгджээ. Энэ нь гэрийн эзэгтэй, залуу ээж нарын хувьд ажил, сургуулиа орхин гэртээ бага насны хүүхдээ харах явдлыг бага боловч багасгахад нөлөөлсөн талтай.

Яагаад үгүй гэж?


Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга, заах аргад жендэрийн мэдрэмжтэй өөрчлөлт шинэчлэл бараг хийгдээгүй, жендэрийн тухай орчин үеийн ойлголтыг эзэмшүүлэх явдал хангалтгүй байна.

Боловсролын салбарт ажиллагсадын дунд нэг хүйс (эмэгтэй) хэт давамгайлах хандлагатай, үүний сөрөг үр дагавар сургалтанд нөлөөлдөг, салбарын менежмент сул, нийгмийн эрэлт хэрэгцээ бодит салбарын өсөлттэй холбоотойгоор захиалгат сургалтыг зохион явуулах, түүнд суралцагсадын жендэрийн харьцааг зөв тусгах явдал хангалтгүй зэрэг хүчин зүйлүүд хадгалагдсан хэвээр байна.

Их дээд сургуульд суралцагч оюутны 2/3 хувь нь хумигдаж байгаа буюу эрэлт хэрэгцээ нь буурч буй боловсрол (багш), эрүүл мэнд (эмч), нийгмийн ухааны чиглэлээр суралцаж байгаа ба тэдний 68 хувийг нь охидүүд эзэлж байна. Харин өсөн тэлж байгаа салбарууд буюу технологи, үйлчилгээний чиглэлээр нийт суралцагсадын 22 хувь нь сурч, тэдний 87 хувийг нь хөвгүүд эзэлж байна.

№	Үзүүлэлт	Хувь
1	Арван жил, бага, дунд сургуулийн сурагчид	50.8
2	Их, дээд сургуулийн оюутнууд	60.7
3	Бакалаврын зэргийн оюутнууд	59.8
4	Мастерийн зэрэг олгох түвшний оюутнууд	64.4

Эх сурвалж: www.mecs.gov.mn



Öḡñíýàò. 2

Ýìýàòýé÷ḂḂä
áîēîâñðîē
ýḡýì øñýí
áàēäàē

(ḡóâēàḡ)

Äðàòèè. 2

Ýìýàòýé÷ḂḂä
áîēîâñðîē
ýḡýì øñýí
áàēäàē

(ḡóâēàḡ)

2005-2008 онуудад эдийн засгийн өсөлттэй холбоотой цалин, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж нэмэгдсэн. Мөн улс төрийн намуудын УИХ-ын сонгуульд оролцохдоо сонгогчдод өгсөн амлалт ч халамжийг нэмэгдүүлэх бас нэг шалтгаан болсныг хэлэх хэрэгтэй.

Нийгмийн халамжийн нэр төрөл нэмэгдсэн нь орлогын ядуурлыг хязгаарлахад зохих нөлөө үзүүлж байна. Гэхдээ нийслэл, хот суурин газарт шилжин ирэгсэд олон байж тэд бүртгэлд хамрагдаагүйгээс шалтгаалан нийгмийн халамж хүртэж чадахгүй байгаа явдал хэсэг бүлэг хүмүүст байсаар байна. Тухайлбал орон гэргүй хүмүүс, гудамжны хараа хяналтгүй хүүхдүүд, шилжин суурьшигчид гэх мэт. Мөн зориуд орлогоо нуун дарагдуулж «ядуу» хүмүүсийн ангилалд «санаатайгаар» бүртгүүлж халамж хүртдэг хүмүүс ч байна. Нийгмийн даатгалд хөдөлмөрийн насны хүн амын 2/3 нь хамрагддаг. Нийгмийн хамгаалалд хамрагдагсадын мэдээ статистик хүйсээр нарийн ангилж гардаггүй. Эмэгтэйчүүдийн тэтгэвэр доогуур тогтоогддог.

2007-2008 оны өрхийн орлого зарлагын нэгдсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн өрхийн ядуурал 34.7 хувь, эрэгтэйчүүдийн өрхийнх 35.3 хувьтай гэж гарчээ.

Өмнө нь 2002-2003 онд хийгдсэн ийм төрлийн судалгаагаар эмэгтэйчүүдийн өрхийн ядуурал 41.6 хувьтай байсан нь буурч, харин эрэгтэй өрхийнх 27.9 хувьтай байсан нь эсрэгээр нэмэгдсэн байна.

Хотод амьдардаг эмэгтэй тэргүүтэй өрхийн ядуурал 30.6 хувь, эрэгтэй тэргүүтэй өрхийн ядуурлаас (25.8 хувь) өндөр хувьтай гарсан байна.

Яагаад үгүй гэж?

2008 оны УИХ-ын сонгуульд парламентад суудалтай 4 намаас тухайлбал МАХН-аас 76 мандатад 10 эмэгтэй, АН-аас 13 эмэгтэй, ИЗН-аас 6 эмэгтэй, Эх орон намаас 2 эмэгтэй тус тус нэр дэвшсэн боловч сонгогдсон нь 3 эмэгтэй (2 нь МАХН, 1 нь ИЗН) байгаа юм. Тиймээс сонгогчдын улс төрийн боловсрол ялангуяа эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих мэдрэмж ойлголтыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор дэвшигдэж байна. Үүнд иргэний боловсрол чухал үүрэгтэй юм.

Иргэний боловсрол нь ихээхэн өргөн хүрээтэй, олон талыг хамарсан нийгмийн бодлогын төвд байх асуудал юм. Энгийнээр хэлбэл,

- Нийгмийн амьдралын аливаа асуудалд зөв сонголт хийх иргэний улс төрийн боловсрол,

- Эрүүл аж төрөх ёсонд суралцах иргэний эрүүл мэндийн боловсрол,

- Өөртөө болон бусдад сэтгэл хангалуун амьдрах нөхцлийг хангах ёс зүйн боловсролыг энд хамааруулж болно.

Иргэний улс төрийн боловсрол иргэн ба төрд яагаад чухал вэ?

Иргэдийн улс төрийн боловсрол өндөр байвал:

- Төрөө зөв бүрдүүлж чадна. Учир нь ардчилсан нийгэмд төрийн эрх мэдэл ард түмний гарт байдаг. Сонгуулиар энэ эрхээ эдэлж, төрийг төвхнүүлэх гарааны нөхцлийг хангадаг.
- Төрийн бодлого үйл ажиллагаанд идэвхитэй оролцож чадна. Төрийн эрх мэдэл ард түмнээс эхтэй шигээ бодлого, үйл ажиллагаа нь мөн тэднээс эхлэдэг байх ёстой. Иргэд нь эрх ашгаа илэрхийлэн төрийн хэрэгт оролцохын тулд иргэний болон улс төрийн зохих төвшний боловсрол мэдлэгтэй байх ёстой. Үүнд төр тусалдаг, боловсрол, мэдээлэл, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг байх учиртай.
- Төр, түүний албан тушаалтанд болон үйл ажиллагаанд хяналт тавьж чадна. Төрийн албан тушаалтан бол иргэдийн сонголтоор хязгаарлагдмал эрх мэдэлтэй болж хуулиар үүрэг хүлээсэн иргэн. Тийм учраас тэднийг иргэд хянаж чаддаг байх ёстой. Иргэд нийтийн эрх ашгийн төлөө төрийг, түүний байгууллага, албан тушаалтнуудыг хянаж чадаж байвал ардчилал чанартай, төр хариуцлагатай байж чаддаг.
- Төр, түүний байгууллага, албан тушаалтнуудтай хариуцлага тооцож чадна. Учир нь төрийн байгууллага, албан тушаалтнууд иргэдэд тайлагнадаг, тэдэнтэй хариуцлага тооцдог байх ёстой. Иргэний болон улс төрийн боловсрол өндөр байвал төрийн байгууллага, албан тушаалтнууд хүссэн хүсээгүй тэдэнд тайлагнаж, тэдний өмнө хариуцлага тооцох болно.

Иргэний улс төрийн боловсрол гэж юу вэ?

Иргэний улс төрийн боловсролын гол агуулгад юуны өмнө:

- Улс төрийн тухай мэдлэг, ойлголт,
- Ардчилалын тухай мэдлэг, ойлголт
- Төрийн бодлого, үйл ажиллагааны талаархи мэдлэг, мэдээлэл
- Хууль цааз, эрх зүйн мэдлэг багтана.

ӨНӨӨ

2006 оны байдлаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан ёсоор бүртгэгдсэн ТББ-ын тоо 6000 орчим болсон байна. 1990-ээд оноос хойш Монгол Улсад төрийн бус байгууллагууд иргэний боловсролын албан бус сургалтын чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2003 оны байдлаар хүний эрх, иргэний нийгэм, ардчилалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд нийт 63 байна. Эдгээр байгууллагуудын олонхи нь хүний эрхийг хамгаалах, ардчилалыг бэхжүүлэх, ардчилсан нийгэмд мэдлэгтэй, хариуцлагатай, идэвхитэй иргэдийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах гэсэн зорилтыг өөрийн үйл ажиллагааны эрхэм зорилго болгон ажиллаж байна.

ТББ-уудын үйл ажиллагааных нь хүрээ өргөссөнтэй холбоотой арга хэрэгсэл нь ч гэсэн нарийсаж байна. Үүнд тухайлбал:

- Нөлөөлөл үзүүлэх компанит ажил
- Төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцоход мониторинг
- Стратегийн өмгөөлөл
- Төрийн байгууллагын дэргэдэх хяналтын болон зөвлөх хороодоор дамжуулж төртэй хамтран ажиллах

/Эх сурвалж: доктор, профессор Г.Чулуунбаатар “Иргэний улс төрийн боловсрол төрийн хөгжилд нөлөөлөх нь” илтгэлээс/, “Иргэний нийгэм, иргэний боловсрол чуулган”, 2007, УБ

Иргэний боловсролыг дээшлүүлэхийн тулд цаашид яавал зохистой вэ?

- Албан боловсролын тогтолцоогоор дамжуулан олгох улс төрийн боловсролыг сайжруулах
- Иргэний боловсролыг дээшлүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Иргэний боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн эхлэл, санаачлагыг төрөөс бодлого, төсөв санхүүгээр дэмжих

Иргэний нийгмийг төрөөс дэмжих бодлого

ДЕМО буюу Ардчилалын Боловсрол Төв нь 2005-2006 онд “Монгол дахь ТББ-уудын дүр зураг” хэмээх тоон үзүүлэлтийн судалгааг Хууль зүй дотоод хэргийн яам, Үндэсний татварын ерөнхий газар болон Дүүргийн татварын албадуудаас авсан мэдээлэл дээр үндэслэн хийсэн билээ.

- 2005 оны 09-р сарын 01-ны байдлаар Хууль зүй дотоод хэргийн яаманд 5.077 ТББ бүртгэгдсэн байна.
- 1997-2004 оны байдлаар ХЗДХЯ-нд бүртгүүлсэн ТББ-уудын тоог авч үзвэл, жилд дунджаар 560 ТББ үүсгэн байгуулагдсан байна.
- Нийт ТББ-уудын 77 хувь нь УБ хотод байрладаг бол 23 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж байна.
- ТББ-ууд 2002-2004 онд улсын төсөвт нийт 2.851.5 сая төгрөгийн татвар төлсөн байна.
- ТББ-ын 42 хувь нь 1-2 ажиллагчидтай, 26 хувь нь 3-5.12 хувь нь 6-9.14 хувь нь 10-20.6 хувь нь 21 ба түүнээс дээш ажиллагчидтай байна.
- ТББ-ыг ажил үйлчилгээний орлогын хэмжээгээр бүлэглэж үзвэл зөвхөн 2005 оны байдлаар гэхэд 51 хувь нь 500 мянга хүртэл төгрөгний орлоготой, 4 хувь нь 500 мян-1.0 сая төгрөг, 27 хувь нь 1.0-10.0 сая, 15 хувь нь 10.0-100.0 сая, 3 хувь нь 100.0 саяас дээш төгрөгний орлоготой ТББ-ууд байна.
- 2005 онд гүйцэтгэсэн ажил үйлчилгээнээс ТББ-ууд 45.3 тэрбум төгрөгний орлого олж, 8.3 тэрбум төгрөгийг ажиллагчдынхаа цалинд олгосон байна.
- 2005 онд ТББ-ууд 34.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 29.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.
- ТББ-ын санхүүжилтыг эх үүсвэрээр нь авч үзвэл 18.6 тэрбум төгрөг буюу 53.9 хувь нь олон улсын байгууллагын төслийн санхүүжилт, 3.5 тэрбум төгрөг буюу 10.2 хувь нь хандив, 2.8 тэрбум төгрөг буюу 8.0 хувь нь гишүүний татвар, 9.6 тэрбум төгрөг буюу 27.9 хувь нь бусад төрлийн санхүүжилт байна.
- ТББ-ын хөрөнгийн зарцуулалтыг /2005 он/ зардлын төрлөөр нь авч үзвэл 6 тэрбум төгрөг буюу 20 хувийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагаанд, 4.5 тэрбум төгрөг буюу 15 хувийг бусад олгосон хандив тусламжинд, 3.4 тэрбум төгрөг буюу 11.2 хувийг сургалт семинар зохион байгуулахад, 0.4 тэрбум төгрөг буюу 1.3 хувийг сурталчилгааны зардалд, 15.8 тэрбум төгрөг буюу 52.8 хувийг бусад зардалд зарцуулсан байна.
- 2001-2005 онуудад төрийн сангаас 156.6 сая төгрөгийн тэтгэлгийг 17 ТББ хүртэж үйл ажиллагаагаа санхүүжүүлсэн байна.

Иргэдийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлсэн иргэний нийгмийн байгууллагууд МУ-ын нийгэм, эдийн засагт зохих хувь нэмрээ оруулж байгаа боловч иргэний нийгмийн байгууллагуудыг төрөөс

дэмжих бодлого байхгүй, иргэний нийгмийн байгууллагуудын төртэй шууд харьцах төлөөллийн альтернатив механизм байхгүй, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах механизмууд алга байна.

1. “Иргэний нийгмийн үзэл баримтлал” хэмээх баримт бичгийг боловсруулж УИХ-аар батлуулах.
 - Иргэний нийгмийн үзэл баримтлалын зорилго нь төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, иргэний нийгмийг хөгжүүлэх, оролцооны ардчилалыг төлөвшүүлэх, шийдвэр гаргах явцад иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах зэрэг гүйцэтгэх харилцан бие биенийгээ нөхөн дэмжсэн үүрэг, функцийг тодорхойлоход оршино.
 - Энэхүү баримт бичгийг боловсруулах төр, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах.
 - Төр болон иргэний нийгмийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг тодорхойлох, түншлэлийн бүтцийг бий болгох, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах.
2. ТББ-ын хөгжлийг дэмжих бодлогын үйл явц дахь оролцоог хангахад чиглэсэн дараах төр-иргэний нийгмийн нэгжүүдийг байгуулах.
 - Ерөнхий сайдыналбаны дэргэд иргэний нийгмийн байгууллагуудын асуудал эрхэлсэн Зөвлөл байгуулах. Энэ Зөвлөлийн нэг үүрэг нь Засгийн газраас гаргах хууль тогтоомжийн төсөлд санал өгдөг байх.
 - Засгийн газрын харъяа нэгжүүдийн дэргэд Иргэний нийгмийн зөвлөх нэгжийг иргэний нийгмийн өргөн төлөөллөөс бүрдүүлэн ажиллуулах.
 - Тус нэгж нь ТББ-ын салбарын асуудлыг хариуцан ажиллах бодлогын үйл явцад оролцоход зуучлах, дэмжих, холбох үүрэг бүхий институци байх юм.
 - ТББ-ын асуудал эрхэлсэн Парламентын бүлэг байгуулах. Тус бүлгийг УИХ-ын дарга толгойлох бөгөөд гол зорилго нь ТББ-уудын эрх ашгийг хууль эрх зүйн актаар хамгаалуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.
3. Төрөөс ТББ-уудыг санхүүжүүлэх механизмыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах.
 - 1 хувийн татварыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд хөндлөнгийн заалт болгон оруулж хуульчлах.
 - 1 хувийн татварын хувиарлагдаагүй хөрөнгөөр “Иргэний нийгмийн сан” хэмээх төрийн төвлөрсөн сан байгуулах асуудлыг хуульчилж ТББ-ын санхүүгийн дэмжлэгийн шинэ эх үүсвэрийг бий болгох.

Яагаад үгүй гэж?

- ТББ-ыг дэмжих үндэсний ивээн тэтгэгчдийг бий болгох зорилгоор “хуулийн этгээдийн орлогын албан татварын тухай хууль”-д нийгэмд үйлчилдэг ТББ-ууд бусад хуулийн этгээдээс өргөсөн хандив, өвлүүлсэн хөрөнгөнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх заалтуудыг сэргээн оруулж хувьчлах.

Иргэний нийгэмд ТББ-уудын гүйцэтгэх үүрэг

Манай улсын нөхцөлд ТББ үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхдээ 3 асуудалд анхааран ажиллах хэрэгтэй санагдаж байна. Эдгээр нь тогтвортой байдал, хамтын ажиллагаа, хариуцлага юм.

Тогтвортой байдал гэдэг нь төрийн бус байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүхий л хүрээг хамарна. Үүнд удирдлага, ажилтны тогтвортой байдал, санхүүжилт, хамтран ажиллагчид, санхүүжүүлэгчид, ард иргэдтэй тогтвортой харилцаагаа хөгжүүлэх гэх мэт. Энэ бүхнийг тогтвортой байлгаж чадвал дэвшүүлсэн асуудал дээрээ тогтвортой ажиллаж дээр дурдсан хууль эрх зүй, бүтэц механизм, үйл явцын хүрээнд асуудлаа шийдвэрлэж зорилгодоо хүрнэ. Үнэндээ хөгжлийн эхэнд ч хөгжих, дэвших явцад ч байгууллагын тогтвортой байдлыг хангана гэдэг нь амаргүй асуудал байдаг. Ийм учраас олон ТББ-ууд өнөөдөр тогтвортой үйл ажиллагаагаа хангаж чадахгүй байна.

Хамтын ажиллагаа: Ажиллах асуудал олон, тогтворгүй үйл ажиллагаа явуулдаг ТББ цөөн болохоор тодорхой нэг асуудал дээр ажилладаг ТББ-ууд цөөн байдаг. Гэхдээ л цөөн боловч хамтран ажиллавал илүү үр дүнд хүрнэ гэдгийг ойлгон сүлжээ, эвсэл байгуулан хамтран ажиллаж зарим амжилттай алхмуудыг хийж эхэлж байна. Харамсалтай нь энэ нь хангалтгүй байна. Төрийн бус байгууллагууд хэрхэн үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар бодож, бүтээлч санаачлага өрнүүлэх хэрэгцээ шаардлага байгааг ойлгож аль болох түргэн энэ алхмыг хийнэ төдий чинээ бидний ажил урагшилж монголын нийгэм хожно гэдгийг ухамсарлан ажил болгох хэрэгтэй байна.

Хариуцлага: ТББ-д бүгдтэй хариуцлага тооцохыг зарчим болгодог. Ёс зүйтэй ажиллахыг шаарддаг. Энэ нь ТББ-ын нийгэмд хүлээсэн үүрэг. Гэхдээ ТББ өөрөө ч бас хариуцлагатай ажиллах ёстой. Бид хамгийн түрүүнд эрх ашгийг нь хамгаалж байгаа ард иргэд, дараа нь хамтран ажилладаг талууд, санхүүжүүлэгч гээд олон талын өмнө хариуцлага хүлээдэг. Бид ёс зүй, санхүү гээд олон чиглэлээр хариуцлага сайн ухамсарлаж үүргээ биелүүлэх шаардлагатай. Учир нь бидний хариуцлагатай үйл ажиллагаанаас үр дүн хамаардаг.

*Ардчилалын боловсрол төвийн захирал Г.Ундралын илтгэлээс
“Иргэний нийгэм, иргэний боловсрол чуулган”, 2007, УБ*

ӨИ-д. ОАЕДААО АИЕИИ ОЕЕААҮӨ ААДААО
 Ò-АӨЕИ АҮӨ ҮИҮАӨҮЕ×-АЕЕИ ИДИЕОИИ

Улсын Их Хурлын гишүүдийн 3.9 хувь, Засгийн газрын гишүүдийн 6 хувь, Төрийн нарийн бичгийн дарга нарын 0 хувь, яамдын газар, хэлтсийн дарга нарын 26.5 хувь нь эмэгтэйчүүд байна. 1995 оны НҮБ-ын дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дэх чуулга уулзалтаас дэвшүүлсэн эмэгтэйчүүд, үндэсний шийдвэр гаргах түвшинд 30 хүртэл хувь байх зорилтоос ухарсан хэрэг юм.

1990 оны парламентын нийт гишүүдийн 23 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 1992 оны сонгуулиар 3.9 хувь болтлоо буурч, 1996 оны сонгуулиар 11 хувь, 2000 оны байдлаар хууль тогтоогчдын 12 хувь нь эмэгтэйчүүд байсан ба Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, дэд сайд нэг нэг эмэгтэй ажиллаж байжээ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороог тухайн үедээ тэргүүлж байжээ.

2004 онд УИХ-д 11.9 хувь

2008 онд УИХ-д 3.9 хувь, Засгийн газарт 6.6 хувь (3 эмэгтэй сайд)

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо ийнхүү буурч байгаа нь нийгэм, эдийн засгийн чиглэлээр хөгжлийн олон асуудлыг шийдэхэд жендэрийн тэгш байдал алдагдахад нөлөөлж байна.

2008 оны сонгуулийн дараа хамтарсан (МАХН, АН) Засгийн газар байгуулагдсан ба кабинетад 2 эмэгтэй сайд (НХХЯ, ЗГХЭГ), 4 эмэгтэй дэд сайд (ХЗДХЯ, ЭМЯ, БСШУЯ, ХХААХҮЯ) томилогдсон нь 1992 оноос хойшхи Засгийн газруудад эмэгтэйчүүдийн төлөөлөл хамгийн өндөр үзүүлэлттэй Засгийн газар болсон юм.


ӨЗНІҮАӨ. 3

ОАЕДААО
 АҮҮА ÒАӨЕИА
 ААЕЕЕАА АОЕ
 ҮИҮАӨҮЕ÷ЗЗАЕЕИ
 НОААЕЕАА

ААА ÒЕЕ. 3

ОАЕДААО
 АҮҮА ÒАӨЕИА
 ААЕЕЕАА АОЕ
 ҮИҮАӨҮЕ÷ЗЗАЕЕИ
 НОААЕЕАА

№	Үзүүлэлт	Хувь
1	УИХ-ын гишүүд	3.9
2	Засгийн Газрын гишүүд	6.6
3	Дэд сайд	25
4	Төрийн нарийн бичгийн дарга	0
5	Яамдын газрын дарга, газрын орлогч дарга, хэлтсийн дарга	26.5



Харамсалтай нь 2009 оны 11 сард нэг эмэгтэй сайд нь өөрчлөгдөж Засгийн газрын кабинетэд эмэгтэй төлөөлөл 13.3 хувиас буурч 6.6 хувьтай байна.

Хүн амын 50-иас дээш хувийг эзэлдэг бүлгийн байр суурь хууль тогтоох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх гүйцэтгэх засаглалын дээд, дунд түвшинд өчүүхэн бага байсаар байгаа нь нийгмийн хөгжил гажуудаж буйг илтгэнэ.

Óēñ ò°ð ààðü ýìýãðýé÷¿¿ãèéí îðîēöîî

НҮБ-аас жендэрийн асуудлыг бодлогоор шийдвэрлэх, хэрэгжүүлэх стратеги, үйл явцыг /gender mainstreaming/ “... Хууль тогтоомж, бодлого эсвэл хөтөлбөр гэх мэт урьдаас төлөвлөдөг аливаа үйл ажиллагааны эмэгтэй, эрэгтэй хүмүүст тусах нөлөөг бүх чиглэлээр бүх түвшинд үнэлэн үзэх үйл явц юм. Энэ нь эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш ашиг хүртээж, тэгш бус байдлыг лавшруулахгүйн төлөө улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээний бүх салбарт бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийхдээ эмэгтэй, эрэгтэй хүмүүст тулгардаг асуудал, туулж өнгөрүүлдэг практикийг заавал анхаарах нэг хүчин зүйл болгон авч үздэг болгох стратеги /концепц, хандлага/ юм...” хэмээн тодорхойлжээ.

Энэ нь нэг талаас хөгжлийн үйл явц, нөгөөтэйгүүр стратеги мөн.

Бодлого төлөвлөлт, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад яамд тэргүүлэх үүрэгтэй оролцдог учраас жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тэрхүү үйл явцад харгалзан үзэх, тусгах асуудалд яамд манлайлан оролцох ёстой.

/Эх сурвалж: Жендэрийн стратеги. УБ.2006 он. 6-7-р хуудас/

Төр, захиргааны зарим байгууллагын удирдах бүрэлдэхүүнд ажиллаж буй эмэгтэйчүүдийг судалж үзэхэд Ерөнхийлөгчийн тамгын газар 4 (26.6%) ЗГХЭГ-ын удирдах бүрэлдэхүүнд 2 (22.2%) эмэгтэй байгаа ба УИХ-ын тамгын газрын 4 (57.1%) байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны гишүүдийн 22.2 хувь нь, Улсын дээд шүүхийн шүүгчдийн 41.1 хувь, Монгол улсын үндсэн хуулийн цэцийн гишүүдийн 33.3 хувь нь, Үндэсний статистикийн хорооны удирдах бүрэлдэхүүнд 50 хувь, Санхүүгийн зохицуулах хороо (Үнэт цаасны хороо)-ны гишүүдийн 28.5 хувь нь, Улсын Ерөнхий Прокурорын газрын удирдах бүрэлдэхүүнд 22.2 хувь нь, Хүний эрхийн комиссын 66.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд Төрийн албаны зөвлөл, Үндэсний Аудитын газар, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнд нэг ч эмэгтэй байхгүй байна.

Монгол улсын Үндсэн хуулийн үндсэн үзэл баримтлал болох «иргэний нийгэмд»-д төрийн /нийтийн/ үйлчилгээг иргэдэд хүргэгч албан хаагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь зохих түвшинд байна. Шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд төрийн албыг нийцүүлэх зорилго агуулсан Төрийн албаны тухай хуулиар төрийн албыг төрийн улс төрийн алба, төрийн захиргааны алба, төрийн тусгай алба, төрийн үйлчилгээний алба гэсэн 4 ангилалд хуваасан билээ. Эдгээр 4 ангилал дотроос төрийн захиргааны болон тусгай албан тушаал эрхлэгч албан хаагчид төрийн «жинхэнэ» албан хаагчийн статустай байна. Төрийн захиргааны албанд хамгийн өндөр албан тушаал болох яамдын Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд өнөөдрийн байдлаар нэг ч эмэгтэй томилогдоогүй байна.

Õ;ñíýãò. 4

Ò°đ çàõèðãààíû
 çàðèì óàèðãàã
 áĸđýěăýõĸĸíă
 àæèèèàæ áóé
 ýìýãðýé÷ĸĸăéí
 ñóăăèãàà


(õóâèàố)

	Нэрс	Хувь
1	ЗГ-ын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд	9.5
2	Ерөнхийлөгчийн тамгын газар	26.6
3	ЗГХЭГазар	40
4	Сонгуулийн Ерөнхий хороо	22.2
5	Төрийн албаны зөвлөл	0
6	Улсын дээд шүүх	41.1
7	Улсын Ерөнхий Прокурорын газар	22.2
8	УИХ-ын Тамгын газар	57.1
9	Үндсэн Хуулийн Цэц	33.3
10	Үндэсний Аудитын газар	0
11	Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл	0
12	Үндэсний статистикийн хороо	50
13	Санхүүгийн зохицуулах хороо	28.5
14	Хүний эрхийн комисс	66.6

Ãõà ô èê. 4

Ò° ð çàõèððãààíû
 çàðèì óàèðãàò
 áçðýéäýðççíä
 àæèèèàæ áóé
 ýìýàðýé÷ççäèéí
 ñóäàèèãàà

(õóâèàố)




Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд	1. Тагнуулын ерөнхий газар (түдгэлзэнэ) 2. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (түдгэлзэнэ) 3. Цөмийн энергийн газар (түдгэлзэнэ) 4. Төрийн өмчийн хороо (түдгэлзэнэ) 5. Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо (түдгэлзэнэ) Технологийн газар (түдгэлзэнэ)	
Тэргүүн шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	6. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (түдгэлзэнэ) 7. Стандартчилал хэмжил зүйн газар (түдгэлзэнэ)	1. Оюуны өмчийн газар (түдгэлзэнэ) 2. Улсын бүртгэлийн ерөнхий газар (түдгэлзэнэ)
Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (түдгэлзэнэ) 9. Онцгой байдлын ерөнхий газар (түдгэлзэнэ)	3. Хүүхдийн төлөө газар (түдгэлзэнэ)
Монгол Улсын сайд, ЗГ-ын ХЭГ-ын даргын эрхлэх ажлын хүрээнд		4. Удирдлагын Академи 5. Төр, Засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газар
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		6. Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар 7. Гадаадын хөрөнгө оруулалтын газар (түдгэлзэнэ)
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		8. Гаалийн Ерөнхий газар (түдгэлзэнэ) 9. Татварын Ерөнхий газар (түдгэлзэнэ)
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	10. Цагдаагийн Ерөнхий газар (түдгэлзэнэ) 11. Хил хамгаалах Ерөнхий газар (түдгэлзэнэ)	10. Архивийн Ерөнхий газар (түдгэлзэнэ) 11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар (түдгэлзэнэ) 12. Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхэлсэн газар (түдгэлзэнэ)
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх газрын хүрээнд		13. Ойн газар (түдгэлзэнэ) 14. Усны газар (түдгэлзэнэ) 15. Цаг уур, орчны шинжилгээний газар (түдгэлзэнэ)
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	12. Зэвсэгт хүчний жанжин штаб (түдгэлзэнэ)	
Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асууд		16. Соёл урлагийн хороо (түдгэлзэнэ)
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		17. Иргэний нисэхийн газар (түдгэлзэнэ) 18. Төмөр замын газар 19. Авто тээврийн газар 20. Авто замын газар 21. Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар (түдгэлзэнэ)

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		22. Нийгмийн даатгалын ерөнхий газар (түдгэлзэнэ) 23. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (түдгэлзэнэ)
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		24. Жижиг, дунд үйлдвэрийн газар 25. Мал эмнэлэг, үржлийн газар
Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		26. Ашигт малтмалын газар (түдгэлзэнэ) 27. Газрын тосны газар (түдгэлзэнэ) 28. Эрчим хүчний газар (түдгэлзэнэ)
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		29. Биеийн тамир, спортын газар (түдгэлзэнэ) 30. Эрүүл мэндийн газар (түдгэлзэнэ)

/Эх сурвалж: “Ардын эрх” сонин №004, 2009-01-08/

Төрийн албан хаагчдын хүйсийн бүтцийг 2007 оны 1-р сарын 1-ний байдлаар үзүүлбэл:




Эх сурвалж: “Монгол улсын төрийн албаны тойм” МУ-ын ЗГ, Төрийн Албаны Зөвлөл, УБ. 2008 он

Ääà ô èê. 5

Ò°ðëéí àëääí
òäää÷äüí
äîîð ýðýäýé,
ýíýäýé÷ççäëéí
ýçëýð òóäü

Ääà ô èê. 5.1

Ò°ðëéí àëääí
òäää÷äüí òîî,
àëääí òóðääëüí
äíäëëëääð



Эх сурвалж: “Төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчийн төлөвшил: өнөөгийн байдал, хандлага” /судалгааны тайлан/ Удирдлагын академи, 2009 он

Яагаад үгүй гэж?

2007 оны 10 сарын 08-аас 11 сарын 23-ны хооронд явуулсан тоо бүртгэлээр нийт 3852 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 199 (5.2 хувь) нь төрийн төв байгууллага, 35 (0.9 хувь) нь Улаанбаатар хотын, 490 (12.7 хувь) нийслэл дүүргийн, 710 (18.4 хувь) нь аймгийн төвийн, 2418 (62.8 хувь) сумын харьяаны байгууллагууд байна. Дээрх 3852 байгууллагад 122016 төрийн албан хаагч ажиллаж байна.

Төрийн байгууллагын харьяаллаар ангилан үзвэл төрийн албан хаагчийн 50 хувь буюу 58329 нь БСШУЯ-ны 1727 байгууллагад, 20.6 хувь буюу 24057 нь ЭМЯ-ны харьяа 634 байгууллагад тоологдсон нь хамгийн их тоотой байгаа нь нийт төрийн албан хаагчдын 70 хувь нь дээрх 2 салбарт ажилладаг гэсэн үг юм.

Одоо байгаа 42 агентлагийн удирдлагаас даргад 2 эмэгтэй (Ойн газар, Хүүхдийн төлөө газар), агентлагийн дэд дарга 4 эмэгтэй томилогдон ажиллаж байна. БСШУЯ-ны харьяа хэрэгжүүлэгч шинэ агентлаг Мэргэжлийн боловсролын сургалтын газар байгуулагдах шийдвэр УИХ-аас батлагдсан хуулийн дагуу гарсан.

№	Яамны нэр	Нийт апаратын ажилчин	Дотоод нэгжийн тоо	Эрэгтэй дарга		Эмэгтэй дарга	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	СЯ	142	18	12	66.6	6	33.3
2.	ХЗДХЯ	74	6	2	33.3	4	66.6
3.	БХЯ	58	6	6	100	0	0.0
4.	БОАЖЯ	73	8	7	87.5	1	12.5
5.	ГХЯ	107	12	11	91.6	1	8.3
6.	ЗТБХБЯ	116	8	8	100	0	0.0
7.	ЭБЭХЯ	75	7	7	100	0	0.0
8.	ЭМЯ	68	7	2	28.5	5	71.4
9.	НХХЯ	55	6	1	16.6	5	83.3
10.	БСШУЯ	70	8	7	87.5	1	12.5
11.	ХХААХУЯ	71	12	9	75	3	25

2008 оны УИХ-ын сонгуульд нам, эвслээс нийт нэр дэвшигчдийн 19 хувь нь эмэгтэйчүүд байсан. Энэ үзүүлэлт 1992 онд 7.7 хувьтай байв. 2005 онд батлагдсан «УИХ-ын сонгуулийн тухай» хуульд «нам эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна» гэсэн заалтыг УИХ-ын 2007 оны 12 сард уг хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах нэрийдлээр хассан.

ᠬᠡᠭᠡᠨᠢᠶ᠋ᠠᠳ. 6

ᠪᠠᠯ, ᠠᠠᠠᠢᠳᠡᠠᠠᠳ
ᠣᠠᠡᠳᠠᠠᠠᠳ ᠠᠡᠠᠠᠢ
ᠣᠣᠰᠠᠠᠡᠠ
ᠠᠡᠡᠡᠡᠠᠡ ᠠᠣᠡ
ᠶᠢᠶᠠᠳᠠᠶᠢᠶᠢᠶᠢ
ᠨᠣᠠᠠᠡᠠᠠᠠ

Квотын заалт хасагдсан хэдий ч УИХ-д суудалтай улс төрийн намуудын хүчин чармайлтын үр дүнд 2008 оны сонгуульд нэр дэвшигчдийн дүнд эмэгтэйчүүд өмнөх сонгуулиас арай илүү олон тоотой байсан. Тухайлбал МАХН-аас 76 мандатад 10 эмэгтэй, АН-аас 13 эмэгтэй түс түс нэр дэвшин өрсөлджээ.

Хуулийн төслийн тухай лавлагаа

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг 2008 оны 7-р сард УИХ-д Засгийн газраас өргөн барьсан. Засгийн газрын хурлаар 2009 оны 6-р сард хэлэлцүүлж дэмжигдсэн хуулийн төсөл юм.

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль нь 6 бүлэг, 29 зүйлтэй. Уг хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Уг хуулийн бүлгүүдийг нарийвчилж танилцуулбал:

Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл (хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, зарчим, бодлого, жендэрийн ялгаварлан гадуурхалыг хориглох, эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах тусгай арга хэмжээ)

Хоёрдугаар бүлэг: Төрийн байгуулал, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах баталгаа (улс төрийн хүрээн дэх эрх тэгш байдлын баталгаа, эдийн засгийн хүрээн дэх эрх тэгш байдлын баталгаа, төрийн албан дахь эрх тэгш байдлын баталгаа, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь эрх тэгш байдлын баталгаа, соёл боловсролын салбар дахь тэгш байдлын баталгаа, гэр бүлийн харилцаан дахь эрх тэгш байдлын баталгаа)

Гуравдугаар бүлэг: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх Улсын Их Хурлын бүрэн эрх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх Засгийн газрын бүрэн эрх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх МУ-ын Ерөнхий сайдын бүрэн эрх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх Жендэрийн үндэсний хорооны чиг үүрэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын чиг үүрэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон нийтийн ба төрийн бус байгууллагын оролцоо)

Дөрөвдүгээр бүлэг: Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх (Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдол гаргах, Жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх)

Тавдугаар бүлэг: Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага (Зөрчлийн улмаас үүсэх төлөөллийн хариуцлага, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага)

Зургадугаар зүйл: Бусад зүйл (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт, Хуулийг хэрэгжүүлэх журам, Хууль хүчин төгөлдөр болох)

/Эх сурвалж: Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөл.УБ,2009 он./

Яагаад үгүй гэж?

ΑΟΔΑΑ. Ì Î Í Î Ë Ó Ė Ũ Í Ç Ñ Å Å Ç Æ Æ Å Å Å, Í Ó Å Å
 Ä Ý Å Ñ Ä Ý Æ È È Í Í Ý Æ È È Í Ó Æ Æ Å È Å Å Å Å
 Ý Ì Ý Æ Æ Ó Ý × -- Ä È È Í Î Ð Æ Æ Î Î

Төрийг төлөөлж буй бүх шатны Засаг дарга, засаг даргын орлогч нарын 17.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэвч аймаг, нийслэлийн Засаг даргаар нэг ч эмэгтэй ажиллахгүй байгаа. Харин нийслэлийн засаг даргын орлогч нэг эмэгтэй мөн Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Засаг даргаар нэг эмэгтэй тус тус ажиллаж байна. Түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт /цаашид ЗДТГ гэх/

ЗДТГ-ын дарга нарын 17.4 хувь

ЗДТГ-ын удирдах ажилтны /газар, хэлтсийн дарга/ 28.1хувь

ЗДТГ-ын ажиллагсдын 51.9хувь нь эмэгтэйчүүд байгаагаас харахад засаг захиргааны нэгжийн шатлал буурах тутам эмэгтэйчүүдийн ажиллах хувь өсөж, харин дээд түвшинд хангалтгүй бага байгаа нь тодорхой харагдаж байна.

Àé ì àã í è éñěýěè é í ÇÄÖÃ-û í á ç ò ý ö

Аймгийн ЗДТГ-ын бүтцийг:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /хяналт шинжилгээ, үнэлгээний тасаг/
- Хууль зүйн хэлтэс /архивын тасагтай/
- Хөгжлийн бодлогын хэлтэс
- Нийгмийн хөгжлийн хэлтэс
- Санхүү, төрийн сангийн хэлтэс
- Цэргийн штабтай байхаар тогтов.

Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйдвэрлэлийн цаг хүрээнээс хамааруулан Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ыг 41 хүртэл, Архангай, Булган, Дорноговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий аймгийн ЗДТГ-ыг 37 хүртэл, Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ыг 29 хүртэл орон тоотой байхаар тогтоов.

Түүнчлэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах хэрэгжүүлэгч агентлагуудыг тогтоолоо.

/Эх сурвалж: “Үнэн” сонин №254, 2008-12-25/

Ø È Ñ Ò Ñ Ý Ý

Яагаад үгүй гэж?

2008 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд Нийслэл Улаанбаатар хотын удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн төлөөлөл ахисан сайн үзүүлэлттэй байна. Тухайлбал нийслэлийн засаг даргын 4 орлогчийн 1 нь эмэгтэй ба нийгмийн хөгжлийн асуудлыг хариуцаж байна. Улаанбаатар хотын 9 дүүргийн нэг дүүргийн засаг даргаар эмэгтэй хүн томилогдон ажиллаж байна. Мөн нийслэлийн ИТХТөлөөлөгч дотор эмэгтэйчүүдийн төлөөлөл 45 мандатаас 10-д нь байж, 22 хувь болон өсчээ.

Ө ЕАӨАҮҮ

Í èēñēýēēéí óäēðäēäâîí á¿ðöēēā

- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
- Нийслэлийн засаг даргын орлогч /нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан/
- Нийслэлийн засаг даргын орлогч /санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан/
- Нийслэлийн засаг даргын орлогч /барилга, хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан/
- Нийслэлийн засаг даргын орлогч /үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан/
- Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргатай байхаар

Ôēääíáäääðð òíðûí çäðēðäâ÷ēéí àæēûí äēääíû á¿ðýö

- Захиргааны алба
- Инженерийн шугам, сүлжээний хэлтэс
- Хот, нийтийн аж ахуйн хэлтэс
- Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс
- Орчны бохирдол, хог хаягдлын менежментийн хэлтэстэй байх

Нийслэлийн ЗДТГ-ын орон тооны хязгаарыг 85 хүртэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 40 хүртэл, нийслэлийн дүүргүүдийн ЗДТГ-ын орон тооны хязгаарыг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт тус тус 50 хүртэл, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт 45 хүртэл, Багануур, Налайх дүүрэгт 35 хүртэл, Багахангай дүүрэгт 22 хүртэл байхаар тогтоов.

Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 28 хэрэгжүүлэгч агентлаг ажиллах юм.


/Эх сурвалж: “Үнэн” сонин №254, 2008-12-25/

Аймаг сумдын ИТХурал дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн харьцуулсан судалгаанаас харахад эмэгтэй төлөөлөл хамгийн өндөртэй аймагт Баянхонгор (47.3 хувь), Төв (44.4 хувь), Дорноговь (39.8 хувь) зэрэг аймгууд орсон бөйхад хамгийн бага төлөөлөлтэй аймагт Сэлэнгэ (8.5 хувь), Баян-Өлгий (13.7 хувь) аймаг орж байна. Дээрх байдлыг дүгнэвэл орон нутгийн сонгогдох ИТХуралд эмэгтэйчүүд аль аль намаас илүү олон тоотой нэр дэвшиж, мөн тэд ялалт байгуулж сонгогдсон байдал ажиглагдаж байна. Орон нутагт эмэгтэйчүүдийн мэдлэг боловсрол өндөр, ажлын дадлага түршлага арвин, сонгогч олон нийтэд сайн ажил, үлгэр дууриалалаар танигдсан зэрэг шалгуур нөлөөлсөн байх талтай.

Äðà ô èê. 5

ÈÖÖ-û í
ò°ë°°ë°ã÷äëéí
äóíä
ýìýäðýé÷ççäëéí
ýçëýð òçâøëí


(àëíàä, ñóí,
íëëñëýë, äççðýä,
õîðîííä
ñîíäíäñäñíí íëëò
ýìýäðýé÷ççäëéí
òîí)




Äðà ô èê. 7

ÈÖÖ-û í
Öýðäççëýä÷äýä
ýìýäðýé÷ççäëéí
ýçëýð òçâøëí

(àëíàä, ñóí,
íëëñëýë, äççðýä,
õîðîíí)




Яагаад үгүй гэж?



ᠴᠠᠳᠠ-ᠠᠨᠢ ᠠᠵᠠᠳᠠ

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
- Хотын хөгжлийн бодлогын хэлтэс
- Санхүү, төрийн сангийн хэлтэс
- Хууль зүйн хэлтэс
- Нийгмийн хөгжлийн хэлтэс
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс
- Үйлдвэрлэлийн хэлтэс
- Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс
- Цэргийн штаб
- Хэвлэл мэдээллийн алба

/Эх сурвалж: “Үнэн” сонин №254, 2008-12-25/



ᠠᠳᠠᠨᠠᠳᠠ 8

ᠡᠭᠡᠭᠡ-ᠠᠨᠢ
 àæēí àēāíā
 àæēēāāñāūí
 áᠵᠠᠳᠠᠳᠠᠳᠠ
 ýíýāᠳᠠᠳᠠᠳᠠ
 ýᠵᠠᠳᠠᠳᠠᠳᠠ
 (àēíāā, ñóì,
 íēēñēýē, āᠵᠠᠳᠠ,
 òíᠳᠠᠳᠠ)


ᠭᠡᠳᠠᠳᠠᠳᠠ

ᠠᠳᠠᠨᠠᠳᠠ 9

Àéíāāò ñóíūí,
 íēēñēýēā
 òíᠳᠠᠳᠠᠳᠠ
 ᠴāñāā āāᠳᠠᠳᠠ
 àēāā òāᠳᠠᠳᠠ
 ýíýāᠳᠠᠳᠠ
 (ᠳᠠᠳᠠᠳᠠ)


Äðà õ èê. 10

Çàñàã äàðãàí
íðëíã÷ííð
àæëëëàããã
ýìýàðýé÷¿¿ã
(àéìãóóãúí
ñóìàíã áíëíí
ã¿¿ðã¿¿ãëéí
õíðííãíã)




Äðà õ èê. 11

ÇÄÒÄ-ñ í
ãàðãààð
àæëëëàããã
ýìýàðýé÷¿¿ã
(àéìãã, ñóì,
ã¿¿ðýã)




Яагаад үгүй гэж?



Ãðà ô èê. 12

ÇÃÒÃ-ò òýèòýñ,
àèáàí û ààðàààð
àæèèèààã
ýìýàðýé÷çã
(àéì àã, ñóì,
íèèñýè, äççðýä)



Ãðà ô èê. 13

ÇÃÒÃ-ò
àæèèèàãñà û í
äóíä
ýìýàðýé÷çãäèéí
ýçèýò òçâøéí
(àéì àã, ñóì,
íèèñýè, äççðýä)

Ä ª Ð ª Â. Ý Ì ÝÀÒÝÉ × ¯ ¯ Ä ÄÄ Ì ÄÖ Í

2005 онд болсон МАХН-ын XXIV Их хурлаар намын дүрэмд өөрчлөлт оруулж, дүрмийн «Намын залуу халаа, бусад байгууллагатай харилцах» гэсэн 12 дугаар бүлгийн 37 зүйлийн 7-д «МАХН-ын бүх шатны сонгуульт байгууллагад нэр дэвшигчдийн 25-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна.» гэж заасан нь намын дотоод бүтцэд (ялангуяа дээд түвшинд) эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэхэд чухал эрх зүйн зохицуулалт болсон.

Түүнчлэн МАХН Социнтерний гишүүн намын хувьд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжигч улс төрийн байгууллага гэдгийн илэрхийлэл болсон.

Özñíýàð. 8

Í è è ò í à ì ù í
à è ø ç ç ä è é í ä ö í ä
ý í ý ä ò ý é ÷ ç ç ä è é í
ý ç è ý ò ò ç ä ø è í
à é ì ä ä
í è è ñ è ý è ý ù ò
(ö ö ä è ä ò)


№	Нэрс	Намын гишүүдийн тоо	Намын хорооны нийт гишүүдийн тоо	Намын хорооны дарга нарын тоо	Намын хорооны нийт тэргүүлэгчдийн тоо	Намын хорооны орон тооны болон орон тооны бус дэд дарга нарын тоо	Намын хяналтын хороо, хэсгийн гишүүдийн тоо	Намын хорооны аппаратад ажиллагсадын тоо	НАШБ-ын дарга нарын тоо
1	Архангай	48.4	22.6	0	52.7	20	43.7	40	25
2	Баян-Өлгий	44.9	39.8	0	27.3	11	31.9	60	10.4
3	Баянхонгор	54.7	6.9	15	26.9	28.5	38.4	16.6	15
4	Булган	52	43.4	16.6	40.9	35	23.2	25	32
5	Говь-Алтай	46.2	33.7	10.5	35	10	33.3	16.2	11.7
6	Говьсүмбэр	50.6	26.8	25	25	66.6	50	37.5	0
7	Дархан-Уул	54.4	31.1	20	27.9	0	29.4	33.3	34
8	Дорноговь	59.4	38.8	12.5	38	18.1	62.7	30.8	32
9	Дорнод	51.9	20.9	0	78.7	24.3	66.6	22.2	29.7
10	Дундговь	51.9	53.1	0.0	51.0	0.0	52.0	51.4	42.8
11	Завхан	49.7	29.9	16	28.4	20	24	40	20.8
12	Орхон	50.7	23.8	0	20.6	16.6	46.6	56.2	50
13	Өвөрхангай	50.9	19.4	30	37.5	38	40.2	40	40
14	Өмнөговь	53.8	23.1	14.2	41.2	28.5	39.1	26.4	15
15	Сүхбаатар	49.3	39.9	14.3	19.2	35.7	25.6	45.5	55
16	Сэлэнгэ	58.2	58.2	22.2	30.2	43.7	31.5	33.3	91.6
17	Төв	52.7	48	25	42.3	57.1	47.6	50	25.9
18	Увс	49.9	19.9	15.8	15.4	6.3	22.2	25	25.3
19	Ховд	31.1	52.4	0	15	13.6	42.2	67.5	16.4
20	Хөвсгөл	57	17.2	8	4.8	33.3	34.5	44.3	9.5
21	Хэнтий	47	30.9	21	47.9	0	34.9	33.3	47.4
22	Нийслэл	52.3	35.5	0	15.6	11.1	39.4	53.5	46.4
	Дундаж	50.0	32.0	12.0	32.0	23.0	39.0	38.0	30.0

МАХН-ын нийт гишүүдийн 50.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Аймаг, дүүргийн намын хорооны гишүүдийн 32.0 хувь, аймаг, дүүргийн намын хорооны тэргүүлэгчдийн 32.0 хувь, аймаг, дүүргийн намын хорооны дарга

Яагаад үгүй гэж?


нарын 12.0 хувь, дэд дарга нарын 23.0 хувь, аймаг, дүүргийн намын хорооны хяналтын хорооны гишүүдийн 39.0 хувь, аймаг, дүүргийн намын хорооны аппаратад ажиллагсдын 38.0 хувь, намын анхан шатны байгууллага болох намын үүрийн дарга нарын 30.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

2007 онд хуралдсан МАХН-ын XXV их хурал намын дүрэм дахь эмэгтэйчүүдийн квотын заалтыг улам тодорхой болгон бататгасан. МАХН-ын дүрмийн «Ерөнхий зарчим, зүйл» гэсэн I бүлгийн 11-д «МАХН-ын бүх шатны сонгуульт байгууллагад 25-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Санал хураалтыг энэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулна» гэж заажээ.



ᠠᠳᠠᠨ ᠠᠨᠠᠭ. 14

ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ
ᠠᠨᠠᠭᠡᠨ ᠠᠨᠠᠭᠡᠨ ᠠᠨᠠᠭᠡᠨ
ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ
ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ
(ᠠᠨᠠᠭᠡᠨ, ᠶᠡᠭᠡᠨ)




ᠠᠳᠠᠨ ᠠᠨᠠᠭ. 15

ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ
ᠠᠨᠠᠭᠡᠨ ᠠᠨᠠᠭᠡᠨ ᠠᠨᠠᠭᠡᠨ
ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ
ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ ᠶᠡᠭᠡᠨ
(ᠠᠨᠠᠭᠡᠨ, ᠶᠡᠭᠡᠨ)


Ää ö è. 16

Í à ì ú í ò î ð ï í ú
 ä ä ð ä ä ä ð
 à æ è è è à à à ä
 ý ì ý ä ö ý é ÷ ç ç ä è é í
 ý ç è ý ò ò ç ä ø è í
 (ä é ì à ä,
 í è é ñ è ý é ý ð)




Ää ö è. 17

Í à ì ú í ò î ð ï í ú
 ö ý ð ä ç ç è ý ä ÷ ä è é í
 ä ö í ä
 ý ì ý ä ö ý é ÷ ç ç ä è é í
 ý ç è ý ò ò ç ä ø è í
 (ä é ì à ä,
 í è é ñ è ý é ý ð)




Яагаад үгүй гэж?



Ãðà ô èê. 18

í àì ù í ò î ð í í í ù
î ð í í ò î í í ù á ó ñ
ä ý ä ä ä ð ä ä ä ð
à æ è è è ä ä ä ä
ý ì ý ä ò ý ÷ ç ç ä
(à é ì ää,
í è é ñ ý é ý ý ð)




Ãðà ô èê. 19

í àì ù í ò î ð í í í ù
ø ý í ä è ð ù í
ò î ð í í í ä
ý ì ý ä ò ý ÷ ç ç ä è é
ý ç è ý ð ò ç ä ø è í
(à é ì ää,
í è é ñ ý é ý ý ð)


Äðà õ èê. 20

Í à ì û í ò ì ò í í í ù
à æ è ú í à è á à í ä
à æ è è è à à ñ à ú í
ä ó í ä
ý ì ý ä ò ý é ÷ ç ä æ é í
ý ç è ý ò ò ç ä ø è í
(ä é í ä ä,
í è è ñ è ý é ý ý ð)



Äðà õ èê. 21

Í à ì û í
à í ò à í ø ä ò í ù
ä ä è ä ö è è ä ä ú í
ä ä ð ä ä ä ð
à æ è è è ä ä ä ä
ý ì ý ä ò ý é ÷ ç ä æ é í
ý ç è ý ò ò ç ä ø è í
(ä é í ä ä,
í è è ñ è ý é ý ð)



МАХН-ын дотоод амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцооны байдлыг харуулсан дээрх график, хүснэгтийг харвал намын амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо дунд болон доод түвшинд өсөх хандлагатай байна. 2000 оноос хойшхи хугацаанд МАХН-д шинээр элсэгчдийн дотор эмэгтэйчүүдийн хувь тогтмол өсөж байна. Намын удирдах дээд бүтэц болох МАХН-ын Удирдах Зөвлөлд 21.7 хувь, Хяналтын Ерөнхий Хороонд 11.7 хувь, Ёс Зүйн Хороонд 28.5 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй байна. Мөн МАХН-ын нарийн бичгийн даргаар анх удаа эмэгтэй хүн сонгогдсон. Харин XXV их хурлаас сонгогдсон Намын Бага Хуралд (нийт 250 хүн) эмэгтэйчүүдийн төлөөлөл 13.3 хувьтай байна. Үүнээс дүгнэвэл намын удирдах дээд бүтэц дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл намын дүрэмд заасан 25 хувийн квотын заалтанд хангалттай хүрээгүй байна.

ОАА. АҮӨӨӨЭЭ Ё Ё Ы ЫАӨҮЭ × -- Ä Ó Ñ Ò ª Ð Ä

Ийм гарчигтай дэлхийн газрын зураг дээр эмэгтэйчүүдийн улс төр дахь оролцоог дэлхийн улс орнуудад ямар байгааг харуулсан судалгаа хүснэгтийг Олон Улсын Парламентын Холбоо, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах салбар, Эдийн засаг ба нийгмийн хэргийн хэлтсээс хамтран хэвлэн гаргажээ. Энэхүү судалгааг 2008 оны 1 сарын байдлаар нэгтгэн хийжээ.

Хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл хамгийн өндөр орны тэргүүн эгнээнд Африкийн Руанда улс орж байна. 2003 оны 9 сард болсон сонгуулийн үр дүнд парламентийн доод танхмийн суудлын 48.8 хувийг эмэгтэйчүүд авчээ. Дараа нь 47.0 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй Шведийн парламент, 41.5 хувийн төлөөлөлтэй Финлянд, 40.0 хувийн төлөөлөлтэй Аргентин, 39.3 хувийн төлөөлөлтэй Голландын парламент түс түс удаалжээ.

Нийт 187 орны хууль тогтоох байгууллагыг хамруулсан судалгааг дүгнэвэл тэдгээрийн 94 хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй байгаа ба парламент дахь эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлт 17.9 орчим хувь байна. Энэ нь үндэсний парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл 30-аас доошгүй хувьтай байлгана гэсэн дэлхийн нийтийн зорилт улс үндэсний түвшинд хараахан хэрэгжиж чадахгүй байгааг харуулж байна.

Дээрхи 189 орноос зөвхөн 20 оронд эмэгтэйчүүд парламентдаа 30-аас дээш хувийн төлөөлөлтэй байна. Эдгээр орныг дурдвал дээр хэлсэн Руанда, Швед, Финлянд, Аргентин, Голландаас гадна Дани 38.0 хувь, Коста-Рика 36.8 хувь, Испани 36.6 хувь, Норвеги 36.1 хувь, Куба 36.0 хувь, Бельги 35.3 хувь, Мозамбик 34.8 хувь, Исланди 33.3 хувь, Шинэ Зеланд 33.1 хувь, Өмнөд Африк 33.0 хувь, Австри 32.8 хувь, Герман 31.6 хувь, Уругвай 30.7 хувь, Танзаны нэгдсэн улс 30.4 хувь зэрэг парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллөөр тэргүүлж байна. Зарим улс орны парламентад ганцхан эмэгтэй төлөөлөлтэй байна. Жишээ нь: Сэнт-Нэвис, Белиз, Тонго, Комороз, Маршаллын арал, Бахрейн, Сан-Томэ Принсип, Кувейт, Папуа шинэ Гвиней, Йемен зэргийг дурдаж болно.

Мөн эмэгтэйчүүд огт төлөөлөлгүй парламенттай улс орон байна. Тухайлбал Микронези, Науру, Оман, Палау, Катар, Саудын Арави, Соломоны арал, Тувалу зэрэг орны парламентад эмэгтэйчүүд огт сонгогдоогүй ажээ.

Монгол орон эдүгээ парламентад 3.9 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй байгаа нь дэлхийн дундаж үзүүлэлт болох 17.9 хувиас бараг 4 дахин бага байгааг дээрх статистик харуулж байна.

2008 оны 1 сарын 1-ний байдлаар дэлхийн 192 улс орноос 36 оронд эмэгтэй хүн төрийн тэргүүн, ерөнхий сайд, парламентын даргаар ажиллаж байна.

Литвад Жендэрийн тэгш байдлын Омбудсмен байгуулагдсаныг бусад орон анхааралтай ажиглаж, “Өвөрмөц, анхаарах судлуштай бүтэц” хэмээн дүгнэж байна. Литвагийн парламент /Сейма/ Тэгш боломжийн талаарх хуулийг баталж, 1999 оны 3-р сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 1999 оны 5 дугаар сарын 25-наас Тэгш байдлын асуудлаарх Омбудын газар нь бие даасан байгууллагын статустай болсон байна.

Гүйцэтгэх засаглалын дээд түвшинд эмэгтэйчүүд ямар хувьтай байгааг мөн энэхүү судалгаа хүснэгтэнд дэлгэн тавьжээ. Нийт 185 орныг хамарсан судалгаанд эдгээрт 1022 эмэгтэй сайд ажиллаж байгаа гэсэн дүн гарчээ.

Яагаад үгүй гэж?

№	эмэгтэй сайд нарын албан тушаал	тоо
1	Нийгмийн асуудал	91
2	Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, тахир дутуу	84
3	Эмэгтэйчүүд, жендэрийн тэгш байдал	72
4	Боловсрол	70
5	Байгаль орчин, Байгалийн нөөц, Эрчим хүч	56
6	Худалдаа, үйлдвэрлэл	53
7	Хөдөлмөр эрхлэлт мэргэжлийн сургалт	49
8	Гадаад хэрэг, гадаадын тусламж	49
9	Эрүүл мэнд	49
10	Соёл	45
11	Хууль зүй	39
12	Судалгаа ба хөгжил, Шинжлэх ухаан ба технологи	34
13	Нийтийн ажил, нутаг дэвсгэрийн төлөвлөлт	32
14	Барилга хот байгуулалт	30
15	Хөдөө аж ахуй, хүнс, ой мод, загас агнуур	29
16	Дотоод хэрэг, дүрвэгсэдийн асуудал	27
17	Төрийн захиргаа, иргэний эрх зүй	27
18	Шуудан харилцаа холбоо	26
19	Орон нутгийн захиргаа	22
20	Аялал жуулчлал	19
21	Эдийн засаг, хөгжил	19
22	Эдийн засаг, Санхүү, төсөв	17
23	Тээвэр	15
24	Спорт	15
25	Хүний эрх	15
26	Хэвлэл, Мэдээлэл	9
27	Парламентын асуудал хариуцсан сайд	9
28	Яамгүй сайд	9
29	Батлан хамгаалах ба ахмадуудын асуудал	6
30	Хүн амын асуудал	5
	Нийт дүн	1022


ᠣᠡᠨᠢᠶ᠋ᠠᠳ. 9

Äýēōēéí 189
îðíû ýìýāðýé
ñàéā íàðûí
ñóāāēāāà

(òîîâîîð)

Äðà ô èê. 22

Äýëðëéí 189
îðíû ýíýãòýé
ñàéä íàðûí
ñóààëäàà
(òîîäîîð)



Засгийн газрын бүрэлдэхүүнд эмэгтэй сайд нарын эзлэх хувиар Финлянд улс тэргүүлж байна. Тэрээр 19 сайдын 11 нь эмэгтэй ба Засгийн газрын кабинетэд нийт 57.9 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй байна. Үүний дараа Норвеги улсын Засгийн газар 55.6 хувийн үзүүлэлттэй байна. Энд Засгийн газрын 18 гишүүний 10 нь эмэгтэй хүн ажээ.

Засгийн газарт 40-49.9 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй 6 улс байгаагаас Швед (47.6 хувь), Франц (46.7 хувь), Өмнөд Африк (44.8 хувь), Испани (43.8 хувь), Швейцар (42.9 хувь), Чили (40.9 хувь) улс орон багтжээ.

Яагаад үгүй гэж?

35-39.9 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй Засгийн газартай улс орнуудад Эл Сальвадор (38.9 хувь), Австри (38.5 хувь), Андорр (37.5 хувь), Дани (36.8 хувь), Исланд, Тринадад Тобаго (тус бүр 36.4 хувь), Капе Вэрдэ (35.7 хувь), Эквадор (35.3 хувь) улс орон орж байна.

30-34.9 хувийн эмэгтэй сайдтай улс орнуудад Герман, Голланд, Никарагуа (тус бүр 33.3 хувь), Шинэ Зеланд (32.1 хувь), Лесото (31.6 хувь) улс орон орж байна.

25-29.9 хувийн эмэгтэй сайдтай 16 орон байгаагаас Бурунди (29.6 хувь), Коста-Рика, Перу (тус бүр 29.4 хувь), Уругвай (28.6 хувь), Уганда (28.0 хувь), Барбадос, Ботсвана, Гамби (тус бүр 27.8 хувь), Гайана, Польш (тус бүр 26.3 хувь), Мозамбик (25.9 хувь), Нигер (28.5 хувь), Гвинея-Бисау, Намиби, Сан-Томэ Принсип, Зүүн Тимор (тус бүр 25.0 хувь) улс орж байна.

20-24.9 хувийн эмэгтэй сайдтай 31 орны Засгийн газар,

15-19.9 хувийн эмэгтэй сайдтай 23 улс орны Засгийн газар,

10-14.9 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй 34 орны Засгийн газар,

5-9.9 хувийн төлөөлөлтэй 37 орны Засгийн газар тус тус ажиллаж байна. Монгол улс 6.6 хувийн (15 сайд нараас 1 эмэгтэй) үзүүлэлттэйгээр энэ бүлэгт хамаарч байна.

3-4.9 хувийн төлөөлөлтэй Ливан, Бахрейн, Украин, Турк, Вьетнам, Афганистан, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Ираны Засгийн газар орж байна.

Эмэгтэй нэг ч сайдгүй Засгийн газар бүхий 13 орон байгаагаас дурьдвал Бутан, Босни-Герцеговин, БНАСАУ, Ливи, Монако, Бирма, Науру, Палау, Румын, Саудын Араб, Сингапур, Соломоны арлууд, Тувалу зэрэг улсыг хэлж болно.

ХАВСРАЛТ

Энэхүү хавсралтанд Социнтерний эмэгтэйчүүдийн байгууллагын зарим чухал тогтоол, Социнтерний гишүүн улс төрийн намуудын дүрэмд баримталдаг квотын зарчим, МАХН-ын дүрмийн заалт, квотын талаарх тайлбар, гадаад орны туршлага зэргийг орууллаа. Мөн МАХН-ын дэргэдэх МАСЭХ-ны тэргүүн Д.Алтайн байгууллагаа төлөөлөн 2006-2009 онуудад олон улсын болон бүс нутгийн хурал зөвлөгөөн, Социнтерний эмэгтэйчүүдийн байгууллагын товчооны хуралд хэлэлцүүлсэн илтгэл, мэдээлэл, мөн Монгол улсад болсон “Сонгууль ба эмэгтэйчүүдийн оролцоо” олон улсын чуулган, МАСЭХ-ны “Хатагтай” клубын цугларалтанд тавьсан илтгэл, сонсгол зэргийг англи, монгол хэл дээр багтаан нийтлэв. Мөн 2009 оны 7 сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Улс төр ба хариуцлага” сэдэвт Зуны академид ХБНГУ-ын Бундестагийн гишүүн, монголын эмэгтэйчүүдийн дотны анд эрхэм хатагтай Уте Кумфын тавьсан илтгэлийг оруулав.

СОЦИАЛИСТ ИНТЕРНАЦИОНАЛ ЭМЭГТЭЙЧҮҮД СИЭ-ИЙН 100 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ГАРГАСАН ТУНХАГ

ШТУТГАРТЫН ТУНХАГ

Өнөөдөр 2007 оны 9 сарын 8-ны өдөр Социалист Интернационалын Эмэгтэйчүүд (СИЭ) бид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш байдлын төлөө тэмцэж ирсэн коммунизмыг үүсгэн байгуулсан эхчүүдээ ахин дурсаж Штутгарт хотноо Зуун жилийн ойгоо тэмдэглэхээр хуран цугларсан билээ. СИЭ нь жендэрийн тэгш байдлын төлөө үйл ажиллагааны анхдагч байгууллага байсаар ирсэн. Эмэгтэй хүмүүс улс төрийн үйл ажиллагаанд оролцож болдоггүй тэр үед, Клара Цеткин бүхий 58 төлөөлөгч 1907 оны 8 сарын 17-нд анхны олон улсын социалист эмэгтэйчүүдийн хурлыг Германы Штутгартад хийснээр өнөөдрийн Социалист Интернационал Эмэгтэйчүүд байгуулагдсан юм. 100 жилийн дараа Социалист Интернационалын Эмэгтэйчүүд нь жендэрийн тэгш байдлын асуудлаар анхдагч байж чадсан ба 146 гишүүн байгууллагатай, манай байгууллага энэ утгаараа хамгийн том, хамгийн ахмад эмэгтэйчүүдийн улс төрийн байгууллага юм.

Анхнаасаа л Социалист Интернационал Эмэгтэйчүүдийн гол анхаарч ажилласан асуудал бол улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо байсан бөгөөд социалист гэр бүлийн олсон амжилтууд ч үүнийг баталж байна. Эхний хурлаар Социалист Интернационал Эмэгтэйчүүдийг үүсгэн байгуулагчид эмэгтэйчүүдийн сонгуульд оролцох эрхийг шаардсан шийдвэрийг гаргасан. Одоо үед, ихэнх орнуудад эмэгтэй хүн саналаа өгөх эрхтэй болсон. 1924 онд Засгийн газрын анхны эмэгтэй гишүүн болсон хүн бол Данийн ардчилсан социалист үзэлтэй Нина Банг байлаа. Хамгийн анхны хүйсийн тэнцвэртэй засгийн газруудыг нь социалист болон нийгмийн асуудал эрхэлсэн сайдууд ахлаж байсан юм. Тэд нар бол: Голда Мэйер, Гру Харлэм Брундтланд, Беназир Бхутто, Мари Робинсон, мөн өнөө үеэс бол, Хелен Кларк, Таржа Халонэн, Луйса Диас Диого, Портиа Симпсон, Мишель Бачэлэт мөн Мишель Калми-Рэй юм. Энэ эмэгтэйчүүд бол бусад эмэгтэйчүүддээ үлгэр дууриал болж, тэднийг дуу хоолойгоо бусдад хүргэж, удирдах албан тушаалд хүрэхэд нь дэмжлэг болж байна.

СИЭ нь квотын зарчмыг социалист, ардчилсан социалист намуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, түүнийг дэмжин ажиллахыг удирдлага болгодог. Квотын зарчим нь улс төр дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлыг

зохицуулахад хамгийн нөлөөтэй хэрэгсэл болох нь батлагдсан юм. СИЭ нь эмэгтэйчүүдийн хүний эрхийг хангах чухал хэрэгсэл болсон. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци, тус конвенцийн нэмэлт протоколд нэгдэж, тэдгээрийн үзэл санааг хэрэгжүүлэхэд Засгийн газруудыг шахан шаардах хүнд ажлыг урт удаан, хугацаанд явуулж ирлээ.

1995 онд Бээжинд болсон НҮБ-ын Дэлхийн Эмэгтэйчүүдийн бага хурал бол эмэгтэйчүүдийн хөгжлийн чухал ахиц үе байж чадсан юм. Энэхүү бага хурлын ач тусаар улс орны хоорондын эв найрамдал хөгжилд жендэрийн тэгш байдал маш чухал үүрэгтэй гэдгийг ухамсарлан ойлгож, нилээд хэдэн Засгийн газрууд улс төрийн хэлэлцэх хэрэгт жендэрийн тэгш байдлын асуудлыг талаар тусгаж өгсөн юм.

Ерөнхийд нь авч үзвэл СИЭ нь ажлаа хийснээр олон амжилтанд хүрсэн боловч нилээдгүй зүйл дээр жендэрийн тэгш байдал хангагдах болоогүй байна. Жишээ нь, гэр бүл дотор, мөн ажил дээр, гэхдээ хамгийн гол нь шийдвэр гаргах үйл явцад тодорхой харагдаж байна. ОУПарламентийн Холбооны судалгаагаар бол үндэсний парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл ердөө 17.3 хувьтай байгаа бол, Засгийн газар дахь эмэгтэй гишүүдийн хувь үүнээс ч бага байна.

Тийм учраас СИЭ-дийн зуун жилийн ой маань зөвхөн тэмдэглэлт баяр бус харин ч хатуу сургамжийг бидэнд эргэн сануулж, ирээдүйд тулгарах асуудлуудыг шийдвэрлэх хүч болгон ашиглах нь зөв юм. Ялангуяа ядуурал, өлсгөлөнг устгах хамгийн хүнд хэлбэрийн тэгш бус байдал болох эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зогсоох тал дээр ажиллах хэрэгтэй байна. Бидний цаашдын сорилтууд нь цэвэр ус хэрэглэх боломж, эрүүл мэндийн үйчилгээ, аюулгүй үр хөндөлт бөгөөд эдгээр нь хүний энгийн хэрэглээ юм. Түүнчлэн эмэгтэйчүүдийн гол ялгарах асуудал бол сайн боловсрол эзэмших явдал юм. Тийм учраас СИЭ нь тодорхой хууль журмыг хэрэгжүүлэх ёстой гэж үзэн ажиллаж байгаа бөгөөд хамгийн түрүүнд НҮБ-ын Мянганы Хөгжлийн Зорилтуудаас эхлэн хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байна.

Даяарчлал болон хурдацтай хөгжиж буй технологи нь өөр олон яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудал, сорилтуудыг дэвшүүлж байна. Жишээ нь: хүмүүс цагаачлах, цаг агаарын өөрчлөлт, фундаменталист үзэл болон террористуудын заналхийлэл, аюултай өвчин жишээлбэл ДОХ, хумхаа гэх мэт, мөн хүний наймаа ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүд хүний наймааны золиос болж байна.

Анхаарлаа хандуулах бусад зүйл бол: мөргөлдөөнийг зохицуулах ба түүнээс урьдчилан сэргийлэх учир нь эмэгтэйчүүд болон хүүхдүүд ихэвчлэн дайн ба мөргөлдөөний үед хохирогчид болж байдаг; бас эв найрамдалыг бий болгох, учир нь эмэгтэйчүүдийн оролцоотойгоор л мөнхийн эв найрамдал бий болж чадна.

Зуун жилийн өмнө, 58 төлөөлөгч бүхий баг дэлхийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш байж чадна гэсэн алсын хараатай байсан. Тэд зоригтой эмэгтэйчүүд байсан, өөрсдийн итгэл эрмэлзэлтэй хүмүүс байсан ба бид бүгдэд их хүч, үлгэр дууриал болж байгаа билээ. Энэ бол бидний үүрэг бөгөөд бид тэдэнд өртэй хүмүүс. Тэдний эхэлсэн ажлыг бид дуусгах ёстой ба шинэ сорилтуудтай нүүр тулж эв найрамдал, хөгжлийг бий болгох хэрэгтэй. Тийм учраас, өнөөдөр Штутгартад цугласан СИЭ-ийн гишүүн байгууллагууд бид эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд жендэрийн тэгш байдлыг бий болгоно, түүний төлөө тэмцэнэ гэж ахин амлалт өгч байна.

**Штутгарт
ХБНГУ**

2007 оны 9 сарын 8

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН КВОТЫГ БАТАЛГААЖУУЛСАН СОЦИНТЕРНИЙ ГИШҮҮН УЛС ТӨРИЙН НАМУУД

Албани	
Социал демократ нам	30%
Социалист нам	30%
Ангол	
Ардын чөлөөлөх хөдөлгөөн	30%
Аргентин	
Социалист нам	30%
(эмэгтэйчүүдийн хороо)	
Иргэний радикал холбоо	30%
(эмэгтэйчүүдийн зөвлөл)	
Армен	
Социалист нам	25% нэр дэвшигчдийн
(эмэгтэйчүүдийн хороо)	жагсаалтанд
Австрали	
Хөдөлмөрийн нам	35%
Австри	
Социал демократ нам	40% хоёр жендэрт
Бельги	
Социалист нам	25%
Социалистуудын нам	20%
(Интер-федерал эмэгтэйчүүдийн хороо)	
Босни-Герцеговин	
Социал демократ нам	30%
Ботсвана	
Үндэсний квот	30%
Бразил	
Ардчилсан хөдөлгөөний нам	30% намын дотоод бүтцэд
Болгар	
Социал демократ нам	30% намын дотоод бүтцэд
Буркина-Фасо	
Ардчилал, дэвшлийн төлөө нам	30%
Чили	
Радикал социал демократ нам	20% намын дотоод бүтцэд
Ардчилалын төлөө нам	40%
Социалист нам	30%
Социал демократын фронт	25% намын дотоод бүтцэд

Яагаад үгүй гэж?

Канад	
Шинэ ардчилсан нам	50%
Колумб	
Эрх чөлөөний нам	30% намын дотоод бүтцэд
Сөрөг ардчилсан хүчин	30% намын дотоод бүтцэд
Коста Рика	
Үндэсний эрх чөлөөний нам	40%
Коте де Ивуар	
Ардын фронт	30%
Хорвати	
Социал демократ нам	40% хоёр жендэрт
Куракао	
Шинэ антиллын төлөө хөдөлгөөн	30% нэр дэвшигчдийн жагсаалтанд
Кипр	
Социал демократын EDEK хөдөлгөөн	25%
Чех улс	
Чехийн ардчилсан социалист нам	25% намын дотоод бүтцэд
Дани	
Социал демократ нам	40% хоёр жендэрт
Доминикани БНУ	
Хувьсгалт нам	33%
Эквадор	
Зүүний ардчилалын нам	30%
Финлянд	
Социал демократ нам	40% хоёр жендэрт болон намын бүтцэд
Франц	
Социалист нам	50%
ХБНГУ	
Социал демократ нам	40% хоёр жендэрт
Грек	
Панхельник социалист хөдөлгөөн	40% хоёр жендэрт болон намын бүтцэд
Гватемал	
Итгэл үндэсний холбоо	40%
Гаити	
Социал демократуудын холбоо	25%

Яагаад үгүй гэж?

Унгар	
Социалист нам	20%
Ирланд	
Хөдөлмөрийн нам	25%
Израйль	
Хөдөлмөрийн нам	40% намын бүтцэд
Мерец-Яхад нам	40% хоёр жөндөрт ба намын дотоод бүтцэд
Итали	
Социалист нам	66% хоёр жөндөр ба намын дотоод бүтцэд
Литва	
Социал демократ нам	30%
Македони	
Социал демократ холбоо	30% хоёр жөндөрт
Мали	
Эв нэгдэл, шудрага ёсны төлөө	
Африкийн нам	30%
Малийн чуулган	30%
Мальта	
Хөдөлмөрийн нам	20%
Мексик	
Ардчилсан хувьсгалын төлөө нам	
Хувьсгалт нам	50% хоёр жөндөрт 50%
Монгол улс	
МАХН	25% намын дотоод бүтцэд
Монтенегро	
Социал демократ нам	30%
Морокко	
Ардын хүчний социалист холбоо	20%
Мозамбик	
Фрелимо нам	35%
Голланд	
Хөдөлмөрийн нам	50%
Никарагуа	
Сандинистын Үндэсний Чөлөөлөх фронт	30% /доод хэмжээ/
Норвеги	
Хөдөлмөрийн нам	40% хоёр жөндөрт

Яагаад үгүй гэж?

Парагвай		
Хувьсгалч Фебрерист нам	30%	/доод хэмжээ/
Румын		
Социал демократ нам	25%	
Сенегал		
Социалист нам	25%	
Серби		
Социал демократ нам	30%	
Словак		
Нийгмийн ардчилал	20%	
Словен		
Социал демократууд	33%	
Өмнөд африк		
Африкийн Үндэсний конгресс	30%	
Испани		
Социалист ажилчдын Нам	40%	хоёр жөндөрт
Швед		
Социал демократ нам	50%	нэр дэвшигчдийн бүхий л жагсаалтанд
Швейцари		
Социал демократ нам	40%	
Тунис		
Үндсэн хуульт ардчилсан чуулган	20%	
Турк		
Бүгд найрамдах ардын нам	25%	хоёр жөндөрт
Украйн		
Социал демократ нам	33%	
Уругвай		
Социалист нам	36%	(доод хэмжээ)
АНУ		
Ардчилсан социалистууд	50%	дотоод бүтэц
Венесуэл		
Ардчилсан үйл хэрэг	30%	
Социализмийн төлөө хөдөлгөөн	30%	
Иемен		
Социалист нам	30%	

(2009 оны 6 сарын байдлаар)

МАХН-ЫН ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг

ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, ЗҮЙЛ

1 дүгээр зүйл. Монгол Ардын Хувьсгалт Намын үйл ажиллагааны нийтлэг зарчим

1.1. Монгол Ардын Хувьсгалт Нам /товчилсон нэр: МАХН/ Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиж, төрт ёсыг дээдлэн хуулийн хүрээнд энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.2. МАХН аливаа сонгуулийн үр дүнд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад олонхи болж бодлогоо хэрэгжүүлэхийн төлөө ажиллана.

1.3. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан зарчимд тулгуурлана.

1.4. Намын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтэнд нь хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, гишүүд дэмжигчдийн идэвхтэй оролцоог хангаж, дотоод ардчиллыг хэлбэрэлтгүй баримтлан хэрэгжүүлнэ.

1.5. Намын удирдах байгууллагуудыг сонгож байгуулна.

1.6. Намын бүх шатны байгууллагын сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг ил тод, ардчилсан чөлөөт өрсөлдөөний зарчмыг баримтлан явуулж, саналыг нууцаар хураана.

1.7. Намын аливаа байгууллага асуудлыг чөлөөтэй хэлэлцэх бөгөөд цөөнхийн саналд хүндэтгэлтэй хандаж, олонхийн саналаар шийдвэрлэн гарсан шийдвэрийг нийтээрээ дагаж биелүүлнэ. Цөөнх саналаа үндэслэлтэй гэж үзвэл асуудлыг намын холбогдох дээд байгууллагад тавьж хариу авч болно.

1.8. Намын бүх шатны байгууллага улс төрийн аливаа шийдвэрийг энэ дүрэмд заасны дагуу албан ёсны хуралдаанаар хэлэлцэн гаргана. Хурал нь олонхи ирснээр хүчинтэй байна.

1.9. Намын сонгуульт байгууллага, сонгуультан үйл ажиллагааныхаа талаар тухайн шатны болон дээд байгууллагад тайлагнана.

1.10. Намын ажлыг ёс зүйн өндөр түвшинд шударгаар явуулна.

1.11. МАХН-ын бүх шатны сонгуульт байгууллагад 25-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Санал хураалтыг энэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулна.

1.12. МАХН хуулийн этгээд мөн.

1.13. Намын төв байгууллага Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана.

1.14. Намын аливаа байгууллагын хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтлөн хэлэлсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол тогтоол, тэмдэглэлд хуралдаан даргалагч буюу тэргүүлэгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

*МАХН-ын XXV Их хурлаар баталсан дүрмээс
Монгол Ардын Хувьсгалт Намын дүрэм. УБ, 2007*

Яагаад үгүй гэж?

КВОТ -ТЭГШ БАЙДЛЫН ТҮЛХҮҮР

Монгол дахь НҮБ-ын Хүн Амын сан
Азийн хөгжлийн банк

Жендэрийн Тэгш байдлын Үндэсний
Хорооны ажлын алба

Яагаад бид квотын тухай яриад байна вэ?

Хүн эмэгтэй ч бай, эрэгтэй ч бай тэгш эрхтэйгээр улс төр, эдийн засаг нийгмийн үйл явцад оролцож, төрийн эрх мэдлийг барилцаж, өөрийнхөө болон бусдын эрх ашгийг төлөөлөх эрхтэй.

Иймээс бид эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш эрхийн талаар ярилцаж байдаг.

Дэлхийн улс орнуудын Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг бүс нутаг, улс улсаар нь жагсаасан бөгөөд Монгол улсын Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо 4 хувь буюу жагсаалтын 129-д бичигдсэн байна.

Жагсаалтын эхний 10-т орсон улсын нэрийг танилцуулваас

1.	Уганда	56.3 хувь	2008. 9 сар
2.	Швед	47.0 хувь	2006. 9 сар
3.	Өмнөд Африк	44.5 хувь	2009. 4 сар
4.	Куба	43.2 хувь	2008. 1 сар
5.	Исланд	42.9 хувь	2009. 4 сар
6.	Аргентин	41.6 хувь	2009. 6 сар
7.	Финлянд	41.3 хувь	2007. 3 сар
8.	Нидерланд	41.3 хувь	2006.11 сар
9.	Герман	38.0 хувь	2007.11 сар
10.	Ангол	37.3 хувь	2008. 9 сар

Мөн жагсаалтын дундуур орсон буюу бидний хэл заншиснаар жендэрийн асуудалтай байдаг гэж тооцдог улсын Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг танилцуулваас

1.	Пакистан	22.5 хувь	2008. 2 сар
2.	Арабын Нэгдсэн Эмирант	22.5 хувь	2006.12 сар
3.	Этиопи	21.9 хувь	
4.	Серб	21.6 хувь	2008.5 сар
5.	БНХАУ-лс	21.3 хувь	2008.3 сар

Эмэгтэйчүүдийн удирдах болон шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх хамгийн гол механизмын нэг бол КВОТ юм.

Квотыг хууль, эрх зүйн орчинд албажуулах нь тэгш эрх, хүний эрх, ардчиллын суурь зарчмыг хөгжүүлэхэд чухал нөлөө болж чаддаг нь олон зууны турш тэмцэж олсон ололтуудаар аль хэдийнээ батлагдсан байна.

Тэгш байдлыг хангах явдал нь дэлхийг хүмүүнлэг байлгах, сайн засаглалыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтойг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрсөөр байгааг бид ч гэсэн анхааралдаа авах цаг болжээ.

КВОТ гэж юу вэ?

Эмэгтэйчүүдийг дэмжиж, хүйсийн тэгш эрхийн боломжийг хууль тогтоох, засгийн газрын кабинет, орон нутгийн удирдах байгууллагуудын бүхий л түвшинд нэр дэвших, сонгогдох боломжийг бий болгож байгаа аргачлал юм. Хүйсийн квот нь эмэгтэйчүүдийг ялгаварлах, улс төрийн өрсөлдөөнд оруулахгүй байхын эсрэг хууль эрх зүйн тэмцэл гэж үздэг.

Өнөөдөр дэлхий нийтэд квотыг хоёр төрлөөр авч үзэж байна.

- Нэгдүгээрт, нэр дэвшигчийн тоонд квот тавих
- Хоёрдугаарт, тодорхой тооны суудлыг эмэгтэйчүүдэд зориулан хуваах гэсэн төрөлтэй байдаг.

Дэлхийн 40 гаруй улс өнөөдөр сонгуулийн квотыг Үндсэн хуулиндаа, харин 50 гаруй улсын улс төрийн намууд өөрсдийн сайн дураар эмэгтэйчүүдэд боломж олгох квотын доод хэмжээг сонгуулийн хуулиндаа тус тус тусгасан байна.

Бидний сайн мэдэх Скандинавын орнууд 1970 оноос эхлэн квотын системийг хэрэгжүүлэх талаар ажиллаж хуульчилснаар парламент болон бусад шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь тогтмолжиж дэлхийн улс орнуудын Жендэрийн үзүүлэлтийн жагсаалтыг тэргүүлсээр байна.

Эмэгтэйчүүдийг дэмжих квот тогтоосноор Аргентин, Коста Рика, Мозамбик, Руанда болон Өмнөд Африк зэрэг улсууд олон жилийн турш эмэгтэйчүүдийн өндөр төлөөлөлтэй Скандинавын орнуудтай төлөөллийн тоогоороо өрсөлдөх болжээ.

Квотыг Үндсэн хуулиндаа тогтоосон улсуудаас дурьдвал:

- | | |
|-------------|----------|
| • Аргентин | 1991 |
| • Гуйана | 1997 |
| • Франц | 1993 |
| • Эритрей | |
| • Кени | 1997 |
| • Руанда | 2003 |
| • Уганда | 1995 |
| • Бангладеш | 2004 |
| • Филиппин | 1995 |
| • Тайвань | 1997 г.м |

Квотыг хэрэгжүүлэх талаарх ойлголтыг сайжруулах хэрэгцээ

Жишээ нь: Нэр дэвшигчийн жагсаалтыг 30 хувьд эмэгтэй нэр дэвшигчийг оруулна гэсэн квот нь шууд 30 хувьд нь эмэгтэйчүүд сонгогдоно гэсэн үг биш юм. Энэ нь зөвхөн эмэгтэйчүүдэд боломж олгож байгаа гэдгийг ухаарах ёстой. Гэхдээ энэ нь эмэгтэйчүүдийн төлөөлөл ёс төдий байна гэсэн үг бус юм.

Эмэгтэйчүүдийн квот нь тэгш байдлын нэг үзэл баримтлалаас нөгөө үзэл баримтлалд шилжих шилжилт юм. Тэгш байдлын сонгодог либерал үзэл нь “Тэгш боломж” болон “Өрсөлдөх тэгш байдал” гэсэн хоёр баримтлал дээр тогтдог юм.

Сонгуульд эмэгтэйчүүдийн нэрдэвших квотыг тогтоож хэрэгжүүлэх нь дараахь хүчин зүйлүүдээр тайлбарлагдсаар ирсэн билээ. Үүнд:

- Эмэгтэйчүүд гэсэн хүйс нь дэлхийн хүн амын тэн хагасыг эзлэж байгаа. Үүнийг хууль ёсны аргумент (нотолгоо) гэж авч үздэг.
- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүд нь хүний эрхийн хувьд тэгш байх зарчимд суурилж, биологийн болон нийгмийн хувьд харилцан адилгүй туршлага хуримтлуулсан байдаг. Эмэгтэйчүүдийн хуримтлуулсан туршлага нь нийгмийн болон улс төрийн бодлогыг сайжруулахад чухал нөлөө үзүүлж чаддаг.
- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сонирхол, эрх ашгийг хөндсөн нийгмийн ялгаатай асуудлууд үүсдэг бөгөөд үүнийг дан ганц хүйс буюу эрэгтэйчүүд төлөөлөн шийдвэрлэх боломж муутай байдаг. Иймээс эмэгтэйчүүдийн оролцоог зайлшгүй чухал хэмээн үздэг аргумент юм.
- Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулснаар нийгэмд бусад эмэгтэйчүүдэд урам зориг өгөх, хамтран ажиллах боломжийг бий болгох, мөн улс төрийн чиг хандлагыг шинэлэг, зарчимч шинэ замаар хөгжих боломжийг бий болгож өгч чаддаг.

Квотын системийг ашиглах нь давуу ба сул талуудтай хэдий ч өнөөдөр бид давуу талыг нь илүү авч үзэх шаардлагатай байна.

Квотын давуу талууд

- Эмэгтэйчүүдийн квот нь ялгаварлан гадуурхдаг, эмэгтэйчүүдэд эдлэх ёстой эрхийг нь эдлүүлэхгүй байгаа саад тотгоруудыг арилгах хууль зүйн үндэслэл болдог.
- Эмэгтэйчүүд иргэн болохын хувьд тэгш төлөөлөлтэй байх эрхтэй.
- Улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн туршлага хэрэгцээтэй.
- Эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдийн сонирхлыг төлөөлж чадахгүй. Харин олон тооны эмэгтэйчүүд зэрэг байваас үүнийг бүрэн илэрхийлж чадна. Сонгууль бол төлөөллийн ардчилсан үйл явц юм.

- Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй эн зэрэгцэх боломжтой, харин эрчүүд давамгайлсан улс төрийн системд эмэгтэйчүүдийн чадавхийг бууруулж тооцсоор ирсэн.
- Квот нь эрэгтэй хүнийг хувь хүнийх нь хувьд ялгаварлан гадуурхаагүй бөгөөд харин улс төрийн намуудыг зөвхөн эрэгтэйчүүдийг бүрэн дэмжиж нэг талыг баримтласан шийдвэр гаргахыг хязгаарладаг. Сонгогчдын хувьд эмэгтэй нэр дэвшигч нар байгаа болохоор боломжууд нь өргөждөг.
- Квот тогтоох нь зөрчилдөөн үүсгэж болох ч энэ нь тун богино хугацааны үйл явц юм.
- Олон улсын байгууллагууд эмэгтэйчүүдийн төлөөллийн зорилгыг тодорхойлон Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын бүх хэлбэрийг устгах конвенцид 179 орон нэгдсэн бөгөөд мөн 1995 оны Бээжингийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, мөн дэлхий нийтээрээ санаа тавин ажиллаж буй Мянганы Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Иймээс бид Монгол улсын Парламентад өмнө гаргасан алдаанаасаа сургамж авч дэлхий нийтийн өмнө гаргасан алдаагаа давталгүй засаж ажиллахыг сануулж байна.

Боловсруулсан:

**Б.Энхсайхан, ЖТБҮХ-ны ажлын
албаны дарга**

**М.Болормаа, Эмэгтэй Удирдагч
сангийн тэргүүн**

Хянасан:

**Д.Мөнхөө, НҮБ-ын Хүн амын сангийн
жендэрийн асуудлаархи**

Үндэсний зөвлөх

Улаанбаатар, 2009 он

ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААР ТОВЧ ТАЙЛБАР

Жендэр, жендэрийн тэгш байдал хэмээх нэр томъёо монгол хэлэнд, манай нийгмийн амьдралд орж ирээд 20 шахам жил өнгөрч байгаа ч утга агуулга нь бүрхэг хэвээр тул эндүү ташаа, дутуу дулимаг ойлгох явдал гарсаар л байна. Үг нь жендэр судлалын шинжлэх ухаан нь түүх, гүн ухаан, нийгэм судлал, хүн судлал, сэтгэл судлал, биологи, анагаах ухаан зэрэг олон шинжлэх ухааны уулзвар дээр үүсч хөгжиж эхэлснээс хойш 40 гаруй жил өнгөрөхөд нийгмийн удирдлагад нэвтэрч олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны салшгүй хэсэг нэгэнтээ болжээ. Гэвч нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны хөгжил сул, үзэл бодлын хувьд хаагдмал байсан улс орнуудын хүн амын олонхи жендэрийн тэгш байдлын тухай ойлголтыг бүү хэл, жендэр хэмээх үгийг ойлгохгүй байна.

Эртний латин хэлний *genre* хэмээх үг нь хэлбэр, төрөл, хэв маяг гэсэн утгыг илэрхийлэх ба европын олон хэлэнд уламжлагдан хэрэглэгдсээр ирсэн нь жендэр хэмээх үгийн үндэс болсон байна. (Жишээ нь урлаг, утга зохиолын хүрээнийхэн франц хэлнээс орос хэлээр дамжуулан авч хэрэглэх болсон «жанр» хэмээх үг нь үүний нэг жишээ юм.)

Жендэр (gender) хэмээх үгийг бүр дундад зууны үеийн европын дээд зиндааныхан хүйсийг заахад хэрэглэдэг байсан баримт бий. Жендэр, жендэрийн тэгш байдлын тухай ойлголт нь ялангуяа соёлын уламжлалт чиг баримжаатай орнуудад барууны үзэл суртлын нэгэн хэсэг, үндэсний соёл уламжлалыг гүйцэтгэх дайсан мэтээр ойлгогдох явдал нэлээд түгээмэл байдаг нь нэг талаар мэдлэг мэдээлэл дутмагаас, нөгөө талаар жендэрийн тэгш байдлыг улс орныхоо хөгжилд ашиг тустай тохиромжтой хэлбэрээр үндэсний соёл уламжлалтайгаа нийцүүлэн хөгжүүлэх арга барил, чадвар дутмагаас болдог ажээ. Мөн барууны орнуудын түүхэн нөхцөл байдлаас үүдэн өрнөсөн эмэгтэйчүүдийн эрхийн төлөө хөдөлгөөн (энэ хөдөлгөөн нь сонгуулийн эрхийн төлөө, тэнцүү цалин хөлсний төлөө, үр хөндүүлэх эрхийн төлөө г.м олон хэлбэрээр өрнөж ирсэн ба үзэл бодлын хувьд либерал, радикал, марксист, пост колонийн, гуравдагч ертөнцийн гэх зэрэг өөр хоорондоо зөрчилдөгч олон урсгал чиглэлтэй байдаг ч манайд феминизм хэмээх ганцхан үгэнд багтаан ойлгох нь түгээмэл байна) эргэлзээ болгоомжлол төрүүлдгийг дурьдахаас аргагүй. Үнэн хэрэгтээ энэ бүх айдас эргэлзээ л «жендэрийн асуудал манайд байхгүй, эсвэл манайд ярих шаардлагагүй» гэхээс эхлэн «гэр бүлийн харилцаанд хөндлөнгөөс оролцох гэж байна, эцгийн эрхт ёсыг устгах гэж байна» гэх хүртэл байдлаар эсэргүүцэх шалтгаан болдог.

Жендэр хэмээх ойлголт нь (нийгмийн хүйс ч гэж нэрэлдэг) хамгийн товчоор хэлбэл эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд байдаг биологийн үүсэл бүхий хүйсийн ялгаатай шинж байдлыг, мөн тэдгээрээс үүдсэн гүйцэтгэх үүргийн, гэр бүл, нийгмийн зүгээс хүлээх хүлээлтийн ялгаатай байдлыг илэрхийлэх зориулалттай. Хүйсийн ялгаа тогтвортой байдаг бол жендэрийн

ялгаа нийгэм бүрт өвөрмөц шинж төрхтэй мөн хөгжлийн явцыг даган цаг хугацаанд хувирч өөрчлөгддөг гэж үздэг. Энэ нь улс орнуудад жендэрийн тэгш байдлын ойлголтыг өөрсдийн соёл, нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн уян хатнаар хэрэглэх боломж олгодог. Эмэгтэйчүүдэд, эмэгтэйчүүдийн хоорондын харилцаа нь зөвхөн биологийн үүсэл гаралтай бус, харин нийгмийн нөлөөллөөр төлөвшиж байдгийг харуулснаараа жендэрийн тухай ойлголт нь бас эмэгтэй эрэгтэй хүмүүсийн шинж төрх, тэдний хоорондын харилцаан дахь нийгэм, соёлын нөлөөг тооцох, залж удирдах боломжийг олгодог.

Жендэрийн тэгш байдал нь орчин үеийн утгаараа хүйсүүд биологийн хувьд ялгаатай гэдгийг, мөн түүнээс үүдэн гэр бүл, нийгэмдээ гүйцэтгэх үүрэг нь ялгаатай байж болохыг хүлээн зөвшөөрч, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хэрэгцээ болон амьдралд нь нөлөөлөх хүчин зүйлс адилгүй байдгыг харгалзаж үзэхэд чиглэдэг. Ялгаатай хэрэгцээ, хүчин зүйлийг нь анхааран үзэж бодлого төлөвлөлтөд тусгах замаар эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хэн хэн нь сонголт хийх боломжтой байж, бүрэн дүүрэн амьдрах нөхцөл болоцоог нь бүрдүүлэхэд жендэрийн тэгш байдлыг хангах ажлын мөн чанар оршдог.

Жендэр болон жендэрийн тэгш байдлын талаар бүрэн гүйцэд зөв ойлгож хэрэглэхэд өнөөдөр нийгэмд хэрэглэж буй олон нэр томъёог ялган салгаж ойлгох нь чухал байдаг. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг бөгөөд жендэрийн тэгш байдалтай хамгийн их анхаарагддаг хүйсийн тэгш эрх, жендэрийн хүйсийн тэнцвэрт байдал хэмээх хоёр ойлголтыг товч авч үзье.

Хүйсийн тэгш эрх нь олон улсын баримт бичгүүдэд англи хэлээр **gender equity** хэмээн бичигдсэн байдаг нь барууны ертөнцөд эмэгтэйчүүдийн сонгууль өгөх эрхийн төлөө, өв хөрөнгөө эзэмших, эрчүүдтэй адилхан ажил хийгээд тэнцүү цалин хөлс авахын төлөө хөдөлгөөн эрчимтэй өрнөж байх үеийн тусгал болсон нэр томъёо бөгөөд тоон үзүүлэлтээр болон тодорхой зүйл, заалтаар хэмжих боломжтой зүйлстэй илүү холбоотой учир “хүйсийн” хэмээн монгол хэлнээ утгачлан орчуулсан нь илүү тохиромжтой байдаг. Хүйсийн тэгш эрх нь жендэрийн тэгш байдлын нэгэн хэсэг байж болох ч бүрэн илэрхийж чадахгүй.

Жендэрийн тэнцвэрт байдал (gender parity) хэмээх ойлголт нь тооны харьцааг илэрхийлэх ба мөн л жендэрийн тэгш байдлын үзүүлэлт болгон хэрэглэгддэг боловч утга агуулгыг нь бүрэн илэрхийлж ч, хэмжиж ч чаддаггүй. Жишээ нь ямар нэгэн асуудлаар шийдвэр гаргахаар хэлэлцэж буй хүмүүсийн хагас нь эмэгтэй, хагас нь эрэгтэй байж, өөрөөр хэлбэл жендэрийн тэнцвэрт байдал дээд зэргээр хангагдсан байлаа. Энэ нь шийдвэрт хоёр хүйсийн санал бодол тэнцүү хэмжээгээр нөлөөлж байгаа эсэхийг ч гаргасан шийдвэр нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн аль алийхнийх нь эрх ашигт нийцэж байгаа эсэхийг ч харуулж чадахгүй юм.

Эх сурвалж: ЖТБҮХорооны ажлын албанаас бэлтгэсэн тайлбар, 2009, 12 сар

ЗҮҮН АЗИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТББ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН VI ЧУУЛГАН

Зүүн Азийн эмэгтэйчүүдийн ТББ-дын төлөөлөгчдийн VI чуулган 2006 оны 7-р сарын 18-20-ны өдрүүдэд Бээжин хотноо болов. Тус чуулганыг БНХАУ-ын Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн Холбоо хариуцан зохион байгуулсан. VI чуулганд БНХАУ, Япон, БНСУ, БНАСАУ, Монгол зэрэг 5 орны 50 гаруй байгууллагын 295 төлөөлөгчид оролцов. Мөн Гонконг, Макао, Тайваний эмэгтэйчүүдийн төлөөлөл оролцсон. БНХАУ-ын БХЭХолбооны бүх хот, муж, дүүргийн эмэгтэйчүүдийн төлөөлөл өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон.

МАСЭХ-ны тэргүүн Д.Алтай, дэд тэргүүн Г.Идэрмаа нар БХЭХолбооны тусгай урилгаар биечлэн оролцов.

Монгол улсаас ЛЭОС (Ц.Энхтуяа), Хүчирхийлэлийн Эсрэг Үндэсний төв (Д.Энхжаргал), Эх орон намын Гэр бүл эмэгтэйчүүдийн холбоо (Б.Цэцэгмаа), Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбоо (О.Сэлэнгэ) зэрэг ТББ-ын төлөөлөл 11 хүн оролцов.

Тус чуулган үндсэн болон салбар хуралдааныг зохион байгуулж, Бээжингийн чуулганы Тунхаглал батлан гаргав.

Зүүн Азийн эмэгтэйчүүдийн ТББ-дын чуулган анх 1994 онд Японы нийслэл Токиод болсон ба энэ бүс нутгийн эмэгтэйчүүдийн ТББ-дын хамтын ажиллагаа, найрамдалт харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн байна. Энэхүү чуулган нь энэ бүс нутгийн эмэгтэйчүүд түршлага мэдээлэл солилцох, төсөл хэрэгжүүлэх санаа оноо олж авах чухал механизм болон хөгжиж иржээ. Зүүн Азийн эмэгтэйчүүдийн ТББ-дын III чуулган Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо 1998 онд зохион байгуулагдаж байсан.

МАСЭХ-ны тэргүүн Д.Алтай **«Бодлого боловсруулж шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн тэгш оролцоо»** (англи хэл дээр тавьсан энэхүү илтгэлийг дор хавсаргав) сэдвээр болсон салбар хуралдаанд улс төрд эмэгтэйчүүдийн боломж, тэдэнд тохиолдох бэрхшээл болон улс төр дахь эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо, чадавхийг бэхжүүлэх асуудлаар үндсэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Мөн ХЭҮТөвийн тэргүүн Д.Энхжаргал салбар худалдаанд үндсэн илтгэл тавьсан. Нээлтийн хуралдаанд Монгол улсыг төлөөлөн ЛЭОСангийн тэргүүн Ц.Энхтуяа баяр хүргэж үг хэлсэн.

Speech to be delivered at the sixth East Asian Women's Forum

Sub theme:

Women's equal participation in decision making and management
Opportunities and challenges for women in politics
Role and capacity building of women in politics

Speech maker:

Ms.D.Altai, Phd, Chairperson of the Mongolian Democratic Socialist Women's Association (MDSWA)

After the 2004 State Great Hural/Parliament/ election, women's representation in the Mongolian Parliament decreased from 11.8 percent to 6.5 percent and the involvement and voice of women in decision-making and policy developing levels declined. One female Deputy Speaker and one female Minister who were appointed as a result of the 2004 SGH and negotiation of the coalition government respectively, are no longer in their positions anymore.

However, studies show that, after the 2004 local elections, women's representation in middle and lower level would tend to increase rather than decline.

Based on our today's reality that exploiting women's education, experience, ability to perform tasks neatly and responsibly in the field of politics and decision – making and reflecting their voice was limited, the first forum “Women's partnership in politics and governance” was organized. We are not satisfied with the lack of women's contribution to making the democratic development more fair, open, plural and accountable. Conditions such as few men who dislike sharing their power, the old and traditional stereotype within the society, lack of support for female candidates from some women and the will of political parties all contribute to it.

On 25-27 April 2005, the first forum titled “Women's partnership in politics and governance” was organized jointly by the women's organizations of parliamentary seated political parties women's organizations-MPRP, Democratic Party, Citizen's Will Party and Motherland Party.

“Women's partnership in politics and governance” was organized in order to overcome this obstacle, in particular, creating favorable legal environment, amending relevant rules and procedures, developing male politician's willingness to improving duties and responsibilities of political parties all of which are directed at improving gender awareness of parliamentary seated political parties and increasing women's political participation.

The main concept of the “Ikh Tenger Declaration” is for parliamentary seated political parties to nominate at least 30% of female candidates to all levels of party elections in cooperation with women's organizations within them, develop legal environment ensuring gender equality, strengthen democratic accomplishments in the regions, support stability, direct creative

participation and initiative of the people to public activities and in addition, we bore the responsibility to require transparency, accountability and ethics from politicians.

What have we accomplished for the implementation of the “Ikh Tenger Declaration” during the last year?

1. We have established a NGO titled “Women’s partnership in politics and governance”, which would serve as the mechanism for stable and permanent cooperation among women’s organizations of parliamentary seated political parties. The NGO was registered with the Ministry of Justice and Domestic Affairs.
2. In relation to including a provision on nominating no less than 30% of female candidates, which was included in the “Ikh Tenger Declaration” in the “SGH Election Law”, the provision was passed by the SGH on December, 2005. Therefore we launched various activities to accomplish our plans for 2006-2007, within the “Ikh Tenger Declaration”. In 2006, we are planning to organize 4 regional seminar and discussions involving all 21 aimags for female candidates, male managing officials and citizens. In addition, we agreed to intern 4 young women from all four women’s organizations in International Republican Institute /IRI/ on gender equality and women’s political participation. Also we will publish and distribute 10.000 women’s seasonal bulletins for local women with the support of USAID and IRI.
3. Also progressive steps were taken in getting the quota included in party rules and procedures and providing special seats for women in party governing body elections.

The 24 th Congress of the MPRP which was held in June of 2005, decided that “No less than 25 percent of candidates for all levels of party elections shall be female”. The same provision was included in the party rule during the party conference held on 12 December 2005 in its nominating, electing, appointing activities.

The Democratic Party 3 rd convention was held in spring 2006 recently and it decided to allocate 50 out of 250 National Consultative Committee seats to women.

The Citizen’s Will party, which is chaired a woman, had included the 30% quota in its rule and over implementing the rule and setting examples for other parties.

The Motherland party has 20% quota for women in highest governing body election and agreed to increase the number to 30% during its convention.

4. The National Council on Gender Equality which implements the “National Programm on Gender Equality” was transformed into a National Committee by the coalition government which was formed as a result of 2004 SGH election and the UNIFEM, in May 2005, National

Committee on Gender Equality conducted a seminar titled “Strategic Planning Workshop on gender” and concluded activities conducted for the 1st phase of the program and discussed its future plans. MDSWA and SGH Social Policy Committee jointly held by supporting F.Evert Foundation of the Germany four roundtable discussion on “Gender equality in family relations”, “Gender equality in economic relations”, “Gender equality in power and decision - making”, “Gender equality in rural development” involving SGH and cabinet members, gender experts of ministries, international and women’s organizations, other women’s NGOs. Its recommendation was submitted to relevant organizations and its implementation is being the focus of the MDSWA.

5. In April 2005 the Parliament of Mongolia adopted resolution on Mongolia Specific Millennium Development Goals, which includes an additional MDG 9 Goal on “Promote Democratic Governance and Human Rights”. This historic resolution has adopted specific targets under all MDGs to be achieved by 2015. For example, with to gender issues it stipulates 100 percent gender equality in primary, secondary and higher education by 2015, increased ratio of female candidates in Parliament election to 35 percent and women representation at the Parliament to 30 percent by 2015. According to the resolution the Government of Mongolia will report the progress on the national MDGs every two years to the Parliament.

Although we have made progress in implementation of the “Ihk Tenger Declaration”, we are facing the following challenges as well:

- Implement incremental and effective activities by the Forum on improving gender awareness of male leaders and policy makers of political parties
- Conduct regular public awareness activities on gender equality and women’s political participation issues and work closely with journalist and mass media
- Prepare future female candidates, leaders and their new generation from well-known businesswoman, manager and leaders through special program, club and project and publicize images to voters.
- Work on getting gender equality issues reflected in SGH future elections and conduct negotiations and talks on increasing women’s representation in the Parliament and Government and jointly create such system.
- Organize specific activities to improve political education of the citizens voters.

Thank you for you attention.

18-20, JULY 2006

BEIJING

CHINA

СОЦИНТЕРНИЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАЙГУУЛЛАГЫН 100 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭ

МАХН-ын дэргэдэх МАСЭХ-ны тэргүүн Д.Алтай тэргүүтэй тус холбооны төлөөлөгчид ХБНГУ-ын Штутгарт хотноо 2007 оны 9 сарын 7-8-ны өдрүүдэд Социалист Интернационал Эмэгтэйчүүд байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээнд оролцсон юм. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Нийслэлийн АСЭХ-ны дарга Д.Баярсайхан, МАХН-ын ҮЗ-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн ажилтан С.Уянга, Монгол телевизийн сурвалжлагч Ч.Сүндэр нар багтсан. СИЭ байгууллагын товчооны хурал 2007 оны 9 сарын 7-ны өдөр зохион байгуулагдав. Энэ удаагийн Товчооны хурлаар санхүүгийн тайлан, зохион байгуулалтын асуудал, Штутгартын Түнхаглалыг хэлэлцэж батлах, СИЭ байгууллагын ээлжит их хуралд бэлтгэх зэрэг асуудлыг хэлэлцэв. Мөн энэ хурлын үеэр Социнтерний гишүүн намын төлөөлөгчид, хүндэт зочид, хэвлэл мэдээллийн байгууллагынхан гэсэн өргөн бүрэлдэхүүн оролцсон нээлттэй чуулган болов. Энэхүү чуулганаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, жендэрийн тэгш байдал, нийгэм-улс төр, эдийн засаг, олон улсын байдал, глобальчлал, дэлхийн дулаарал зэрэг өргөн хүрээтэй асуудлаар хэлэлцүүлэг хийж санал солилцсон.

Энэхүү хэлэлцүүлэгт МАХН-ын эмэгтэйчүүдийн байгууллагын Тэргүүн, доктор /PhD/, профессор Д.Алтай Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн байдал, цаашдын зорилт төлөвийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл хийв. (Мэдээллийг ард англи хэл дээр хавсаргав)

СИЭ байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээ нь 2007 оны 9 сарын 8-ны өдөр зохион байгуулагдав. Энэ баярын үеэр хүндэтгэлийн нээлтийн ёслол болж түүнд Социнтерний ерөнхийлөгч Ж.Папандреу, СИЭ байгууллагын ерөнхийлөгч П.Локателли, ХБНГУ-ын СДН-ын дэргэдэх Социал-Демократ Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүн, СДН-ын дэд дарга Е.Фернер, Штутгарт хот харъяалагддаг Баден-Вюртембург Холбооны Улсын СДН-ын дарга У.Вогт нар оролцож үг хэлэв. Мөн жендэрийн тэгш эрхийг хангах чиглэлд сайн түршлага хуримтлуулсан Испаний Засгийн газрын тэргүүн дэд ерөнхийлөгч Т.Вега, Чилийн Эрүүл мэндийн сайд М.С.Барриа нар оролцож мэндчилгээ дэвшүүлэв. Мөн төр, засгийг тэргүүлж буй олон орны эмэгтэй удирдагчдын видео мэндчилгээг үзүүлсэн.

Баярын үеэр Шведийн улс төрч, судлаач И.Карлссоны бичсэн «Нэгдэх зуун жил-СИЭ-ийн товч түүх» нэртэй номын танилцуулга болов. Дараа нь 1995 онд Бээжин хотноо болсон НҮБ-ын эмэгтэйчүүдийн

асуудлаархи IV Бага хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Африкийн нэртэй улс төрч эмэгтэй Гертруда Монгелад тусгай шагнал гардуулах ёслолын ажиллагаа болсон.

СИЭ байгууллагын 100 жилийн ойд зориулсан гол арга хэмжээ нь үдээс өмнө ба хойно болсон «Эмэгтэйчүүд эрх мэдэл бүхий албан тушаалд», «Үе үеийнхний үзэл бодол, байр суурь» гэсэн 2 сэдвээр зохион байгуулагдсан дугуй ширээний ярилцлага байлаа. Энэ ярилцлагын үеэр Европ, Африк, Латин Америк, Ази тивийн Социнтерний гишүүн улс төрийн намуудын эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөгчид, үе үеийн улс төрийн зүтгэлтнүүд өөрсдийн туршлагаасаа ярьж, мэдээлэл солилцож эмэгтэйчүүдэд тохиолддог нийтлэг ололт амжилт, бэрхшээл зорилтын талаар чөлөөтэй ярилцаж, сэтгүүлчдийн сонирхсон асуултанд хариулав.

МАСЭХ-ны Тэргүүн Д.Алтай «Эмэгтэйчүүд эрх мэдэл бүхий албан тушаалд» сэдвээр зохион байгуулсан дугуй ширээний ярилцлаганд Ази тивийг төлөөлөн үндсэн илтгэгчээр оролцов. Тэрээр Монголын эмэгтэйчүүдийн хувьд парламентад сонгогдон ажиллах давуу тал, сонгуульд нэр дэвшин өрсөлдөх, компанит ажилд тохиолддог бэрхшээл, эмэгтэйчүүдийн асуудалд тулгардаг уламжлалт хандлага ойлголт, түүнийг даван туулах арга зам, намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагууд хамтран ажиллаж буй арга туршлага, цаашдын зорилт зэрэг асуудлыг хөндөн үзэл бодол, байр сууриа илэрхийлэв. (Илтгэлийг ард англи хэл дээр хавсаргав)

СИЭ байгууллагын 100 жилийн баярын оройн арга хэмжээг Европын Парламент дахь Социалистуудын Бүлэг зохион байгуулж, дуу бүжиг, харилцан мэндчилгээ дэвшүүлэх зэргээр ойр дотно танилцах дулаан уур амьсгалд тэмдэглэв.

SOCIALIST INTERNATIONAL WOMEN BUREAU MEETING

By Dr. Altai.D

Chair, MDSWA, Mongolia

Dear Delegates and SIW fellows,

Distinguished Guests and Friends,

I have a great pleasure to extend our heartfelt congratulation to You for the 100 Year Anniversary of the Socialist International Women, on behalf of all women of Mongolia, a country of Central Asia. We wish you every success for the struggle of freedom, justice and solidarity.

We, the Mongolian Democratic Socialist Women's Association, under the Mongolian People's Revolutionary Party, are very proud of cooperating with you since 1999, in the family of the Socialist International, to promote democracy, justice and equality.

Mongolia is a sparsely populated land locked developing country of some 2.5 million inhabitants. It has been 16 years since Mongolia has undergone a complex social, political and economic reform. The process of transition in Mongolia towards democracy and market economy has been implemented with ups and downs. It has initially experienced some serious economic and social constraints and challenges. Especially, a severe economic crisis during the period of 1990-1994 caused enormous social problems; unemployment and poverty have gone far.

The economic revival that has emerged since 1995 led to some progress in growth rate in GDP. It marked 4.0 in 2002 and grown up to 8.5 percent in 2005. In spite of this economic growth, there has been a little progress in improving quality of life, reducing inequalities and poverty of population. Official figures suggest that around one third of the total population live in poverty and many others find themselves close to the poverty line.

Mongolia's Constitution, newly enacted in 1992, established a multi-party system, democratic elections of representatives at all levels of governance. National and local parliamentary elections and elections of president have been held four times since 1990, however it should be noted that overall participation of citizens in both national and local elections has tendency to decline. Our constitution provides equal rights for men and women and this fact proves the existence of favorable conditions in Mongolia for achieving gender equality.

Mongolian women who constitute over 50 percent of the country's population play an important role in the society. For example, women comprise about 49 percent of the work force, 51 percent of graduates in higher education, 58 percent of professional and technical staff, 79 percent of teachers and 82 percent of medical personnel.

While women and girls are doing well in some areas, they are significantly lagging in representation at election-making levels and more

women are become victims of poverty, unemployment, violence and gender-based discrimination in labor market.

Women representation in the Parliament was 11.8 percent in 2001, but decreased by 6.5 percent after result of the last election in 2004.

In 2002, the Government of Mongolia has adopted the National Programme on Ensuring Gender Equality and the National Committee on Ensuring Gender Equality headed by the Prime Minister was an important role to implement this programme. In 2005, the Parliament has adopted the resolution on supporting and implementing the Millennium Development Goals.

This historic resolution has adopted specific targets under all MDGs to be achieved by 2015. For example, with regards to gender issues, it stipulates 100 percent gender equality in primary, secondary and higher education by 2015, increased ratio of female candidates in parliament election to 35 percent and women representation at the Parliament to 30 percent by 2015. According to the resolution, the Government of Mongolia will report the progress of the national MDGs every two years to the Parliament.

What are we, the Association and the Mongolian women, doing to increase representation of women in politics?

1. We are working for constituting favorable condition in legal system which supports women participation in political party charters, electoral laws and other related laws. For instance, the MPRP has adopted women quota increase in the revised charter by the 24th Congress which was held in 2005. It says in the charter, "No less than 25 percent of candidates for all party structure elections shall be female". This proves that we are implementing the resolutions of the Socialist international and Socialist international Women. It was also enacted in new law on election of Parliament of Mongolia that "at least 30 present of all candidates from any political parties and coalition shall be female". Today our party has majority seats in the Parliament /38 out of 76/ and Chairman of our party, Mr.Enkhbold is leading the Government of National Unity.
2. Women's organizations of political parties which have seats in the Parliament have cooperated and initiated women's network. In 2005, a forum on "Women's partnership in politics and governance" was organized by this network and adopted "Ikh Tenger Declaration" which is aimed to influence male politicians and political parties, to cooperate with them and increase gender perceptions of citizens and voters. Women NGOs, in particularly partnership between women organizations of political parties is important to influence social psychology, to effect positively, to accept women politicians and social leaders in the society and to support them.
3. It is very important for woman to develop our dream to be politics, to prepare ourselves and to introduce ourselves in society, in politics and

voters. From 2006, our Association is working in club system in order to help women to be a candidature for all structure elections. We are cooperating with foreign organizations such as Fredrich Ebert Stiftung from Germany, International Republican Institute from the United States on different projects, moreover organizing trainings, regional conferences, roundtable meetings, and also media advertising and research works.

4. We have much more things to learn from women of Socialist International sister parties in order to change traditional perception and stereotype in the society that “Only men do politics”, to cooperate with male politicians and take their support. Especially experiences of countries that have increased women political participation and succeed in gender equality field, are crucial examples. This, SIW Bureau meeting is a specific to coincide with the 100 Year Anniversary of the SIW. We are delighted for this good opportunity to exchange our view and information and learn from each other.

Taking this opportunity, I would like to express our deep gratitude to the host organization, the Federation of Social Democratic Women of the Social Democratic Party of Germany.

I would like to wish You, equal members of Socialist International family-women of all over the world, political leaders of different generations, who are gathering for the theme “One Hundred Years in the Forefront of Gender Equality”, prosperous growth, more success, endless joy and good health.

Thank you for the attention.

7 SEPTEMBER, 2007

STUTTGART

GERMANY

**ONE HUNDRED YEARS IN THE FOREFRONT
OF GENDER EQUALITY**

**SIW CENTENARY
STUTT GART, GERMANY, 8 SEPTEMBER 2007**

Roundtable: Women in positions of power

Moderator: Sylvie Coyaud, Journalist

Presentation by Dr. Altai Dulbaagiin, Chair, MDSWA, Mongolia

Dear Delegates and SIW fellows

Distinguished quests and Friends.

I am honored to represent women of Mongolia at this Centenary of the Socialist International Women. I have a great pleasure to extend our warmest congratulation to you for the 100 years Anniversary of the SIW.

Furthermore, I would like to express our sincere gratitude to the leaders of the SIW and the Federation of Social Democratic Women of the Social Democratic Party of Germany for your great efforts in organization of such historic event.

First, I would like to give you a brief introduction of my life experience.

I am a Doctor of Philosophy in history and have been working as a professor and research fellow at universities and research institutes for over 20 years. I'm married and have two daughters.

Since 1992, I have been involved in politics. I have been elected as a Member of Conference of the MPRP and a Member of Steering Council of the MPRP. In 1994, together with my comrades I have initiated to establish women's organization under the MPRP and since then I have been working as a Chair of this organization. Since 1999 our party and MDSWA joined the SI and SIW.

I was elected as a Member of the Parliament of Mongolia during 2000-2004 and was a Member of Social Policy and State Structure Standing Committees. At this duty, I have initiated and took active part in formulating bills on ethics of high ranking state officials, on education and law on fighting against family violence. I worked in close cooperation with other MPs on renewing various laws related to strengthening parliamentary democracy in my country, including act on State Great Hural (Parliament) and others. At the same time, I have been working as a Secretary General of the Mongolian Parliamentary Group and several times represented Mongolia in IPU conferences and meetings. In 2004, I also was elected as a Substitute Member of the Coordinating Committee of Women Parliamentarians of the IPU, Group of Asia and Pacific countries.

Second, based on my experience I would like to try to answer to the question “What are the challenges and advantages of being elected in parliament as a women member?”

1. Increase of female representation in the Parliament with 93.5% male members, like Mongolia, would clearly indicate opportunity for transparency and openness. Thus, participation of women, that comprises 50 percent of total population and voters, shall be represented in the parliament. This would provide some opportunity of women to have their participation, send their voice and express their interests in the society.
2. Women participation in policy formulation and decision-making process would allow diverse, human centered and faultless policy decisions to be made because women give more importance to children, family, elderly, social welfare, social security and environment issues.
3. It is much more difficult for women to be nominated by a political party as an election candidate because the party has a fear to loose the seat, if it would have too many female candidates. Due to traditional approaches, voters, particularly women voters' mostly feel cautious to vote for women.
4. Wealthy businessmen and influential male politicians tend to be a good candidate for any political party, since they are able to provide financing as much as necessary during election campaign. Particularly, women candidates seem to loose to wealthy businessmen candidates due to financial constraints.
5. Another obstacle is to undergo with stereotype approach to react towards women. Therefore, it is important to improve political education of citizens and voters, to advertise positive images of women politicians using different media and constitute favorable condition in political parties and society to support women candidates. In my opinion, this would be achievable through active cooperation of women NGOs organizations, partnership and understanding with male politician's voters and their support for women.

Thank you for the attention

**8 SEPTEMBER 2007
STUTTGART
GERMANY**

**“СОНГУУЛЬ БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО” СЭДЭВТ
ОЛОН УЛСЫН ЧУУЛГАН**

2008 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Төрийн ордны «Б» зааланд «Сонгууль ба эмэгтэйчүүдийн оролцоо» сэдэвт чуулганыг ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сан, Улс Төр ба Засаглалд Эмэгтэйчүүдийн Түншлэл, АНУ-ын Олон Улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэнгээс хамтран зохион байгуулж Фридрих-Эбертийн сангийн суурин төлөөлөгч Роланд Файхт нээж үг хэллээ.

Олон улсын чуулганд ХБНГУ, АНУ-ын төлөөлөгчид, 4 намын эмэгтэйчүүдийн байгууллага, Иргэний нийгмийн байгууллагууд болон төр засгийн удирдлагууд, судлаачид оролцлоо.

Тус чуулганд МАСЭХ-ны тэргүүн хатагтай доктор, профессор Д.Алтай «Монголын эмэгтэйчүүдийн өнөөгийн байдал, бэрхшээлтэй асуудлууд», ХБНГУ-ын Бундестагийн гишүүн хатагтай Үте Кумф «ГСДН-ын эмэгтэйчүүдийн байгууллагын квотын механизмыг хэрэгжүүлсэн туршлага», АЭХ-ны тэргүүн хатагтай Б.Дэлгэрмаа «Сонгуулийн систем ба эмэгтэй нэр дэвшигчид», АНУ-ын Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн Монгол дахь төслийн захирал Ж.Де Витт «Дэлхий дахинаа ардчиллыг бэхжүүлэхэд эмэгтэйчүүдийн үүрэг», Иргэний Зориг ЭХ-ны тэргүүн хатагтай доктор Ч.Базар «Сонгогчдын эрэлт хэрэгцээ ба эмэгтэй нэр дэвшигчид», «Эх орон-гэр бүл» эмэгтэйчүүдийн холбооны дэд тэргүүн хатагтай Оюунбилэг «Сонгуулийн компани ажлын хөрөнгө босгох нь» сэдэвт илтгэлүүд тавьж хэлэлцүүлэв.

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БЭРХШЭЭЛТЭЙ АСУУДЛУУД

Илтгэгч: МАХН-ын дэргэдэх МАСЭХ-ны тэргүүн, доктор /PhD/,
Удирдлагын Академийн профессор Д.Алтай

Илтгэлийн төлөвлөгөө:

1. Монгол орон, эмэгтэйчүүдийн өнөөгийн байдал
2. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага
3. Тулгамдаж буй зорилт бэрхшээлүүд

Монгол орон, эмэгтэйчүүдийн өнөөгийн байдал

1990 оноос Монгол орон ардчилсан өөрчлөлтийн замд тууштай шилжсэнээр улс төр-эдийн засаг, нийгэм-соёлын хүрээнд гүнзгий шинэчлэл хийгдэх үйл явц эхэлсэн. 1992 онд шинэ үндсэн хууль батлагдаж, Монгол улс парламентын Бүгд Найрамдах Улс байхаар тунхагласан ба хүний эрх, эрх чөлөөг хангах, өмчийн олон хэлбэр, чөлөөт өрсөлдөөнд суурилсан эдийн засгийн бүтэц байгуулах, ардчилсан, чөлөөт сонгуулийн үндсэн дээр парламент, орон нутгийн ИТХурлыг байгуулах, Ерөнхийлөгчөө нийт ард түмнээс сонгох явдлыг хуульчлан бататгасан.

Монгол Улсын нийт хүн амын 50 гаруй хувийг эзэлдэг Монгол эмэгтэйчүүд нийгэмд онцгой чухал үүрэг гүйцэтгэдгийг дараах тоо баримт харуулж байна. Эмэгтэйчүүд хөдөлмөрийн насны хүн амын 51 хувь, нийт ажиллагчдын 49 хувь, ЕБСургууль төгсөгчдийн 51 хувь, их дээд сургуульд суралцагчдын 61 хувь, дээд боловсролд хамрагдагсдын 73 хувь, мэргэжлийн болон техникийн албан тушаалд ажиллагсдын 58 хувь, нийт багш нарын 79 хувь, эмнэлгийн байгууллагад ажиллагчдын 82 хувийг тус тус эзэлж байна. Дээр нь Монголын эмэгтэйчүүд аливаа сонгуульд хамгийн идэвхтэй оролцдог ба нийт сонгогчдын 50 хувь, улс төрийн гол намуудын нийт гишүүдийн 40-50 орчим хувийг бүрдүүлж байна.

Эмэгтэйчүүдийн аж байдалд тодорхой ахиц ололт байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж байгаа, нэн ялангуяа шийдвэр гаргах түвшинд жендэрийн төлөөлөл хангалтгүй байна. Мөн эмэгтэйчүүд ядуурал, ажилгүйдэл, хүчирхийлэл, хөдөлмөрийн зах зээл дээрх ялгаварлалд ихээхэн өртөж байгаа талаар судалгааны үр дүн харуулж байна. Тухайлбал “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгаа”-гаар /ДБ, НҮБ ХХ, ҮСГазар/ нэн ядуу өрхийн 25, нийт ядуу өрхийн 18 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна гэсэн дүн гарчээ. Зээл тусламж авахад хөрөнгийн хууль ёсны эзэмшигч нь ихэвчлэн эрэгтэйчүүд байдаг тул эмэгтэйчүүд зээл тусламж авахад барьцааны хөрөнгө байдаггүй нь судалгаанаас /НХХЯ, НҮБХХ/ харагджээ. Эмэгтэйчүүдийн гуравны нэг нь ямар нэгэн хэмжээгээр хүчирхийлэлд

өртсөн дүн АХБ, Дэлхийн Банкнаас Монгол улсын жендэрийн байдалд хийсэн судалгаанаас гарсан байна.

Сүүлийн үед хүн наймаалах хэрэгт эмэгтэйчүүд, өсвөр насны охид, хүүхдүүд өртөх болсон гэмт хэргийн жишээ багагүй тэмдэглэгдэх болов.

Жендэрийн тэгш байдлыг хангах талд 1996 онд Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хөтөлбөр, 2002 онд ЖТБХҮХөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж байна. Хүйсийн тэгш байдлын асуудлаархи Үндэсний Зөвлөлийг 2001 онд байгуулан ажиллаж, тус зөвлөлийг 2005 онд Жендэрийн Тэгш Байдлын Үндэсний Хороо болгон өөрчилж, ажлын албатай болгосон.

Монгол улс Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци зэрэг олон улсын гэрээ, конвенцид нэгдэж орсноос гадна ЖТБХҮХөтөлбөрийг 2002-2015 он хүртэл хэрэгжүүлэхээр /МХЗорилтын хэрэгжих хугацаатай ижил/ баталсан ба түүний эхний I, II шатны хэрэгжилтийн байдал шаардлагын түвшинд хүрэхгүй байна. УИХ-ын зарим гишүүд, гадаадын эксперт судлаач, ТББ-дын хамтын оролцооны үндсэн дээр “Эмэгтэй, эрэгтэй хүний тэгш эрх, тэгш боломжийг хангах тухай” хуулийн төслийг боловсруулаад байна.

Монгол улсын ЗГ, УИХ Монголд жендэрийн тэгш байдал бий болгох, гэр бүлийн болон жендэрээс улбаатай хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 1999 онд Гэр бүлийн тухай, 2004 онд Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг баталж, МУ-ын Засгийн газар 2007 онд Гэр бүлийн хүчирхийллийн Үндэсний хөтөлбөрийг баталсан.

Олон улсын өмнө гэрээ конвенциэр хүлээсэн үүргийн дагуу УИХ-ын хууль, ЗГ-ын хөтөлбөрийг амжилттай батлах явдал нэг хэрэг, харин түүнийг хэрэгжүүлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах, практик үр дүнд хүрэх явдал нэн чухал болж байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ, зорилт

1992 онд УИХ-ын сонгуулийн тухай шинэ хууль батлагдаж 76 гишүүнийг томсгосон 26 тойргоор сонгох мажоритор тогтолцооны үндсэн дээр сонгох анхны сонгууль болов. Сонгуульд нэр дэвшүүлэх үйл явц улс төрийн олон намуудын хоорондын болон нам доторхи чөлөөт өрсөлдөөний үндсэн дээр явагдаж эхэлсэн. 1980-аад оны сүүлчээр АИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 24,9 хувьтай байсан бол 1992 оны анхны УИХ-ын сонгуулийн үр дүнд 3,9 хувь болтлоо буурч, 1998 онд 10,5 хувь, 2002 оны байдлаар 11,8 хувь болж өссөн. Харин 2004 онд эмэгтэйчүүдийн төлөөлөл бараг хоёр дахин буурч 6.5 хувь болов. Ийнхүү эмэгтэйчүүдийн бодлого боловсруулж шийдвэр гаргах түвшин дахь оролцоо буурсан нь хэд хэдэн учир шалтгаантай:

- Олон намын тогтолцоо төлөвшиж, улс төрийн сонгуульд өрсөлдөж нэр дэвших үйл явц илүү түвэгтэй, өрсөлдөөнтэй болсон. Улс төрийн намууд дотор нийт нэр дэвшигчид ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд энэ нь чухал улс төрийн капитал, эрх мэдэл, албан тушаалын төлөө тэмцэл болон хувирсан. Энэхүү тэмцэлд эмэгтэйчүүд эрх мэдэл, улс төрийн туршлага, хөрөнгө санхүүгийн хувьд мөхөсдөж байна.
- Улс төрийн намуудын зүгээс эмэгтэйчүүдийг дэмжиж, сонгуульд өрсөлдүүлэх, улс төрийн албан тушаалд дэмжин томилох тодорхой механизм, үйл ажиллагаа хомс, эрэгтэй лидерүүдийн хүсэл эрмэлзэл сул байгаа нь нөлөөлдөг. Учир нь улс төрийн намууд өөрсдөө шинээр төлөвшиж хөгжих үйл явц үргэлжилсээр байна. Эмэгтэйчүүдийн квотыг намын дотоод амьдралд бататган хэвшүүлэх үйл явц 2005 оноос бодитой эхэлсэн.
- Сонгуулийн систем манайд мажоритар хэлбэрээр төлөвшиж 4 удаа УИХ-ын сонгууль явагдлаа. Дэлхий дахины практикт эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийг нэмэгдүүлэхэд сонгуулийн пропорциональ систем илүү уян хатан гэж тооцогддог. Гэхдээ өнгөрсөн 4 удаагийн сонгуулийн дүнгээс харахад сонгогчид нэр дэвшигч нь эрэгтэй юу эсвэл эмэгтэй юу гэдгээс үл хамаарч, нэр дэвшигчийг хүйсээр нь ялгаварлан санал өгч байна гэсэн хандлага ажиглагдахгүй байна. Харин Монголын нийгэм дахь сонгогчдын боловсролын түвшин нь аль нэг намд, түүний сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалтыг харгалзан сонголт хийх тал илүүтэй анзаарагддаг. Иймээс УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшиж өрсөлдөх боломж гагцхүү улс төрийн намуудын бүтэц, удирдлагаас ихээхэн хамааралтай гэдэг нь харагдаж байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь ямар зэрэг нөлөөтэй байх вэ?

- Төлөөллийн ардчиллын илэрхийлэл болсон парламентыг илүү нээлттэй, иргэний оролцоог хангасан ил тод, шударга болгон төлөвшүүлэхэд нөлөөлнө.
- Улс төрийн шийдвэр олон талтай, нягт нямбай, төгс төгөлдөр, илүү хүмүүнлэг, уян зөөлөн энэрэнгүй байх боломж өргөжинө.
- Монгол улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө болон, гэрээ конвенцид нэгдсэн үүрэг амлалтаа биелүүлэх, МХЗорилтыг хэрэгжүүлэх шаардлага хангагдана.
- Улс орныг тогтвортой хөгжүүлэх, хариуцлагатай, ёс зүйтэй төрийг төлөвшүүлэхэд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хамтын хүчин чармайлт, оролцоо, санаачлага зүтгэл өрнөх бололцоо хангагдана.
- Улс төрийн бодлого илүү прагматик, амьдралд ойр дөт, шийдвэрлэгдэх арга зам оновчтой, аливаа гажуудал доголдлыг арилгах, нийгмийн зөвшилцөлд хүрэх нөхцөл бүрдэнэ.

Тулгамдаж буй зорилт бэрхшээлүүд

- Монголын улс төрч эмэгтэйчүүдийн хувьд улс төрийн нам дотроос сонгуульд нэр дэвших боломж хумигдмал байна. /УИХ-ын сонгуулийн хуулиас эмэгтэйчүүдийн 30 хувийн квотын заалт хасагдсан, улс төрийн намууд төлөвшлийн шатанд яваа, лидер эрэгтэйчүүдийн улс төрийн хүсэл зориг дутмаг/
- Мажоритар тогтолцоонд суурилсан томсгосон тойргоор сонгууль явагдаж, компани ажил 26 хоног үргэлжлэх тул нэр нөлөөтэй, санхүүгийн бэл бэнчинтэй эрэгтэй улс төрчидтэй өрсөлдөхөд тэгш бус гарааны нөхцөл үйлчилж эмэгтэй нэр дэвшигч сонгогдоход бэрхшээлтэй тулгарна.
- Нийгмийн сэтгэл зүйд оршсоор буй эмэгтэй хүнд хандах уламжлалт хандлага /стереотип/ сөрөг нөлөө үзүүлнэ.
- Манлайлагч эмэгтэйчүүдээ намын боловсон хүчний бодлогоор дамжуулан бэлтгэх, олон нийтэд таниулах
- Сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх, эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих сэтгэлгээг төлөвшүүлэх
- Эмэгтэйчүүдийн ТББ-дын хамтын хүчин чармайлтыг улам нягтруулах, эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжих хөдөлгөөн өрнүүлэх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр, урлаг соёлоор дамжуулан жендэрийн тэгш түншлэл, харилцан ойлголцлын тухай шинэлэг хандлагыг иргэд сонгогчид, залуучууд, гэр бүлд төлөвшүүлэх зорилтууд тулгараад байна.

Анхаарал тавьсанд баярлалаа

Улаанбаатар хот,
Төрийн ордон
2008.03.04

“ХАТАГТАЙ” КЛУБ

2006 оны 4 сард МАХН-ын дэргэдэх МАСЭХ нь “Хатагтай” клубыг анх байгуулж, манлайлагч эмэгтэйчүүдээ улс төрд бэлтгэх, тэдний имижийг төлөвшүүлэх, олон нийтэд таниулах зорилгоор 10 гаруй удаа цугларалт зохион байгуулсан. 2009 оны 12 сард энэ клубын шинэ буланг нээж анхны хүндэт зочноор “Нийгэм-төрийн эрхэмсэг хатагтай” Д.Мөнхөө гуай уригдсан.

МАСЭХ-ны Тэргүүн Д.Алтайн “Хатагтай” клубын цугларалтанд хийсэн мэдээлэл.

Сэдэв: 2008 оны сонгууль ба эмэгтэйчүүд

I. 2008 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн дүн, эмэгтэйчүүдийн оролцоо

1. 2008 оны УИХ-ын сонгууль шинэчлэгдсэн хуулиар явагдав

Сонгуулийн хууль: Олон мандаттай 26 тойрог

Нэр дэвшигчид: 290 (245 нь 12 нам, эвслээс, 45 нь бие даагчид)

Онцлог: Өмнөх сонгуулиас олон эмэгтэй нэр дэвшигчид өрсөлдсөн.

Эмэгтэй нэр дэвшигчид 66 хүн буюу 22.7 хувь, Бие даагч 45 хүнээс 15 нь эмэгтэй /33 хувь/ байв.

Эмэгтэй нэр дэвшигчдийг намаар ангилж үзвэл:

• МАХН	10 эмэгтэй	13 хувь
• АН	13 эмэгтэй	17.1 хувь
• Иргэний эвсэл	6 эмэгтэй	16 хувь
• ИЗН	6 эмэгтэй	21 хувь
• МУНН	4 эмэгтэй	15 хувь
• БНН	4 эмэгтэй	20 хувь
• ҮШН	4 эмэгтэй	21 хувь
• ЭОН	2 эмэгтэй	18 хувь
• МОНАРХН	2 эмэгтэй	15 хувь
• ЭҮХН, ХХН, МЛН тус бүр	эмэгтэй нэр дэвшигч гаргаагүй.	

Сонгуулийн дүн:

УИХ-д 76 хүнээс 3 эмэгтэй сонгогдсон буюу 3.9 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй болсон.

МАХН	2
ИЗН	1
АН	0

МАХН-аас Д.Арвин /Хэнтий аймаг/, Д.Оюунхорол /Завхан аймаг/, ИЗН-аас С.Оюун /УБ хот, Сонгинохайрхан дүүрэг/ сонгогдсон.

2008 оны сонгуулийн үр дүнд МАХН, АН хоёр хамтрсан Засгийн газар байгуулсан. Шинэ Засгийн газрын кабинет 15 гишүүнтэй түүнээс 2 эмэгтэй сайд томилогдсон нь 13.3 хувийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй байна.

Мөн Засгийн газрын салбарын 11 яаманд дэд сайдаар 4 эмэгтэй (3 нь МАХН, 1 нь АН) томилогдон ажиллаж байна.

2. Орон нутгийн сонгууль

2008 оны 10-р сарын 12-нд болов. Нийслэлд ирц хүрээгүй тул 11-р сарын 30-нд дахин сонгууль явагдав.

- Аймаг, нийслэлийн ИТХ-ын 698 мандатын төлөө 1638 нэр дэвшигч өрсөлджээ.
- Нийслэлийн ИТХ-ын 45 мандатыг хасч тооцвол 641 мандатын 393-ыг нь МАХН-аас нэр дэвшигчид бүрдүүлсэн.

МАХН	393
АН	230
БНН	2
ЭОН	2
Бие даагчид	16
- Нийслэлийн ИТХурлын 45 мандатад /15 томсгосон тойрогт/ 7 намаас 165 хүн нэр дэвшсэн. МАХН-аас нийт 45 хүн нэр дэвшсэнээс 10 эмэгтэй /22.2 хувь/ нэр дэвшиж 8 нь ялалт байгуулав.
- Нийслэлийн ИТХуралд сонгогдсон 10 эмэгтэйдээс 8 нь МАХН, 2 нь АН байна.
- Нийт 21 аймгаас МАХН 17 аймагт, Улаанбаатар хотын 9 дүүргээс 8 дүүрэгт /Хан-Уулаас бусад/ орон нутгийн сонгуульд ялалт байгуулав.
- Улаанбаатар хотын 9 дүүргийн ИТХуралд МАХН-аас 281 хүн нэр дэвшсэн ба үүний дотор 61 эмэгтэй /21.7 хувь/ өрсөлдөж, 44 эмэгтэй нь ялалт байгуулав.

Улаанбаатар хотын дүүргүүдэд нэр дэвшсэн эмэгтэйчүүд

	Дүүрэг	Нэр дэвшсэн тоо	Ялалт байгуулсан
1	БГДүүрэг	5	4
2	БЗДүүрэг	7	7
3	СБДүүрэг	8	8
4	СХДүүрэг	8	8
5	ЧДүүрэг	5	2
6	ХУДүүрэг	14	2
7	БНДүүрэг	4	4
8	БХДүүрэг	7	6
9	НДүүрэг	3	3
	Дүн	61	44

Яагаад үгүй гэж?

Аймгуудын ИТХ-ын бүрэлдэхүүнд эмэгтэйчүүд дундажаар 17 хувьтай сонгогдсон. Зарим аймаг, дүүрэгт 30 гаруй хувьтай байхад зарим газарт 5-6 хувьтай байна. Улаанбаатар хотод Нийслэлийн засаг даргын орлогчоор 1 эмэгтэй /МАХН/, Баянгол дүүргийн засаг даргаар 1 эмэгтэй сонгогдсон. /МАХН/

УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл шинэ Үндсэн хууль батлагдсан цагаас хойшхи хугацаанд эхэндээ өсөх хандлагатай байсан бол 2004 оноос эргээд буурч байна. 1990 онд АИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 24.9 хувьтай байсан.

- 1992 онд 3.9 хувь
- 1998 онд 10.5 хувь
- 2002 онд 11.5 хувь
- 2004 онд 6.5 хувь
- 2008 онд 3.9 хувь

2. Эмэгтэйчүүдийн төлөөлөл яагаад буурсан бэ?

- Сонгуулийн хуулиас эмэгтэйчүүдийн квотыг хассан /2007 оны 12-р сард/, УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгууль томсгосон тойрог, можаритор системээр явагдсан.
- Нийгмийн сэтгэл зүй, сонгогчдын хандлага нөлөөлсөн (судалгаагаар улс төрчдийн хүйс сонгогчдын 54-61 хувьд нөлөөтэй байдаг гэсэн дүн гарсан)
- Улс төрийн намуудад эмэгтэйчүүдийг сонгуульд нэрийг нь дэвшүүлэх хүсэл эрмэлзэл дэмжлэг дутмаг, тодорхой тойрогт өрсөлдөх эрх авахын төлөө тэмцэл нам дотор хүчтэй өрсөлдөөний дунд явагдсан (нэр дэвшихийн тулд улс төрийн намтай гэрээ байгуулж мөнгө төлсөн гэх мэт)
- Эмэгтэй нэр дэвшигчид бие биетэйгээ нэг тойрогт өрсөлдсөн.
- Иргэний нийгэмд үйлчилдэг эмэгтэйчүүдийн ТББ-д нэгдмэл хүчирхэг эмэгтэйчүүдийн хөдөлгөөн болон зохион байгуулагдаж чадаагүй, эмэгтэй нэр дэвшигчээ нэгдэж дэмжээгүй.
- Эмэгтэйчүүд олонд танил болох, улс төрд өөрийгөө сайтар бэлтгэх явдал шаардлагын хэмжээнд хүрээгүй.
- Орчин үеийн сонгуулийн компанит ажлын стратеги төлөвлөлт, менежментийг эзэмших шаардлага эмэгтэй нэр дэвшигчдэд түлхүү тавигдахын сацуу хөрөнгө, санхүү босгох явдал гол бэрхшээл болж байна.

3. Цаашид баримтлах стратегийн зорилгод дэвшүүлэх санал

- Эмэгтэйчүүд улс төрийн нам доторхи байр сууриа бэхжүүлэх. Нам доторхи бүх түвшний эрэгтэй шийдвэр гаргагчдад нөлөөллийн компанит ажлыг дэс дараатай зохион байгуулах
- УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах, эмэгтэйчүүдийн суудал хадгалах зарчмыг баримталж квотын

механизмыг түүнд баталгаажуулах, сонгуулийн пропорциональ эсвэл холимог системийг дэмжих, учир нь энэ нь эмэгтэйчүүдийн төлөөлөлд илүү ашигтай

- Тодорхой нэг тойрогт эмэгтэй нэр дэвшигч эртнээс ажиллаж, сонгогчдод танил болох, тэдний хэрэгцээг судлах, олон нийттэй харилцах бодлогын үндэслэл (мессеж) стратегия тодорхойлох
- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, жендэрийн мэдрэмжийг хөгжүүлэх сургалт сурталчилгааг төр, ТББ-ын хамтын оролцоотойгоор зохион байгуулах
- Эмэгтэйчүүдийн хүчирхэг нэгдмэл хөдөлгөөнийг зохион байгуулах, нийгэмд, сонгогчдын сэтгэл зүйд нөлөөлөх цогц бодлого хэрэгжүүлэх
- Эмэгтэйчүүдийг дэмждэг бүлэг, залуучуудтай тодорхой төлөвлөгөөний дагуу ажиллах (судалгаагаас харахад эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих хандлагатай 47 хувь, дэмждэг бүлэг 25 хувь, дэмжих хандлагагүй бүлэг 20 хувь, огт дэмждэггүй 8 хувь гэсэн дүн гарч байна.)
- Эмэгтэй улс төрчдийн имиж бүрдүүлэх, нийгмийг хөгжүүлэх шинэлэг хөтөлбөрийг бий болгох, эмэгтэй нэр дэвшигч өөрийгөө бүхий л талаар бэлтгэх, эмэгтэйчүүдийн манлайллыг хөгжүүлэх (шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн үлгэр дууриал, сонгогчид ба эмэгтэй удирдагчийн хоёр талын сонирхол, дэмжлэг, хамтын ажиллагаа зэрэг) зорилтыг онцлон дэвшүүлж байна.

(IRIM судалгааны багийн дүгнэлтийг ашиглав.)

Анхаарал тавьсанд баярлалаа

**Улаанбаатар хот,
Бишрэлт зочид буудал
2008.10.31**

“ЖЕНДЭР БА ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ХУРАЛ

Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн Холбооны урилгаар МАСЭХ-ны Тэргүүн Д.Алтай тэргүүтэй 5 хүн 2009 оны 04-р сарын 20-22-ны өдрүүдэд БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо болсон «Жендэр ба гамшгийн эрсдлийг бууруулах нь» сэдэвт Олон Улсын хуралд оролцов.

Хурлыг БХЭХолбоо ба НҮБ-ын Гамшгийн эрсдэлийн стратегийн нарийн бичгийн дарга нарын Газар хамтран зохион байгуулсан юм. Хуралд 41 орны төлөөлөгчид оролцов. МАСЭХ-ны Тэргүүн Д.Алтай «Монгол орны цөлжилт: нөлөөлж буй хүчин зүйл, асуудал, жендэр» гэсэн сэдвээр сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Ц.Ганхүү, ТБЦДСүлжээ ТӨХК-ний Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Э.Анударь, Онцгой байдлын Ерөнхий газрын гал түймэртэй тэмцэх хэлтсийн мэргэжилтэн П.Амарзаяа, Хэнтий аймгийн онцгой байдлын хэлтсийн олон нийттэй харьцах мэргэжилтэн Г.Мөнхзул нар багтаж оролцов.

Олон улсын бага хурлаас Бээжингийн үйл ажиллагааны хөтөлбөр баталж, дэлхий нийтийн улс оронд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн оролцоог улам нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн тавив. Хуралд парламентийн гишүүд, сайд, дэд сайд нар болон гамшигийн чиглэлээр ажилладаг байгууллагын мэргэжилтэн, олон улсын байгууллагын зөвлөх эксперт, иргэний нийгэм, эмэгтэйчүүдийн ТББ-уудын төлөөлөл оролцов. Сүүлийн жилүүдэд дэлхийн олон оронд тохиосон цунами, далайн шуурган салхи, газар хөдлөлт, үер, гал түймэртэй хэрхэн тэмцэж, урьдчилан сэргийлэх, гамшиг тохиолдсон үед мэдээлэл шуурхай дамжуулж, яаралтай арга хэмжээ авах талаар хуралд оролцогчид санал солилцож ярилцав. Олон улсын байгууллагын туслалцаа дэмжлэг, улс орны төр Засгийн газрын шуурхай тусламжийн ажлын уялдаа холбоо, гамшгийн менежментэд суралцах, гамшигт өртсөн бүх хүмүүст тухайлбал эмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настанд яаралтай хэрхэн туслах вэ, түр орогнох байраар яаж хангах вэ зэрэг асуудлаар үр бүтээлтэй санал солилцов.

**DESERTIFICATION IN MONGOLIA:
FACTORS, ISSUES AND IT'S GENDER PERSPECTIVES.**

**United Nations International Strategy for Disaster Reduction
All-China Women's Federation**

International Conference on Gender and Disaster Risk Reduction

Presentated by Mrs. ALTAI Dulbaa (Ph.D), Chair, Mongolian Democratic Socialist Women's Association, Mongolia

Panel 3: Gender perspective in risk reduction and climate change.

Mongolia's geographical and climate features including harsh continental climate, located in remote area from sea, evaluated on the 1580 meters above sea level, more than 40% of all territory falls into unproductive, sensitive desert like steppe and Gobi are found as main reason for desertification.

Mongolia is one of the most arid countries in the world. Due to global climatic change, average annual temperatures in our country warmed by 2.10C in period of 1940-2007. In our country, all zones are vulnerable to drought and harsh winter disaster (named in mongolian dzud) and their frequency in dry and semi-dry areas mostly high. In some areas, drought and dzud are happening year after year which is one of the main reasons causing desertification

Desertified land is mainly distributed in arid, semi- arid and dry sub-humid areas in Mongolia. 70 per cent of Mongolia's territory falls in arid and dry zone with deficit in surface water run-off. Forest covered area accounts only for 8.5 per cent of total territory. In last 100 years forest and steppe fires contribute strongly to desertification.

One of the reasons for desertification is sand movement. Strong winds cause spread of sands and this leads to loss of productive soil layer and water holding capacity of soil.

Although, the main reason of desertification in Mongolia is impact of global climate change, but in many cases, there is strong negative impact of improper human activity such as development of industry and mining accompanied by pollution and improper use of water and land resources.

Increase in livestock herd causes large load for carrying capacity of pastures. Mongolian livestock herd is steadily increasing in recent years and by the end of 2008 reached 42.1 million.

At present, 90 percent of Mongolia's territory is affected by desertification and land degradation and among them the severely affected areas are Uvs lake depression, Great Lakes depression and several other aimags (provinces) located in Gobi region. The forest and steppe regions of the country are among the territories where desertification process is active from weak to medium level.

Thus, the Government of Mongolia has joined in 1996 the UN

Convention to Combat Desertification and adopted the National Action Plan for Combating Desertification in 1997 and 2003. Goal of this national plan is to support and assist the activities, programs and projects at international, national and local community levels aimed at changing the desertification tendency and reducing the climatic changes and droughts.

National plan to combat desertification has the following 7 components:

1. Be prepared and build national adaptation capacity for droughts and climatic changes caused by natural factors such as desiccation, low precipitation, increase of drought frequency and dust storms speeding up desertification.
2. Provide administration, legal and economic environment aiming to combat desertification
3. Populate environment-friendly methods and technologies in agriculture.
4. Promote sustainable management of land, water and pasture, use environment-friendly methods and technologies.
5. Decrease the negative effects of mining and extraction on environment, increase the creation of renewable energy industries and use the eco-friendly technology to process the minerals and metals in harmless and efficient way
6. Expand the initiative activities concerning the protection, rehabilitation and acclimatization of biological species
7. Improve the public advocacy, awareness and education for combating desertification

Desertification limits citizen's income sources and leads to increased migration to urban areas and it causes number of serious issues related to equity of gender and reduction of disaster risk among the whole population. First of all, it should underlined desertification has strong negative impact on female group of the population because of the fact that in Gobi region there are most of households are poor and single women headed. In addition, most of single women headed poor families have many children which arising complex of pressing social problems such as unemployment, high child mortality and maternity rates, school dropouts, less access to medical and reproductive health services, domestic violence and alcoholism.

Taken into account the above mentioned problem Government of Mongolia has adopted in 2002 a separate program on Gender equality. Thus, implementation of those two programs, namely the National Action Plan for Combating Desertification and National Program on Gender Equality, in their close coordination is now becoming the main agenda of the activities not only for the central and local government of Mongolia, but for all other stakeholders of Mongolian society, including non-governmental organizations, private sector and scientific and research institutions.

**APRIL 20-22, 2009
BEIJING
CHINA**

СОЦИНТЕРНИЙ ГИШҮҮН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН БОЛОН
СИЭ БАЙГУУЛААГУУДЫН ЗӨВЛӨЛДӨХ ХУРАЛ

МАХН 1999 онд Социнтерний ажиглагч, 2003 онд жинхэнэ гишүүн улс төрийн нам болсон. Сүүлийн 10 жилд МАХН Социнтерний Их хурал, жил бүр болдог зөвлөлийн хурал, Ази-Номхон далайн бүсийн хуралд тогтмол оролцож байна. 2009 оны 06-р сарын 26-29-ны өдрүүдэд Монтенегро улсын Петровац, Будва далайн эргийн хотуудад болсон Социнтерний эмэгтэйчүүдийн байгууллагын болон Улс төрийн намуудын ээлжит Зөвлөлийн хуралд МАХН-ыг төлөөлж Намын Бага хурлын гишүүн, МАСЭХ-ны Тэргүүн Д.Алтай оролцов. Социнтерний эмэгтэйчүүдийн байгууллагын Зөвлөлийн хурлаар «Дэлхийн санхүүгийн хямрал эмэгтэйчүүдэд нөлөөлж буй нь» сэдвийг хэлэлцэж санал солилцон, тогтоол гаргав. Д.Алтай Ази номхон далайн бүсийг төлөөлж Монголын эмэгтэйчүүдийн аж байдалд санхүү эдийн засгийн хямрал хэрхэн нөлөөлж буй талаар сонирхолтой илтгэл тавив. Энэ хуралд мөн Хорвати (Төв ба Зүүн Европ), Буркина Фасо (Африк), Австри (Баруун Европ), Коста-Рика (Латин Америк) улсын социал демократ, ардчилсан хөдөлмөрийн намын эмэгтэйчүүдийн байгууллагын удирдлагаас үндсэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

Хямралыг даван туулах төлөвлөгөө хөтөлбөртэй байх, түүнд хяналт тавих, нийгмийн зардлыг хасаж танахгүй байх, эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засгийн эрхийг хангах, эмэгтэйчүүдэд ажлын байр, зээл олгох асуудлыг тусгасан тогтоол батлан гаргав. Хуралд 27 орны 30 гаруй намын төлөөлөгчид 70 гаруй хүн оролцов.

Будва хотод 06-р сарын 28-29-ний өдрүүдэд Социнтерний гишүүн улс төрийн намуудын Зөвлөлдөх хурал болов. Хурлаар дэлхийн санхүүгийн хямрал, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, ардчилал, байгаль орчин зэрэг өргөн хүрээтэй асуудлаар хэлэлцүүлэг хийж, нэгдмэл байр суурийг илэрхийлсэн баримт бичиг, тогтоол гаргав.

МАХН-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Г.Тэнгэр 2008 онд болсон Их хурлаас Социнтерний санхүү-захиргааны хорооны нишүүнээр сонгогдсон. Санхүү захиргааны хорооны хурал 2009 оны 06-р сарын 28-ны өдөр болж Д.Алтай МАХН-ыг төлөөлөн оролцож, Социнтерний Ерөнхий нарийн бичгийн дарга Луис Аяала, бусад 10 гаруй орны төлөөлөгчидтэй уулзаж санал солилцов.

THE IMPACT OF THE FINANCIAL CRISIS ON WOMEN

SIW Council Meeting

Keynote speaker

Dr. Altai. D Chair, MDSWA, Mongolia

Mongolia is sparsely populated land locked developing country of some 2.6 million inhabitants of which 51 percent are women and 75 percent are youth of age under 35. It has made significant strides in achieving macroeconomic stability and fundamental structure reforms since its transition to democracy and a market-based system in 1990.

Thus, Mongolia has experienced good economic growth for the last 4 years during which average economic growth was nine percent. GDP per capita more than doubled between 2004 and 2007. Budget expenditure more than doubled, substantially increasing the spending on public servant's salaries, pensions and social transfers.

But the global financial crisis has had some negative impact to Mongolian economy. This is first of all that Mongolia's economy is based around the mining sector and it is vulnerable to world price's fluctuations on mineral resources. Within the beginning of global financial crisis world price on the main exports of Mongolia such as copper, gold and coal has been dropped down significantly. For instance, price of copper has dropped by almost three times compare to last year.

Symptoms of vulnerability in Mongolia were observed since mid 2008 when oil prices heat up (petrol is about 25% of Mongolian import, 2007 NSO Statistics). At that time, even the country got some rapid economic expansion it was accompanied by the soaring inflation. By the end of 2008 inflation rate reached up to 34.2 percent and prices for key food staples such as flour and meat increased sharply and oil prices, and electricity and heating tariffs went up.

Due to the above mentioned economic factors, poverty is still the main economic and social issue, so nearly one of third of the population is under poverty line. During the last year this indicator increased quarterly from 25.1-42.1 percent. Unemployment rates is 2.8 percent per 2007 employment statistics.

In terms of gender ratio of poverty and unemployment rate among the population, there is significant disparity and gap between men and women. Female unemployment is higher than among men. According to official data from October 2008, unemployed increased to 6,861 of which almost 60 percent are women.

Women face great disadvantage, despite their higher attainments in

education. Unemployment is higher for people with upper-secondary and higher education and women comprise 59 percent of upper-level students and 65 percent of college university graduates.

Women's participation in mining, transport, storage and communication, and financial intermediation sectors has been limited at 7.7 percent compared to 13 percent for men.

In general, in the country it is more common that women earn less than men due to being concentrated in low-paying sectors, holding lower positions and working fewer years because of their reproductive and care givers roles.

Women get less than men even for the same or comparable position and occupation.

In 2004-2007, women have been paid on average 21 percent less as managers, 19 percent less as specialists, and 30 percent less as engineers. Gender gap in wages is common in private as well as in public sectors.

Global financial crisis continues to have a negative impact of Mongolia's livestock sector, which provides a living for approximately 28 per cent of the population and where employed much number of women. It is because that herder incomes have fallen sharply as result of lower demand from Chinese traders for Mongolian cashmere. At the same time, incomes have been further squeezed by a price drop in mutton and beef from \$4 to \$2 a kg.

At present, 60 per cent of Mongolia's population lives in the cities and 40 per cent are rural. According to statistics, life expectancy is 64 for men and 69 for women. Mongolian women live in average five years longer than men. However, according to the existing legislation, they can retire from five to twenty years earlier than men. Rural women are restricted in their enjoyment of their legitimate rights in terms of working hours, wages and paid annual leave. Moreover, their contribution in the economic development has not been recognized and rewarded properly. They have been denied maternity leave and child care benefits.

Currently, because of recent global financial crisis and worsening the whole economic situation in the country burden of women has been significantly increased in general. Due to high rate of inflation women have to work more hours to earn additional income. Public servants have to run private businesses after office hours. Domestic responsibilities and need for household subsistence contribute in such double and even triple burden of women.

Self-employment makes a significant contribution to the household and national economy. However, in the new for Mongolia informal sector labour protection is poor and people are not satisfactorily covered by social and medical insurance. Majority of self-employed women can't get paid maternity leaves and other benefits related to reproductive function.

Яагаад үзүү гэж?

These are some general thoughts and facts about the country's recent economic and social developments in general and negative impact of global financial crisis on and via it on Mongolian women in particular. And, I hope that as result of integrated sound economic and social policy of the Government of Mongolia in cooperation with international community the situation in the country will be improved and more accomplishments will be made in overcoming existing problems and enhancing role of women in favorable means and ways to them as well.

Thank you.

***Petrovac
Montenegro
26-27 June, 2009***

**ГСДН БОЛОН ГЕРМАН УЛС ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС
ТӨРИЙН ОРОЛЦОО**

**Зуны академи сургалт
МАХН, Ф.Эбертийн Сан**

Уте Кумф, Бундестагийн гишүүн

***Бидэнд эмэгтэйчүүд тоон үзүүлэлтийн хувьд биш, улс
төрд чухал хувь нэмэр оруулдгаараа хэрэгтэй***

Эмэгтэйчүүдийн улс төрийн үйл ажиллагааны зүгээс сүүлийн жилд хоёр чухал ойн баяр тэмдэглэсэн. Энэ нь: Эмэгтэйчүүд сонгох эрхтэй болсны 90 жил /1918 оноос/ болон Эмэгтэйчүүдийн оролцоо буюу квотын 20 жил /1988/ юм. Энэ онд манай улс Германы Үндсэн Хуулийн 60 жилийн ойгоо тэмдэглэж байна. Энэ хуулиар анх удаа хүйсийн ялгаваргүй тэгш эрхийг үндсэн эрхээр хуульчлав. Эдгээр үйл явдлууд нь улс нийгмийн орчин үеийн шударга чиглэлийн дагуу хөгжих томоохон алхмуудыг тодорхойлов. Эмэгтэйчүүд нийгэм ба улс төрд тэгш эрхт байр суурь олохын тулд урт зам туулж ирсэн ч эдүүгээ зорилгодоо бүрэн хүрээгүй байна. Энэ нь хүний эрхээс гадна эдийн засгийн ач холбогдолтой. Аливаа улс ардын аж ахуй нь мэргэжилтэй боловсон хүчний нөөцийг ашиглахын тулд тэднийг улс нийгмийн процесст хамруулан оролцуулах нь нэн чухал байдаг.

Энэ нь орчин үеийн биеэ даасан эмэгтэйчүүдийн амьдралд нийцэхгүй байна. Өнөөдрийн эмэгтэйчүүд амьдралаа өөрсдийн төсөөллөөр төлөвлөдөг. Иймд тэд сайн боловсрол болон мэргэжил эзэмшин, өөрийн гэсэн мөнгөтэй болж, олонхи нь хүүхэд төрүүлж, нийгэмд хариуцлагатай байр суурь олохыг хүсдэг. [Шинжлэх Ухааны Төв Берлин /WZB/ болон Хэрэглээний Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэн /infas/ хамтарсан 2008 оны БРИГИТТЕ-Судалгаа]. Улс төрчдийн томоохон сорилт нь үүний суурь нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. ГСДН нь эмэгтэйчүүдийн асуудалд хандсан анхны нам болсноороо гол хөдөлгүүр хүч нь юм.

Герман Улсын эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ? Дараахи тоон үзүүлэлтээс үзнэ үү:

Хүн амын тоо

- Герман Улсын хүн амын дийлэнхи хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. 82.2 сая хүний 51% нь /41.9 сая/ эмэгтэйчүүд болон охидууд байдаг.
- 2007 оны байдлаар, гадаад орнуудаас 7,5 сая эмэгтэйчүүд Герман улсад шилжин ирж суурьшсан байна. Тэдгээрийн 21% нь хуучнаар Зөвлөлт Холбоот Улсаас, 19% нь Турк улсаас, 12% нь дундын тэнгисийн орнуудаас, мөн 11% нь Польш улсаас ирсэн байна.

Мэргэжил ба боломж

- Их сургууль төгсөгчдийн тал шахам хувь нь эмэгтэйчүүд байдаг. Хэлний болон соёл, урлагийн ангийг /69,8%/ төгсөгчид, хүмүүнлэг, анагаах ухааны ангийг /58,8%/ төгсөгчдийн талаас илүү хувийг эмэгтэйчүүд эзэлдэг.
- 2005 оны байдлаар, нийт хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн тэн хагас нь аж ахуйн, 87 салбараас зөвхөн 5 салбарт нь тухайлан ажиллаж, ялангуяа ахуйн үйлчилгээний болон нийгэм хангамжийн салбарт илүүтэй хөдөлмөрлөж байжээ. Тухайлбал, оффисийн ажилтан /Эдийн засагч 19,9%, Эрүүл мэндийн салбарт 10,3%, Худалдаа 8% нийгмийн хангамжийн салбар 6,8%, Цэвэрлэгээ болон хог хаягдал 5,8% тус тус байлаа.
- Герман улсын хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн тоо өсөж улмаар 64%-д хүрлээ. Гэвч хувийн хэвшил болон шинжлэх ухааны салбарын удирдах албан тушаал дээр эмэгтэйчүүдийн эзлэх хувь цөөн байдаг. Харин улс төрд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсөж, Холбооны Канцлер болон парламентад 6 эмэгтэй гишүүнтэй болсноор Герман улс Европын Холбооны улсууд дотроо 4-р байр эзлэх болсон.
- Жижиг дунд үйлдвэрийн доод болон дунд төвшний удирдах албан тушаалд эмэгтэйчүүд голлон ажилладаг. 2005 онд жижиг дунд үйлдвэрийг 1/5-ийг нь эмэгтэйчүүд удирдаж байсан. Үндэсний томоохон 50 компанийн тэргүүн буюу удирдах зөвлөлийн даргаар эмэгтэй хүн ажиллах нь онцгой тохиолдол юм.
- Эмэгтэйчүүдийн орлого эрэгтэйчүүдийнхээс доогуур байдаг: Герман улсад цалингийн ялгааны төвшин 23%-тай байна. Энэ нь дараах хүчин зүйлсүүдээс хамааралтай. Жишээ нь, улс ардын аж ахуйн олон салбаруудад, мэргэжлийн ажилд эмэгтэйчүүдийн эзлэх хувь цөөн байдаг, гэр бүлийн амьдралын улмаас тэдний хөдөлмөр эрхлэлт завсардаж улмаар эрэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөлмөрийн бүтээмж нь мэдэгдэхүйц удаан болдог байна. Ингэхдээ эмэгтэйчүүд ажилладаг салбарын цалин бага байдаг.

Эмэгтэйчүүдийн амьдрал хэв маяг

- Германд Европын Холбооны Улсуудтай адил хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нь хүүхэдгүй эмэгтэйчүүдийнхээс илүү бага байдаг. Дани улсад эхчүүдийн 80% ажилладаг бол Германд эхчүүдийн ердөө 60% хөдөлмөр эрхэлдэг. Европын холбооны дундаж хэмжээ нь 64,5% юм.
- Эмэгтэйчүүдийн тэтгэвэр нь эрэгтэйчүүдийнхээсээ дунджаар 475 евроогоор бага байна. 2006 онд эмэгтэйчүүдийн дундаж тэтгэвэр нь 509,18 евро байсан. Эрэгтэйчүүд сардаа дунджаар 984,18 евро тэтгэвэр авдаг.
- Эмэгтэй хүн эрэгтэй хүнтэй харьцуулахад эрүүл мэнддээ

анхаарал тавьж амьдардаг. Эмэгтэйчүүдийн 78% нь огт тамхи татаж байгаагүй бол эрэгтэйчүүдийн 44% нь энэ үзүүлэлтэд багтана.

Санаачлага ба Хамтран шийдвэрлэх

- Сонгогчдийн хувьд эмэгтэйчүүд улс төрд идэвхитэй нөлөөлдөг. 2005 оны Бундестагын сонгуульд 5 эмэгтэй тутмаас 4 нь /78%/ оролцсон. Эрэгтэйчүүд сонгуульд 79%-тай оролцож ялимгүй илүү байсан.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн тавцанд эздэх хувь нь хүн амын эзлэх хувьтай харьуулахад бага байна. 1983 онд парламентын гишүүдийн 10-аас доошгүй хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байсан бол өнөөдөр Бундестагын 32 шахам хувийг бүрдүүлж байна. Харин орон нутгийн парламентад илүү цөөхөн хувь эзэлж байна.
- Гэр бүл доторхи үүрэг хариуцлагын хувиарлалт нь тэгш бус хэвээр байна. Жишээ нь: гэрийнхнийгээ асрах ториолдолд. Эмэгтэйчүүд 7 хоногт 31 цаг, эрэгтэйчүүд 19,5 цаг цалингүй ажил эрхэлж байна.
- Өөрсдийн санаачилсан сайн дурын ажлаараа эмэгтэй болон эрэгтэйчүүдийн хувьд ялгаатай байдаг. Эрэгтэйчүүд илүүтэйгээр спортын салбар /14%/, улс төр /4,5%/, болон мэргэжлийн ашиг сонирхлын төлөөллийн газруудад /4%/, сайн дураараа ажилладаг бол эмэгтэйчүүд нийгмийн /4%/, болон сүм шашны /7%/, салбарт идэвхи гаргадаг.
 - 2005 оноос хоош /сонгуулийн 16-р үе/ эмэгтэйчүүд ГСДН-ын парламентын гишүүдийн 39%-ийг, парламентийн нийт гишүүдийн 32%-ийг тус тус бүрдүүлж байна.
- ГСДН-ын удирдах зөвлөлийн гишүүдийн 42,2%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд ГСДН-ын нийт гишүүдийн 30,3% нь эмэгтэйчүүдээс бүрддэг.

Квотын тогтоол

1988 онд ГСДН-ын Холбооны их хурал дээр удаан хугацаанд үргэлжилсэн ширүүн мэтгэлцээний үр дүнд эмэгтэй ба эрэгтэйчүүдийн сонгуулийн оролцооны баталгаат доод хэмжээг /квот/ тогтоосон. Өнөөдрийг болтол ГСДН нь дотоод дүрмэндээ “функц болон мандатад эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд 40% дээш хувийн оролцоотой” байхыг заасан байдаг. Орон нутгийн ба холбооны муж улсын сонгуульд намын хэмжээнд дахь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн оролцооны хувь чөлөөтэй байдаг бол, ГСДН-ын Бундестагийн сонгуульд оролцох дүрмэнд хязгаар заасан байдаг.

4-р зүйлийн 2-р хэсэгт ийнхүү өгүүлсэн байдаг. “сонгуульд оролцох нэр дэвшигчдийн нэрсийг жагсаалтыг солбих зарчмаар гаргана. Хамгийн олон санал авах магадлалтай эрэгтэй буюу эмэгтэй нэр дэвшигчээр эхлэн эмэгтэй, эрэгтэй солбин 5-р эгнээнд, нэг бол эмэгтэй юмуу эрэгтэй нэр дэвшигч бичигддэг”.

Бусад намын квот

- 1996 оны ГСНД-ын их хурлаар эмэгтэйчүүдийн оролцооны сайн дурын квотын системийг ГСНД-ын дүрмээр баталж, үүнд эхний сонголтын явцад эмэгтэйчүүдийг бүхийл албан тушаал, мандат болон функц нд 1/3 оролцоотой байхыг заасан. Давтан сонголт явуулах болсон тохиолдолд дээрхи квотын дүрэм нь хүчингүй болно.
- Ногоон намын дүрмийн дагуу эмэгтэйчүүд уг намын Холбооны бүхийл зөвлөл болон байгууллагуудад 50%-аас дээш хэмжээний оролцоотой байхыг шаарддаг.
- Чөлөөт Ардчилсан Нам нь эмэгтэйчүүдийг нам дотроо квотын аргаар дэмжихээс татгалздаг. Холбооны удирдах зөвлөлийн 1987 оны шийдвэрээр эмэгтэйчүүдийн тэгш эрхт байдлыг намын байгууллагуудын бүхийл үе шатанд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэхийг заасан. Чөлөөт Ардчилсан Нам нь эмэгтэйчүүдийн шийдвэрлэх албанд эзлэх хувийг нь нийт гишүүдийн дотор байгаа хувьтай нь тэнцүүлэхийг эрмэлзэж байна.
- Зүүний Нам нь дүрмэндээ парламентын зөвлөлийн болон намын бүх албан тушаалын сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийн оролцооны хувийг 50 дээш хэмжээгээр тогтоосон.

1994 оны Бундестагийн сонгуулиар /сонгуулийн 16-р үе/ нэр дэвшихэд ГСНД-ын хувьд анхны удаа квотын систем үйлчилсэн. Эхэнд дурдсанчлан, 2005 оноос хойш /сонгуулийн 16-р үе/ ГСНД-ын парламентийн гишүүдийн 39%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд парламентийн нийт гишүүдийн 32%-ийг бүрдүүлж байна.

Квот дангаараа хангалтгүй - агуулга нь чухал

Эмэгтэйчүүд дангаараа хөтөлбөрийг бүрдүүлж чадахгүй. Энэ нь эмэгтэйчүүд бидний хувьд квотын системд орох явцад зайлшгүй байх мэдээжийн зүйл юм. Квот нь улс төр, нийгэм болон эдийн засагт тэгш эрхт байдлыг хэрэгжүүлэх нийт бодлогын хэрэгсэл болж, бидэнд үзэл бодлоо болон ашиг сонирхлоо илэрхийлэх боломжийг олгож байгаа юм. Эмэгтэйчүүд өөрийн мэргэжлийн өндөр чадвар болон туршлагаасаа олж авсан мэдлэгээ улс төр болон нийгмийн тогтолцоог хөгжүүлэхэд зориулах нь зүйтэй. Тийм учраас хөтөлбөрийн чухал асуудлыг дараахи сэдвүүдээр хийж ирсэн ба хийсээр байна.

- Боловсрол болон мэргэжил эзэмших ижил боломж
- Нэг төрлийн ажилд ижил цалин олгох
- Гэр бүлийн амьдрал болон хөдөлмөр эрхлэлтийн зохицол (хүүхдийн асрамж, эх эцэг ажлаасаа чөлөө аван хүүхдээ гэртээ асрах цаг, 10-н жилийн бүтэн өдрийн сургалттай сургууль)
- Тэгш эрхт байдлыг эрхэмлэсэн гэр бүлийн бодлого
- Нийгмийн баталгаа, нийгмийн баталгааны системд тэгш эрхийг эрхэмлэх

- Эмэгтэйчүүд шинжлэх ухаан ба боловсролын салбарт
- Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

Улс төрийн сорилт

Бидний тэгш эрхт байдлын төлөөхи тэмцэл нь ахицтай байгаа боловч эртний хувиарлалт бүр мөсөн арилаагүй байна. Одоогоор хуулиар олгогдсон тэгш эрхийг бодит байдалд хэрэгжинэ гэсэн баталгаа байхгүй байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн бодлогыг өөрсдөө хэрэгжүүлж байгаа зүгээс нь харахад дараахи “барилгын талбайд” чиглүүлэх нь урьдын адил шаардлагатай хэвээр байна. Үүнд:

Цалингийн тэнцвэр

Ялангуяа хөдөлмөрийн салбарт эртнээс үүссэн цалингийн ялгаа нь хэвээр байсаар байна. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй адил түвшинд мэргэшсэн боловч хэд дахин багаар цалинждаг. Статистикийн мэдээнээс үзэхэд эмэгтэй болон эрэгтэй хүний цалингийн ялгаа нь 20%-30% хооронд хэлбэлзэж байдаг.

Эмэгтэйчүүд удирдах албанд

Нийгмийн болон эдийн засгийн салбарын гол албан тушаалууд дээр ихэнхдээ эрэгтэйчүүд ажилладаг. Томоохон компаниудын удирдах албан тушаалд ердөө 4%-ийг нь эмэгтэйчүүд эзэлдэг. Европ дахь хөрш Норвеги улсыг авч үзэхэд, зүгээр амлахын оронд хуулийн зохицуулалтаар өөрчлөлт оруулах нь харагдаж байна. Норвеги улс нь биржэд бүртгэлтэй компаниудын удирдах зөвлөл болон төлөөлөн удирдах зөвлөлийн 40 дээш хувь нь эмэгтэйчүүд байхыг шаарддаг. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд аж ахуйн нэгжид хориг тавьж, албадан хаалгуулахад хүргэдэг.

Гэр бүл болон ажил албаны уялдааны сайжруулалт

Залуучуудын 90% нь хүүхэдтэй амьдралыг хүсдэг. Гэвч эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн хүүхэдгүй амьдрах хандлага нэмэгдсээр байна. Тэдний дийлэнхи нь өндөр боловсрол болон цалинтай байдаг. Нөгөөтэйгүүр эхчүүд хүсээгүй боловч хөдөлмөр эрхлэлтээс татгалзах болдог. Иймд хүүхдийн асрамж мөн боловсролын салбарын үнэлгээ, чанарыг нь сайжруулж, өрхүүдэд санхүүгийн туслалцаа, гэр бүлүүдэд ээлтэй ажлын нөхцөл байдлыг нь өөрчлөх шаардлагатай байна.

Жендэрийн тэгш эрхийг эрхэмлэсэн татварын тогтолцоо

Германы татварын тогтолцоонд гэр бүлийн “ганцаараа цалинжигчийн” загварыг дэмжсээр ирлээ. Үүнд гэр бүлийн нэг нь /ихэнхдээ нөхөр нь/ хөдөлмөрлөн орлого олж, нөгөө нь гэртээ суудаг. Энэ нь эмэгтэйчүүд өөрсдөө хөдөлмөр эрхлэх сонирхлыг нь бууруулахад хүргэдэг.

Яагаад үгүй гэж?

Дүгнэлт

Герман улсад ч мөн шийдвэрлэж хэрэгжүүлэх асуудал их байна. Гэсэн ч, эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрийн оролцоог дээшлүүлэх тэмцэл нь өгөөжөө өгдөг. Улс төр, нийгэм болон эдийн засагт эмэгтэйчүүд их хэмжээний хувь нэмэр оруулж чадна. Манай анхны эмэгтэй сайдуудын нэгэн Кэте Штробель /1907-1996/ хэлсэнчлэн “Улс төрийг зөвхөн эрэгтэйчүүдэд даалгана гэхэд хэтэрхий чухал зүйл юм”.

*МАХН, ХБНГУ-ын Ф.Эбертийн Сан хамтран зохион байгуулсан
“Зуны академийн сургалт”
Улаанбаатар хот,
2009 оны 7 сарын 8-9 өдрүүд*

АШИГЛААСАН НОМ, СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ

1. “УИХ-ын сонгуулийн тухай” хууль, УБ, 2005 УБ, 2008
2. “Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого”. УБ, 2008
3. “Мянганы хөгжлийн зорилтуудыг дэмжин хэрэгжүүлэх тухай” УИХ-ын тогтоол. УБ, 2005
4. “Яагаад үгүй гэж”. МАСЭХ, ХБНГУ-ын Фридрих Эбертийн сан. УБ, 2005
5. “Монголын жөндөрийн байдал”. Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк. УБ, 2005
6. “Жөндөрийн асуудлаарх стратеги төлөвлөлтийн семинар” 2005.05.12-12, ЖТБҮХороо, НҮБ-ын эмэгтэйчүүдийн сан, УБ, 2006
7. “Жөндөрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (шинэчилсэн найруулга 2003-2015). МУ-ын Засгийн Газар, Жөндөрийн тэгш байдлын үндэсний хороо. УБ, 2007
8. “Жөндөрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргачлал”. МУ-ын Засгийн Газар, Жөндөрийн тэгш байдлын үндэсний хороо. УБ, 2007
9. “МАХН-ын мөрийн хөтөлбөр, дүрэм, бага хурлын III, VI хуралдаан”. МАХН-ын Удирдах Зөвлөл. УБ, 2007
10. МАХН-ын XXIV-XXV Их Хурлын баримт бичгүүд. УБ, 2007
11. “Жөндөрийн тэгш байдлыг хангах төрийн бодлогын асуудлууд” Монгол улсын Засгийн газар, ЖТБҮХороо, НҮБ-ын Хүн Амын Сан, УБ, 2007
12. “Хөдөлмөр эрхлэлт, ядуурал” (Монголын хүний хөгжлийн илтгэл). Монгол улсын Засгийн газар, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг. УБ, 2007
13. “Монголын жөндөрийн төлөв байдал 2008” сэдэвт I (2008 оны XI сар), II (2009 оны IX) зөвөлгөөнд хэлэлцэгдсэн илтгэл, мэдээллийн материал. АХБ, Швейцарийн хөгжлийн агентлаг, ЖТБҮХороо, “Монфемнет” Монголын эмэгтэйчүүдийн ТББ-дын Үндэсний сүлжээ
14. НҮБ-ын Хүн Амын Сан. Хүн амын асуудлаарх зайны сургалтын хөтөлбөр “Жөндөрийн агуулгатай бодлого үйл ажиллагаа, үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрэх нь”
Гарын авлага 1 “Жөндөрийн тухай ойлголтууд”
Гарын авлага 2 “Жөндөрийн дүн шинжилгээ хийх болон шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах нь”
Гарын авлага 3 “Жөндөрийн мэдрэмжтэй ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа”, ЖТБҮХорооны ажлын алба. УБ, 2008

15. “Эмэгтэйчүүд ба хэвлэл мэдээлэл”. “Монфемнет” эмэгтэйчүүдийн ТББ-ын үндэсний сүлжээ, Монголын Эмэгтэйчүүдийн сан, Австралийн олон улсын хөгжлийн агентлаг. УБ, 2008
16. “Эмэгтэйчүүд сонгуульд хэрхэн өрсөлдөж ялах вэ?” Иргэдийн Альянс төв, Монголын эмэгтэйчүүдийн сан. УБ, 2008
17. Д.Алтай, Н.Гэрэлсүрэн “Монголын эмэгтэйчүүдийн байгууллага” түүхэн товчоон (1924-2008). УБ, 2008
18. “Монгол улсын төрийн албаны тойм” Монгол улсын Засгийн газар, Монгол улсын Төрийн албаны зөвлөл. УБ, 2008
19. “Төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчдын төлөвшил: өнөөгийн байдал, хандлага” (судалгааны тайлан). Удирдлагын Академи. УБ, 2009
20. “Тэгш байдлын хөтөлбөр” НҮБ-ын Хүн Амын сан (Шведийн Ваксжо хотын туршлага). УБ, 2009
21. “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал ба Монгол Улс” МУ-ын Ерөнхийлөгчийн ТГ, МУ-ын ЗГХЭГ, УИХ-ын тамгын газар, МУ-ын ШУА, МАХН-ын сургалт, судалгааны Прогноз Академи. УБ, 2009
22. “Намын ажилтны лавлах” (Баримт бичиг, журам, заавар, зөвлөмж) Я.Баттогтох, Ж.Баярмаа. УБ, 2009
23. “Эмэгтэйчүүд үүнийг хийж чадна” (Норвегийн Хөдөлмөрийн намын Эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөр), НҮБ-ын хүн амын сан, Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо. УБ, 2009
24. “Эмэгтэйчүүдийн нүдээр: Үндэсний аюулгүй байдал”, “Монфемнет” Монголын эмэгтэйчүүдийн ТББ-ын үндэсний сүлжээ. УБ, 2009
25. Д.Мөнхөө. “Хатан ухааныг цэгнэхүй”. УБ, 2009
26. Томас Майер. “Нийгмийн ардчилалын ирээдүй”. УБ, 2009
27. I.Carlsson. “One hundred years in the forefront of gender equality”. Germany, 8 september 2007
28. “Women in Politics: 2008” IPU, situation on 1 January 2008
29. Mongolia. A Public Expenditure and Financial management review. Core report, January 2, 2009
30. UNFPA Mongolia. 15 years after the International Conference on Population and Development. Country review Ulaanbaatar, 2009

ГАРЧИГ

1.	Өмнөх үг	3
2.	Нэг: Нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь	7
3.	Хоёр: Удирдах болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо	20
4.	Гурав: Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагад эмэгтэйчүүдийн оролцоо	27
5.	Дөрөв: Эмэгтэйчүүд ба МАХН	34
5.	Тав: Дэлхийн эмэгтэйчүүд улс төрд	39

Хавсралт 44

6.	Штутгартын тунхаг (2007.09 .08. ХБНГУ Штутгарт)	44
7.	Эмэгтэйчүүдийн квотыг баталгаажуулсан Социнтерний гишүүн улс төрийн намууд	46
8.	МАХН-ын дүрэм	50
9.	Квот-тэгш байдлын түлхүүр	51
10.	Жендэр, жендэрийн тэгш байдлын талаар товч тайлбар	55
11.	Зүүн азийн эмэгтэйчүүдийн ТББ-ын төлөөлөгчдийн VI чуулган 2006.07.18-20, Бээжин хот	57
12.	Социнтерний эмэгтэйчүүдийн байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээ 2007.09.07, ХБНГУ-ын Штутгарт	61
13.	“Сонгууль ба эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт олон улсын чуулган 2008.03.04, Төрийн ордон, Улаанбаатар хот	68
14.	“Хатагтай” клубын цугларалт “2008 оны сонгууль ба эмэгтэйчүүд” 2008.10.31, Бишрэлт зочид буудал, Улаанбаатар хот	73
15.	“Жендэр ба гамшгийн эрсдэлийг бууруулах нь” сэдэвт Олон Улсын хурал. 2009.04.20-22, БНХАУ-ын Бээжин хот	77
16.	Социнтерний гишүүн улс төрийн намуудын болон СИЭ байгууллагуудын зөвлөлдөх хурал 2009.06.26-29, Петровац, Будва хот,Монтенегро	80
17.	ГСДН болон Герман улс дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо 2009.07.08-09,Зуны академи сургалт, МАХН, ХБНГУ-ын Ф.Эбертийн Сан, Улаанбаатар хот.	84
18.	Ашигласан ном, судалгааны материал	90